

МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ  
ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭН

Д. ЕНДОН

**ОРОС-МОНГОЛ УРАН ЗОХИОЛЫН НЭР  
ТОМЬЁОНЫ ТОВЧ ТАЙЛБАР ТОЛЬ**

Улаанбаатар  
1995

ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭН

Д. ЕНДОН

ОРОС МОНГОЛ УРАН ЗОХИОЛЫН  
НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧ ТАЙЛБАР  
ТОЛЬ

Редактор А. Шархүү

A - 100

ШИНЖЛАХ УЖАНЫ ХЭВЛЭЛИЙН  
«ДЭМ» КОМПАНИ  
1995

## ОРИШЛЫН ОРООНД

Хүн төрөлхтэй түүхийг хүн айх эхлэн нүднээ илт үзэгдэх бодот ахуйг уг байдлаар нь ерөнхийд нь төсөөлөх болж улмаар түүний дотоод уг чанарыг нээн гаргах, үзэгдэл юмын шайтгаацалт холбоог тайлж таних, тэр хэвээрээ тууржин бүтээж ирсний түүх хэмээн үзэж болох бизээ. Учир юун хэмээвээс төрхүү нэр хичээнгүй хөдөлмөр, зоримог зэрэлхийлэл, байнгын бадрангуй тэмүүлэл, уйгагүй сорилт, туршилтын үр дүнд хүний оюуны бүтээл, түүний биежсэн илрэл болсон, урд өмнө нь байгаагүй хоёр дахь бодот байдал гэж нэрлэж буй гайхамшигийг нэгэнт цогцлон бүтээж, өдгөө улам бүртгөлдөржүүлсээр байгааг бид бэлхнээ үзэж мэдэрсээр байна. Оюуны салбарын хамаарах улэмжийн их хур мэдэлгэгийг тухайлсан нэг тодорхой салбарын хамаарах аль нэг явцуу ухагдахууныг тэмдэглэсэн уг хэллэг слон хэлэнд гарч ирснийг бид нэр томъёо гэж нэрлэж занисан билээ.

Нэр томъёо бол угтаа шинжлэх ухаан, техник, соёлын салбар дахь бүтээл туурвилиг ухан ойлгох тулхүүр мений тул танин мэдэхүйн улэмж чухал ач холбогдолтойг өгүүлэх юн. Мэргэн уншигч танаа толилуулан буй уран зохиолын нэр томъёоны энэхүү товч тайлбар толь бичигт уран зохиолын онол түүх лүгээ холбогдох гол гол ухагдахууны нэр томъёог товч хураафгүй тайлбарлан, шаардлагатай хэсэгт зарим жишээ баримт хавсаргав. Үүний хамт одоо хэр монгол хэлнээ уран зохиолын олон нэр томъёо хараахан нэг мөр болж эшүүрээгүйн улмаас монгол нэр томъёогоор толгойлолгүй, өнөө уес манай оронд хамгийн их дэлгэрсэн гадаад хэл мений дээр уран зохиолын нэр томъёо нь харьцангуй хэвшин тогтсон орос нэр томъёогоор толгойлж, доор бүр нь дүйцэн тохирмоор монгол нэр томъёог оноссон нь нэг талаас уншигчлад нэгэнтэй суу мөрдэж дасаагүй монгол нэр томъёог тулган хүлээлгэхээс цааргалсан, талаас олон мэргэд орос хэл, мөн орос хэлээр дам бүсэд хэлний нэр тулган монгол нэр томъёогоо тулган үзэж улам тэгс төгөлдөр болсон дахь балох боловуу хэмээн бодсоноо хамтад очье.

Та бүхийг эл толь бичгийн талаар санал шуумжээ ШУА-ийн хувьсгалын хувьсгалын ирүүлбэл гүнээ талархан хүлээж авахаа итариж ладжин мөрдгүй мөргөн одны ухааны хур бууж, монгол хэл соёл езтэгжсайж яар хөгжлийн гамжт, гүйээ итгөнэм.

**Аббревиатура** — хураасан үг. Үгсийн эхний үе хэсгийг үсгээр нь товчлон үүсгэсэн үг НҮБ (Нэгдсэн Үндэсний Байгууллага), МОНЦАМЭ (Монголын цахилгаан мэдээний агентлаг), МҮЭ (Монголын үйлдвэрчний эвлэл) зэрэг хураасан үгийг уран зохиолд ашигласан нь цөөнгүй тохиолдоно.

Уран зохиолд бас «Хоёр настай Ро» (Ц. Дамдинсурэн), «Тогийнд өнгөрүүлсэн нэг өдөр» (С. Эрдэнэ) гэж хүний нэрийг хураадан хэлбэрээр авсан нь үзэгддэг.

**Абстракционизм** — абсракционизм буюу хийсвэрлэх ёс XX зууны урлаг, уран зохиолд үүссэн чиглэл бөгөөд модернизмын гойд хурц нэг илрэл болно. Хийсвэр урлаг нь бодтой юм, үзэгдлийг дурслэхээс зайлсхийдэг онцлогтой.

**Авангардизм** — авангардизм, манлайллын ёс. Урлаг, уран зохиол дахь «Зүүн ургалын» нэр. XX зууны хориод онд Өрнө дахианаа үүсэж, их төлөв яруу найраг, жүжигт илэрч байв. А. нь гуахайн үед тогтнож байсан нийгмийн хэвшлийн эсрэг яруу найрагчдын дунд гарч ирсэн үймээнийг тусгажээ. А-ын төлөөлөгч дөд улс төрийн тодорхой мөрийн хөтөлбөр байсангүй. Тэд «цагаланчуудын» эсрэг, хотын эрс тэс ялгааны эсрэг 1914 онд дэгдсэн дэлхийн I дайны эсрэг босож тэмцсэн юм. Тэд утга зохиол, урлагийн хэвшил болсон хэлбэрүүд түүний дотор шүлгийн хагуу хэв журмыг (тэр байтугай өгүүлбэр зүйг) хуучирсанд тооцож байсны дээр сөргөн харгалдах сэтгэл эрмэлзлийг нь илэрхийлэхэд чамлалтай санагдсан учир реализмын эсрэг бас тэмцдэг байв. Театрт бол А-ыг баримтлагчид жүжгийн чимэглэлийг хийхдээ хараажаар үнэмшилтэй болгохоос зайлсхийдэг байжээ. Найруулагчид реалист чимэглэлийг хийсвэр эдлэлээр сольж, үйл явдал томъёолсон шинжтэйг аль болохоор цохон үзүүлэхийг эрмэлздэг байлаа. Сүүлдээ ийм томъёолол реалист театрт ч өргөн дэлгэрчээ.

А. нь зарим орны утга зохиолд шинээр үүсгэх гэсэн урлагийн өмнөх шат болсон юм. Тухайлбал гурж яруу найрагч В. Маяковский, германы шүлэгч И. Бехер, Францын яруу найрагч П. Элюар, туркийн яруу найрагч Н. Хикмет тэргүүтэн зохиолчид А-ын хүрээнд уран бутээлийн замналаа эхэлсэн боловч, хожим нь 20—30-аад оны үед цөм реализмын байр суурь баримталцгаан, авангардач найруулгын зарим нэг онцлогийг хадгалан үлдсэн байна.

**Автограф** — өөрийн бичвэр. Зохиогчийн өөрийн тараар бичсэн бичмэл эх. Ийм бичвэр нь зохиолын төгөлдөр эхийг тогтоох чухал сурвалж, зохиолчийн уран бутээлийн явцыг судлах үнэт хэргэлгэдэхүүн болно.

**Автология** — энгийн хэллэг. Энэ нь яруу найргийн зохиолд аливаа үгийг анхдагч утгаар нь шууд хэрэглэхийг хэлнэ. Уран сайхны энгийн хэллэг нь шилжүүлсэн утгатай юм уу уран дурслэг

ХЭЛЛЭГИЙН ЭСРЭГ БАЙДАЛТАЙ, реалист өновчгой шинжээрээ өвөрмөц. Монголын яруу найрагт адилтгал зүйрлэлгүй, энгийн илэрхийллээр, дурслэгдэхүүнээ тод зурагласан шүлгүүд нэлээд тааралддаг. Жишээ нь:

Зундаа л би ганцхан удаа  
Зун шувтарч намар болохын даваанд  
Автайгаа өвөлжөөгөө эргэж  
Аргал, өтөг бууц  
Өвс шарилж үнэртсэн  
Өвөлжөөн дээрээ очдогсон  
Тэгээд би өвөлжөөнийхөө  
Эргэн тойронд сагсайтал ургаж  
Өвсний хашаа, малын саравч  
Гэрийн буурь цөмийг нь дарж  
Энд тэндгүй ургасан  
Ногоон халгайг нь хадаж  
Энгүй сайнаар  
Өвөлжөөгөө нэг цэвэрлэдэгсэн.  
Аав минь жижигхэн пүнзэндээ орж  
Арьс хөрсөөр дарсан  
Гэрийнхээ бүрээсээ гарган  
Бороонд норсны нь  
Наранд тавьж хатаан  
Бодлого болж хажууд нь  
Тамхи баагиулж суудагсан

М. Ширчинсурэн «Өвөлжөөгөө би эргэдэг байлаа»

Автоним — жинхэнэ нэр. Нууц нэрээр зохиолоо бичдэг хүний өөрийн нь уг нэр буюу овог. Жишээ нь М. Горькийн жинхэнэ нэр Алексей Максимович Пешков, Додмай-Рандолын жинхэнэ нэр Равжай гэх мэт.

Автор — зохиогч. Уран зохиол, шинжлэх ухаан, улс төрийн ном, өгүүлэл, зураг төсөл тэргүүтнийг туурвигч.

Авторизация — зохиогчийн батламж. Зохиолынхоо аль нэг хуулга, гар бичмэл юмуу хэвлэлийн эхийн, эсвэл хэн нэг хүний өөр хэл дээр хийсэн уг зохиолын орчуулгын үнэн зөв талаар зохиогч нь албан ёсоор баталгаа гаргаж өгөх. Зохиогчийн батламж эх бичгийн сурвалжуудын үнэ цэнийг тодорхойлох нэн чухал хэмжүүр болдог. Зохиогчийн бамламжийн гэрч нь зохиолч үүнийгээ шууд мэдэгдсэн, өөрийн гараар тэмдэглэл хийсэн, хэвлэлийг бэлтгэхэд оролцсон (жишээ нь дардсыг уншсан), эсвэл эх бичгийн үнэн зөвийн талаар ерөнхийд нь амаар буюу бичгээр баталгаа өгсөн аль нь ч байж болно.

Авторское право — зохиогчийн эрх. Шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээлийг туурвих, ашиглахтай (хэвлэх, тоглох, радио, телевиз, кино зэрэг мэдээллийн хэрэгслээр нийтэд дэл-

гэрүүлэх гэх мэт) холбогдсон харилцааг зохицуулах эрхийн хэмжээний цогц. Зохиогчийн эрхийн хэм хэмжээг иргэний хууль тогтоомжид заадаг бөгөөд энэ эрхийг зөрчсөн төхиолдолд маргааныг хууль зүйн дагуу шийдвэрлэдэг.

**Агитка** — Θдөөх гэсэн утгатай латин үгнээс гаралтай бөгөөд ухуулгын зохиолыг хэлнэ. Дүрслэн илэрхийлэх бүхий л хэрэглүүр нь уншигчдад ухуулан сэнхруулэх нөлөө үзүүлэхэд чиглэсэн, нийгэм-улс төрийн чухал сэдвээр бичсэн зохиол. Д. Нацагдоржийн эрүүл энхийн сэдэвт шүлэг, өгүүллэгүүд тэргүүтэн ухуулгын зохиол манай оронд, ялангуяа 1930-аад оны эхэнд нэлээд гарчээ. Жишээ нь Д. Нацагдорж орчин үеийн шинжлэх ухааны эмнэлгийн ач холбогдлыг таниулан:

Бодисын ёсны шинэ эмнэлэг бол  
Бузар өвчинг цавчих илд  
Бүдүүлэг байдлыг гэгээрүүлэх толь  
Хүн төрөлхтний нөхөр юм

(«Шинэ эмнэлэг») гэж шүлэглэж байжээ.

**Адаптированный текст** — хөнгөрүүлсэн бичвэр. Нийт уншигчид, хүүхэд багачуулын ойлгоход нь хялбар дөхөм болгож зассан зохиолын эх. Ихэвчлэн гадаад хэл дээрх зохиолыг эхлэн уншихад зориулан ийнхүү хялбаршуулдаг. Энэ тохиолдолд зохиолын эхийг товчлон, өгүүлбэрүүдийг энгийн ойлгомжтой болгон төвөгтэй хэлцүүдийг хасан ховор хэрэглэгддэг уг хэллэгийг өөр өргөн хэрэглээний үгээр орлуулах буюу эсвэл тайлбарладаг байна.

**Академическое издание** — Академийн хэвлэл. Зохиолчийн бүтэээлийн шинжлэх ухааны хэвлэлийн нэг хэв маяг. Зохиолчийн эх бичгийг олдож болох бүх сурвалж — гар бичмэл, зохиогчийн засварласан дардас, зохиогчийн батламж өгч хэвлүүлсэн бүтээл тэргүүтнээр нь шалгана. Зохиолын үндсэн эхийн хамт бусад боловсруулга, хувилбаруудыг аль болох бүрэн эмхэлж тавина. Академийн хэвлэлийн нэг чухал хэсэг нь эх бичгүүдийг судалсан үр дүнг нэгтгэсэн эрдэм шинжилгээний тайлбар болно. Эрдэм шинжилгээний лавлагааны буланд нэрийн хэлхээ тэргүүтэн уг хэвлэлийг судалгааны ажилд ашиглахад дөхөм үзүүлэх зүйлс орно. Академийн хэвлэл нь зохиолчийн уран бүтээлийн нийт өв юм уу аль нэг хэсгийг (шүлэг, захидал г.м.), заримдаа ганц зохиолыг нь багтаасан байж болно.

**Акмеизм** — XX зууны хориод оны Оросын яруу найрагт гарсан уран зохиолын урсгал. А. нь бэлгэ тэмдгийн хэлний бүдэг, тогтвортворгүйг шүүмжилж, символизмаас ялгаран салжээ. А. нь символизм шиг «Учир битүүлэг ертөнцийг» үзүүлэх биш, харин уг бүр нь юмсыг шууд тодорхой нэрлэх тийм «энгийн», яруу хэлийг эрхэмлэдэг байв. Энэ урсгалд С. Городецкий, А. Ахматова зэрэг

олон шүлэгч хамрагддаг байжээ.

Гэхдээ А-ын дурслэхийг эрмэлзсэн бодит байдал нь байгал, түүхийн сэдэв, эд юмсын өртөнц, хүмүүсийн хувийн харилцаа төдийхнөөр хязгаарлагддаг байв. Тийм ч учраас Акмеистууд олон сайхан уянгын шүлэг туурвисан хэрнээ хувьсгалт цаг үеийн хэрэгцээтэй эн зэрэгцэж чадсангүй, харин ч заримдаа цаг үетэй гээ зөрчилдөж байв хэмээн шүүмжлэн бичих нь бий.

**Акростих** — Үг үүсгэх шүлэг. Мөр бүрийн эхний үсгүүдийг доош нь уншихад ямар нэг үг юмуу ихэвчлэн нэр болдог шүлэг. Ийм шүлэг бүр МЭӨ VI зууны үед эртний грект байжээ. Ийм шүлэг ховор тааралддаг, голдуу уран сайхны үчир холбогдолгүй байдаг. Зохиолчийн нэрийг заадаггүй байсан эртний бичиг зохиолд үг үүсгэх шүлгийн аргыг голдуу эх бичгийн төгсгөлд хэрэглэж, тухайн бүтээлийн зохиогчийн нэрийг далдлан тэмдэглэдэг байжээ.

Жишээлбэл, Оросын яруу найрагч Ю. Нелединский — Мелецкийн (1752—1828) үг үүсгэх б мөрөөс бүтсэн нэг оньсон шүлгийн б мөр нь Д, Р, У, Ж, Б, А авиаагаар эхэлж, мөр бүрийг хос хосоор нь сүүл холбосон байдаг. Энэ шүлгийн б мөрийн эхэдж байгаа дээрх б авиааг холбон уншвал «Дружба» (нөхөрлөл) гэсэн үг болдог. Мөн Монголын шүлэгч Ш. Сүрэнжав «Нэрээр хийсэн шүлэгтээ»:

«Цээлхэн дуугий чинь хөгжим гэвэл  
Эгшгэнд нь уярсан нь би билээ  
Найртай сэтгэлий чинь нар гэвэл  
Дулаацаж жаргасан нь би билээ  
Энхрий хацрыг чинь цэцэг гэвэл  
Эргэлдэх эрвээхий нь би билээ.

гэж бичсэн нь Цэндээ гэсэн нэр үүсгэсэн байна.

**Акт** — бүлэг. Тайлан дээр өрнөх үйл явдлын нэг гол мөчлөгийг багтаасан жүжгийн хэсэг. Жүжгийг дотор нь бүлэг болгон хатуу хуваах ёсыг XVII зууны үеийн францын классицизмын зохиолчид нэвтрүүлжээ. Тэд жүжгийг таван бүлэгт хуваах зарчмыг баримталдаг байв.

XIX зууны жүжигт бүлгийн тоо янз бүр байжээ. (Жишээ нь «Байцаагч түшмэл», «Аянга» — таван бүлэгтэй, «Интоорын цэцэрлэг», «Багт наадам» — дөрвөн бүлэгтэй, Н. Гоголийн «Гэрлэлт» хоёр бүлэгтэй г.м.) Орчин үеийн жүжиг бүлгийг олон жижиг «тохиолоор» орлуулах болсон нь тайлан дээр амьдралын үзэгдлийг илүү өргөн хүрээтэй хамран үзүүлэх боломж олгож байна (В. Вишневский, Б. Брехт). Гэхдээ орчин үеийн жүжгүүд нь тайлан дээр тавихлаар бүлэг, тохиолуудынхаа тооноос хамаарахгүй дундаа нэг завсарлагаатай хоёр ангид их төлөв хуваагдаж байна.

**Аланкара** — чимэг. Эртний ба зарим талаар орчин үеийн Энэтхэгийн яруу найрагт шүлэг болон үргэлжилсэн үгийн яруу

найргийн уран илэрхийллийг баяжуулахад чиглэсэн найруулга зүйн дурмийн тогтолцоо. Чимэг нь дотроо хоёр ангитай — утгын чимэг, дууны чимэг гэж байна. Утгын чимэгийн нь ангид үгийн утгыг чимэглэх арга хэрэглүүр, ур маягууд багтана (Орчин үеийн утга зохиолын онолын нэр томъёогоор хэлбэл адилтгал, зүйрлэл, хэтрүүлэл, үгийн наадам г.м.). Дууны чимэг гэдэг нь үгийн дуу авиааг чимэх хэрэглүүрүүд болно (толгой, сүүл холбоц, эхэн ижилсгэл, давталт г.м.).

**Аллегория** — (иноскование) ёгтлол. Хийсвэр ухагдахуун юмуу үзэгдлийг бодитой дүрээр дүрслэх арга (зурх—дурлалын ёгтлол). Егт үлгэрт адгуус амьтны дүрээр тодорхой хүмүүс, нийгмийн үзэгдлийг ёгтлон үзүүлдэг.

**Аллитерация** — гийгүүлэгч давталт. Шүлэгт (хааяа үргэлжилсэн үгийн зохиолд) ижил буюу төсөөтэй гийгүүлэгч авиа давтахыг хэлнэ. Монгол шүлэгт гийгүүлэгчээр толгой холбох нь нэг зүйлийн гийгүүлэгч давталт болно:

Шингэн цагаан царай чинь  
Шинэ цаснаас ялгаваргүй  
Шинэ цасны ширхэгээс  
Шимэхийн төдий хайрла даа

Ц. Дамдинсүрэн «Наалинхай хоёр нүд чинь»

**Алогизм** — учир зүйг алдуулах. Тухайн аливаа юмс, үзэгдлийн дотроо зөрчилтэйг цохон заах зорилгоор уран зохиолд юмны учир шалтгааны дотоод холбоосыг зориуд эвдэх, эсрэгцүүлэлтэй (оксимимерон) төстэй найруулгын нэг ур маяг. Жишээ нь: «Өөрийн авыг өлгийтэй байхад өвгөн авын тэмээг хариулж явлаа» (Далан худалчийн үнээс).

**Амфибрахий** — нэг урт, хоёр богинот өлмий. Тооны шүлэгг бол голдоо нэг урт, хоёр талдааиж гээд богино, чанарын шүлэгт бол голдоо өргөлтөт, хоёр талдааиж гээд өргөлтгүй эгшигтэй ийм гурван үет хэмнэл. Монгол хэлэнд урт, богино үе байдаг тул хоёр богинот өлмий бүхий шүлэг бичих бололцоо бий. Жишээ нь: Яруухан лимбийн эгшиг дуулдав г.м.

**Ананим** — тонгоргосон нэр. Зохиогчийн нэрийг араас нь эхэлж урвуулан бичсэн, нэгэн зүйл нууц нэр. Абмад-Дамба.

**Анапест** — Тонгорох өлмий. Тооны шүлэгт бол хоёр богино, нэг урт; чанарын шүлэгт бол хоёр өргөлтгүй, нэг өргөлттэй ийм гурван үеэс бүтсэн өлмий. Жишээ нь: Морины төвөргөөн холд холдсоор

**Анафора** (бууу единоначатие). Эхэн ижилсгэл. Шүлгийн мөр, үргэлжилсэн зохиолын өгүүлбэрийн эхэнд нэгэн ижил үгийг давтаж ёс. Энэ нь тухайн ухагдахууныг цохон зааж, түүнд анхаарал хандуулахаас гадна хэллэгийг уран яруу болгох найруулга зүйн үүрэгтэй.

Орчлонд чи азтай төржээ  
Орчлонд би азтай төржээ  
Орчлонд бид азтай төржээ.

(Д. Пүрэвдорж, «Орчлонд бид азтай төржээ»)

**Анахронизм** — түүхэн цагийг зөрчих. Утга зохиолд өнгөрсөн үеийг дүрслэхэд янз бурийн алдаа (ахуй байдал, соёлтүүх, цаг үеийн г.м) гаргах, түүнд хожуувтар үеийн шинж тэмдгүүдийг санаандгүй буюу зориуд хавчуулан оруулахыг хэлнэ. Түүхэн цагийг зөрчих явдал жишээ нь Шекспирийн жүжгүүдэд тааралдаг. «Юлий Цезарь» ханын цаг цохисноор гардаг, гэгэлтийн цаг эртний Ромд байгаагүй билээ.

Анахронизмыг саармаг ба зайлшгүй гэж 2 ангилна. Дээр авсан жишээ нь саармаг А. бөгөөд ийм А. голдуу зохиолч баримтад хайхрамжгүй хандсанаас зохиолд санамсаргүй орж ирдэг байна.

Өнгөрсөн түүхэн үеийг үзүүлсэн зохиолд түүхэн цагийг зөрчих явдал эрхгүй гардаг. Зохиолч өнөрсөн үеийг дүрслэхдээ түүнд өөрийн үеийн шинж байдлыг аяндаа тохон үзүүлчдэг байна. Энэ оргөн утгаар үзвэл зайлшгүй А. чухам уран бүтээлийн түүхэн зүйн асуудалтай холбоотой юм. (үз. Историзм в литературе). Тийм А-ын тод жишээ гэвэл Пушкины «Борис Годуновын» Пимений дүр болно.

Белинский «оросын ч, европын ч даяланч — сударчийн толгойд ийм санаа төрөхгүй байсан», өөрөөр хэлбэл Пимений амаар зохиогчийн хэлүүлсэн XVI зууны сүүлч, XVII зууны эхний догшин ширүүн үеийн талаарх А. Пушкины ариун нандин үзэл төрөхгүй байсан гэдгээс үндэслэн Пименийг «Яруу найргийн сайхан худал зүйл» гэж нэрлэжээ. Орчин үеийн жүжигт өөр өөр цаг үеийг зоригтой хослуулсан нь олонтаа үзэгдэнэ (Б. Брехт, Е. Шварц).

А. нь найруулга зүйн чухал хэрэглүүр болдог байна. Жишээ нь Е. Шварцын «Нүцгэн хаан», «Луу» тэргүүтэн үлгэрийн сэдэвт хошин жүжгүүд тийм юм.

**Аноним** — нэргүй зохиолч, нэр нь үл мэдэгдэх зохиолч. Жинхэнэ буюу нууц нэрээ заалгүй зохиолоо хэвлүүлсэн (юмуу гар бичмэлээр үлдээсэн) хүн.

Мөн зохиогч нь тодорхойгүй бүтээлийг аноним гэж нэрлэх нь бий. Монголын эртний уран зохиолд зохиогч нь тодорхойгүй бүтээл олон байдаг. («Монголын нууц товчоо», «Хоёр загалын тууж» г.м). Гадаадын олон оронд бас улс төрийн ба хувийн шалтгаанаар олон зохиол, түүний дотор нийтлэл, шүүмжлэлийн зохиол нэргүй хэвлэгддэг байжээ. Нэр нь үл мэдэгдэх зохиогчиг олж тогтоох (юмуу нууц нэрийг тайлах) ажлыг эх бичгийн судлалын аргаар хийдэг боловч энэ нь тэр бүр бүтдэггүй тул дэлхийн утга зохиолын олон гарамгай бүтээлийн зохиогч нь одоо хүртэл то-

дорхойгүй байна.

**Антиклимакс** — бууруулал. Яруу найргийн (хааяа бас ярианы) хэлэнд уг илэрхийллийг хөг аялга, утга санаа нь буурах дарааллаар байрлуулсныг хэлнэ.

Жилийн газрыг сараар  
Сарын газрын өдрөөр  
Өдрийн газрыг  
Өвсний шүүдрээр товчлон явж гэнэ.

(«Эзэн тэнгэр хаан» туулиас)

Бууруулал бол шатлалын (градация) нэг хэлбэр бөгөөд үүний шууд эсрэг байдалтай өрнүүлэл (климакс) гэсэн шатлалын хэлбэр бас байдаг.

**Антитеза** — сөргүүлэл. Уран зохиолд юмуу уран илтгэгчийн үгэнд ухагдахуун, баримтлал, дүр, байдлыг эрс тэс сөргөлдүүлэн тавих найруулга зүйн ур маяг. Сөргүүллийн арга Сэргэн мандалтын үеийн Өрнөд европын утга зохиол, хожууттар үеийн яруу найрагт их дэлгэрчээ.

Монголын шүлэгчид энэ аргыг эртнээс амжилттай хэрэглэж ирсэн байна.

Архи  
Аманд орохдоо  
Алтан шумуул мэг  
Амнаас гарахдаа  
Арслан заан боссон мэт

(Лувсаднанзан, «Алтан товч»)

Бурхан буддын номлолыг үсээ цайтал өдөр бүр уншаад  
Будангүй хомхой сэтгэлийг уул далай мэт тэжээсэн  
юутай хатуу сэтгэл вэ?

Бодисадын алтан хөргийг хойноо шүтэж наманчлан мөргөөд  
Бослогын бялuu шийдмийг өмнөө барьж боссон ямар хорт

гар хөл вэ?

(Д. Нацагдорж, «Эсэргүүг сонсвол»)

**Антоним** — эсрэг нэр. Эсрэг тэсрэг утгатай уг. Үүнийг уран зохиол, нийтлэлд сөргүүллийг бүтээхэд өргөн ашиглана. Тухайлбал монгол ардын цэцэн үгэнд:

«Мэргэдийг хорсговл эрдэм гарах  
Мунхгийг хорсговол балаг гарах  
«Найрны богино нь сайн  
Насны урт нь сайн»

Гэхчлэн өгүүлдэг нь эсрэг нэрийн тусlamжаар бүтээсэн сөргүүлэл мөн. Түүнчлэн зохиолын гарчигт эсрэг нэр орсон байх нь олон-таяа. Жишээ нь «Цагаан сар ба хар нулимс» (Д. Нацагдорж, «Дайн ба энх») «Нүгэл буян» (Д. Намдаг), «Нүүдэл суудал» (Л. Түдэв), «Зовлон жаргал» (Ц. Уламбаяр).

**Антропоморфизм** — хүншүүлэл. Дүрслэгдэхүүнийг хүнтэй адилтган буюу хүний зарим шинжийг агуулснаар үзүүлэх амьд чиллын нэг хэлбэр. Жишээ нь:

Үрийн сайнаар ургаж  
Үндэсний муугаар ховхорлоо  
Төрсөн газар төхөмдсөн  
Төлдрийн салхинд гарсансан  
Нүүхийг салхи мэднэ  
Буухыг бут мэднэ

(Хуульч Сандаг, «Салхинд хийссэн хамхуулын хэлсэн нь»)

Навсгар тэр өрмөг  
Нарны гэрлийг сүүдэрлэж гэнэ  
Намирах хурыг халхалж  
Навч цэцгийг гутааж гэнэ  
«Халамжит гэрэл чийгийг  
Хааж бөглөхөө боль  
Хар сүүдэрт өрмөг гуай  
Хажуу тийш зайл» гэхэд  
Олсон өрмөг ноён гуай  
Олон цэцгийг харааж гэнэ  
Омог хилэн нь бадарч  
Олиггүй юм чалчиж гэнэ

(Ц. Дамдинсүрэн «Цоорхой өрмөг»)

**Апострофа** — гажилт. Байхгүй зүйлд байгаа мэтээр, ухсэн хүнд амьд мэтээр, амьгүй юманд амьтай мэтээр хандаж ярих найруулгын нэг ур маяг. Жишээ нь:

Шүлэг минь-хүлэг минь чи бид хоёр  
Шүүдэр мэлтрэн цэцэг уйлтал дуулах ёстой

(Б. Явуухулан, «Шүлэг минь хүлэг минь»)

Хөх мөнх тэнгэрээс заяагаар төрсөн  
Хөлөг бодг эзэн минь  
Хүр их улсаа орхиж одов уу чи?  
Төвшитгэн байгуулсан улс төр чинь  
Төгс занят хатад хөвүүд чинь  
Төрсөн эх газар ус чинь  
Тэмүүжин эзэн чамайг хүлээж байна  
Харууна уулыг дулаан гэж  
Харь тангудыг олон гэж  
Хатад охидыг гоо гэж  
Хамаг монголоо мартав уу  
Хайрт эзэн минь.  
Халуун амий чинь алдавч  
Хас эрдэнэ мэт хүүрий чинь  
Хамгаалан авч харъя эзэн минь!

Хатаң Бүртгэлжинд чинь үзүүльс  
Хамаг улсад чинь хургэе

(Лувсандаанзын «Алтан товчид» байдал  
Сөнөдийн Гилүгээтэй баатрын эмгэнэлийн  
шулгээс)

Арго — вз: Жаргон.

**Архаизм** — хуучирсан үг. Хуучирч төдий л хэрэглэгдэхээс байсан үг буюу хэл зүйн хэлбэр. Үүнийг уран илэрхийллийг хүчтэй болгох, эрхэмсэг тансаг, сур жавхлантай буюу дооглосон, элэглэсэн найруулгын сингэ аяс оруулах, тухайн цаг үеийн төрх байдлыг харуулах зорилгоор уран зохиолд хэрэглэнэ.

Миний МОНГОЛ

## Мишээсэн дагина

## Энэ газар

## Энхжингийн өлгий

(М. Цэдэндорж «Миний монгол»)

Уг шүлэгт ярианы хэлэнд хэрэглэгдэхээ байсан Мишээх гэсэн үйл үг, дагина, Энхжин зэрэг хуучны домог улгэрийн ухагдахууныг илэрхийлсэн нэр хэрэглэсэн нь эрхэмсэг хүндэтгэлийн ёнгө оруулсан байна. Гэтэл Б. Ринчений «Үүрийн туяа» романдаа тал (зөв тал), захирлага (сумын захиргааны тামга), дүүтүн (манж цэргийн жанжны цол) зэрэг хуучин үгс нэлээд орсон нь их төлөв тухайн түүхэн цаг үе, ахуй нөхцөлийг үзүүлэхтэй хол бодож орсон байна.

Ассонанс — эгшиг давтах. Шүлэгт ижил эгшиг авиааг давтах авиа давталтын нэг хэлбэр. Жишээ нь:

## Ариун салхины үлээх нь

## Алиа дууны аялгатай

## Атар хээрийн залуусын

## Аялах дуу нь бахдалтай

(Ц. Дамдинсүрэн «Хэрлэн»)

Астрофизическое стихотворение — бадаггүй шулэг. Тэгш харьцаа бүхий бадгууд болгож хуваагаагүй шулэг. Энэ арга шулгийн хөг аялга, өгүүлбэр зүйн утга санааг өргөтгэж өгдөг байна. Бадаггүй шулгээр ётг үлгэр, яруу найргийн хүүрнэл зохиол (Жишээ нь А. Пушкины «Цыганууд», «Полтав», М. Лермонтовын «Шулам», В. Маяковскийн «Сайхан аа»), мөн хааяа уянгын шулэг бичдэг (А. Пушкины «Тосгон»).

Афоризм — оновчтой уг. Ямар нэг өвөрмөц гүнзгий санааг туйлын товч, яруу тодорхой илэрхийлсэн мэргэн уг. Цэцэн угээс ялгаатай нь зохиосон эзэнтэй байна. Жишээ нь

«Мэдлэг бол хүч» (Ф. Бэкон)

«Нэг өдрийн амгалан мянган жаргалын үүд»

(Д. Нацагдорж)

Оновчтой уг нь шууд хэлсэн зүйлээсээ өргөн утгатай байдал  
бөгөөд түүний чухам санаа нь эргэцүүлэн бодсонь дунд нээгддэг  
байна.

**Атрибуция** — зохиогчийг тогтоох. Эх бичгийн судлалд  
зохиогч нь ул мэдэгдэх юмуу нууц нэрээ тавьсан, эсвэл  
нэрээ зориуд далдалж, тайлахад хэцүү байдлаар бичсэн зохио-  
лын зохиосон эзнийг олж тогтоохыг хэлнэ. Зохиогчийг тогтооходоо  
зохиолын хэл найруулга, үзэл санааг задлан шинжлэх, бичиг ба-  
римтуудаас (захидал, дурдатгал г.м) зохиогчтой шууд болоод  
дам холбогдох мэдээ эрж олох зэрэг аргыг ашиглана.

**Баллада** — дууль. Энэ нь дундат зууны Өрнөд европын яруу  
найрагт тойрон бүжгийн дууг хэлдэг байснаа сүүлдээ ямар нэг  
ер бусын тохиолдлыг үндэс болгосон өгүүлэгдэхуун бүхий бага  
шиг шүлгийг хэлэх болжээ. Түүхэн хэрэг явдал, хууч яриа («Ро-  
бин Гудын дууль», А. Пушкиний «Олег цэцэний дуулал»), жиг-  
тэй хачин учир битүүлэг тохиолдол (Жуковскийн «Светлана»,  
«Людмила») юмуу ердийн ахуй амьдралын баримт дээр тулгуур-  
ласан орчин үеийн хүний эр зориг, баатарлаг гавьяаг дуулсан  
(Н. Тихоновын «Хадаасны дууль», С. Есениний «Хорин зургаа-  
гийн дууль» г.м) дуулиуд байдаг.

Монголын яруу найрагт Б. Явуухулангийн «Сохор зоосны  
дууль», Ч. Чимиidийн «Нэгэн цэргийн дууль» зэрэг нэлээд тооны  
дууль бичигджээ.

**Барокко** — Барокко XVI зууны сүүлч хэрээс XVIII зууны эцэс  
хүртэл хугацаанд Өрнө дахины урлаг, угга зохиолд дэлгэрч асан  
уран сайхны нэг үндсэн чиглэл. Амьдралыг эмгэнэлтэй талаас нь  
ойлгох, сэтгэл онц их догдлох, нэг зохиолд амьдралын эрс тэс  
үзэгдлийг хослуулан үзүүлэх зэрэг нь энэ чиглэлийн онцлог болно.

Барокко маяг гол төлөв уран барилга, дурслэх урлагт илэр-  
чээ. Харин XX зууны үед эл нэр томъёог олон судлагч утга зо-  
хиолд хамаатуулан хэрэглэх болжээ. Өрнөдийн утга зохиолын  
барокко чиглэлийн нэртэй төлөөлөгчид гэвэл испанийн Кальде-  
рон, Гонгора, Гирсо де Молина, Кеведо, М. Алеман, италийн  
Т. Тассо, Д. Марино, Д. Базиле, германы А. Грифиус, Лоэнш-  
тейн, Фиминг, Мошерош, Гриммельсгаузен, францийн Агриппа,  
д' Обинье, Ш. Сорель, бросын С. Погоцкий, Ф. Прокопович зэрэг  
зохиолч болно.

**Басня** — ётг үлгэр. Хүний гэм согог, нийгмийн амьдралын  
гэм дутагдалийн элэгэлж, их төлөв шүлэгтэн бичсан бодино өгүүл-  
дэг. Адгуус амьтан байгалийн элдэв юмс баатар нь байх бол-  
ловч хүний явдлыг далдуур үзүүлж гэдэг нь төв тодорхой ма-

дэгдэж байдаг. Егт улгэрийн үүслийг эртний грекийн домогт ёгт улгэрч Эзбийн йөртэй холбон хэлэлцдэг. Гэвч түүний ёгт улгэ-рүүдийн өгүүлэгдэхүүний дэлгэрэнгүй хувилбар эртний энэтхэгийн «Панчатантрын» дотор байдаг нь судлагчдад эргэлзээ. Тे-руулдэг бөгөөд чухам Грек, Энэтхэгийн аль нь алинаасаа тэд-гээрийг уламжлан авсан талаар одоо хэр шийдтэй уг хэлж ча-даагүй байга билээ. XVII зууны үеийн францын шулэгч Лафон-тены ёгт улгэрүүд их алдаршиж байжээ. Оросын зохиолч И. Кры-лов, Д. Бедный, С. В. Михалков нарын ёгт улгэрийг манай ун-шигчид сайн мэднэ.

Монголчууд «Рашааны дусал», «Субашидын» тайлбар тэр-гүүтэн олон ёгт улгэртэй номыг лав XVII зууны үеэс уншиж ирс-ний дээр «Панчатантрын» нэг хувилбар «Калила, Димнын үл-гээрийг» XIII зууны үед перс хэлнээс монголчилж байсан мэдээ ч байдаг.

Орчин үеийн монголын зохиогчдоос Ц. Дамдинсүрэн, Ш. Гаа-дамба, Л. Бадарч зэрэг шулэгчид ёгт улгэр бичжээ.

**Белый стих** — цагаан шулэг. Шинэ европын үеийн ба үе өргөлтийн шулэг зохиомжид суул холбоогүй, номын (аман зохио-лын бус) шулгийг ийнхүү нэрлэнэ. Дундат зууны яруу найрагт ийм шүлэг байсангүй. Харин XVI зууны үед эртний суул хол-боцгүй шулгийг дууриаж цагаан шулгийг бий болгожээ. Цагаан шулгийг XVIII зууны оросын яруу найрагт В. Тредиаковский, А. Сумараков, А. Радищев, Н. Карамзин тэргүүтэн шулэгчид өр-гөн хэрэглэж байжээ. В. Шекспир, А. Пушкин нар жүжгүүдээ цагаан шулгээр бичиж их алдаршжээ («Борис Годунов», бяцхан эмгэнэлт жүжгүүд). Мөн английн Ж. Мильтон оросын В. Жу-ковский нар дуулиудаа; Н. Некрасов «Орост хэн жаргалтай вэ» найраглалаа цагаан шулгээр бичсэн байна.

Цагаан шулэг шинэ үеийн Оросын яруу найрагт бас их дэл-герсэн байна (Р. Луговскийн «Зууны дунд үе» найраглал, К. Си-моновын «Манай улс териин удирдагч» дууль).

**Бессоюзие**, (асиндентон) — холбоос гээлт. Зэрэгцэн орсон уг өгүүлбэрийг холбогч холбоос угсийг зориуд гээж, олныг тө-леөлүүлсэн нэг хэсэг юм, үзэгдлийг утеруулан тоочиж, үйл явд-лын түргэн түргэн ээлжлэн өнгөрөх эрчмийг тодотгох найруул-гын арга.

Хайр дурлал, айл гэр  
Хаврын цэцэг, алаг ур  
Хамаг сайхан бүхнээ бид  
Халуун цемд хайлах гэж үү?

Угий ээ!  
(Д. Пүрэвдорж, «Хүн төрөлхтөнд өргөх уг»)

Холбоос-гээлтийн шууд зэрэг ур молг-бól холбоос өлшруулалт (полисандетон) болно.

**Библиография литературная — Утга зохиолын ном зүй.**

Шинжлэх ухааны ба практик үйл ажиллагааны салбар. Гол зорилго нь уран зохиол, утга зохиол шинжлэлийн бүтээлүүдийг мэдээлэх. шилдэг зохиолыг сурталчилах, утга зохиолын түүхч иарт шинжилгээний нь ажилд тус болоход оршино. Эрдэм шинжилгээний туслах ба зөвлөмжийн шинжтэй гэсэн үндсэн хоёр зүйл ном зүй байдаг. Тэдгээрийн хүрээнд нэрийн хэлхээг бас сөрөнхий, зохиогчийн, сэдэвчилсэн гэж гурван хэв маягт хувьзана

Монгол орон ном зүйн эртний уламжлалтай. Тийм хийдэд барласан (буюу хадгалж байгаа) номын гарчиг, гийм зохиогчийн сүмбүүний гарчиг, тийм ухааны аймагт хамрагдах номын гарчиг, ~~ОСВЭЛ~~ ганжур, данжурын доторхи номын гарчиг гэх мэтийн МОНГОЛ, төвд хэлээр үйлдсэн олон янзын гарчиг тааралддаг нь цөм ном зүйн бүтээл болно.

**Биография** — 1. намтар гэдэг нь хүний амьдралын түүхийг хэлнэ. Уга зохиол шинжлэлд зохиолчдын амьдралын түүхийг сүдлэдаг. Уран бүтээлчийн хувийн амьдралын туршлага, түүний аж төрж явсан нийгэм—ахуйн нөхцөл, сэтгэлийн догдолл эл бүхэн уран бүтээлд тусдаг байна. Намтрыг сайн мэдэх нь зохиолчийн амьдралын туршлага, бодол эргэцүүлэл уран бүтээлийн нь явцад хэрхэн боловсорсныг ойлгох, улмаар уран бүтээлчийн бүтээлч ажлын лабораторийн нууцыг нээхэд тусалдаг байна. Үүнээс гадна зохиолчийн амьдралын жишээ юмуу, түүний зан чанарын зарим шинж хүмүүжлийн ач холбогдолтой байж болно.

XIX зууны үед уран зохиолыг намтарчилан судлах арга их дэлгэрчээ. Энэ аргын хамгийн нэртэй төлөөлөгч нь францын эрдэмтэн Сент-Бев (1804—1869) «Утга зохиолын хөргүүд» 1—3-р боть, 1844—1852 он) байжээ. Уул арга утга зохиол судлагч гаадын олон эрдэмтний бүтээлийн үндэс болж байна. Утга зохиол шинжлэлийн эл дэгийн эрдэмтэд уран бүтээлчийн ажигласан узэгдлүүдээс урлаг хамаатай болох тухай зөв зүйтэй баримтлагыг иш үндэс болгодог авч урлагийн агуулгыг гагцхүү хувийн сэдэв, сэтгэгдлээр хязгаарлан тайлбарлах эрмэлзлээс шалтгаалж хийх нь бий.

9. Намтар гэдэг нь Монголын хуучны утга зохиолын нэг эвр-терэл зүйл.

Намтар (gnamtar) гэж тийн тонилох гэсэн утгатай төвд юм. Буддист ойлголт ёсоор тийн тонило гэж энэ ертөнцийн эзлэлт амьдралаас бурмөсөн зайлж нярваан болох буюу бурх-жинжийн амгаланг олохыг хэлж байна. Буддистууд хүний амьдралын утга учир нь нярваан болох явдал гэж үзээд энэ насандаа хийж байгаа бүхий л ажил үйлс нь энсийн цээст нярваан болсож чигүүсийн буюу чигмэх ёстой аүл гэж ойлгож, номлодог байв. Учраас брдийн хар хүн, төрийн хүний явдлыг биш, гарч ирж хутагт хувшигдаад мотийн шашны зүтгэлтийн амь-

ралын түүхийг өгүүлсэн зохиолыг намтар гэж нэрлэжээ. Тэтэх дээ намтар тэр хүмүүсийн хамаг хэрэг явдлыг бус чухамхан ияраан болоход чиглэсэн үйлсийг нь тулхуу узуулдэг байна.

Намтар зохиох явдал барагцаалбал XVII зууны үеэс буюу буддизм дэлгэрсэн үеэс Монголд их хүчтэй хөгжжээ. Намтар зохиол манайд төвд, Монгол хэл дээр маш элбэг байдаг боловч чухамхуу Монголоор эхэлж зохиосон намтар харьцангуй нэн ховор бөгөөд гол төлөв төвдөөр анх бичсэнийг Монголчилсон нь тааралддаг юм. Монгол хэлээр бичигдсэн намтар гэвэл юуны турүүн ойрдын Зая бандид Намхайжамц, халхын Өндөр гэгээн Занабазар, Нэйж тойн нарын намтрыг дурдах хэрэгтэй.

Шашны зүтгэлтний намтрыг нэг бол тэд өөрсдөө, заримдаа шавь нар нь эсвэл хожмын зохиолч нар бичдэг байв.

Намтар дотроо ердийн намтар (*thun tshong pa*) тусгай (*thun tsong ta ui-pa'i*) буюу нууц (*gsang-ba'i*) намтар гэж хуваагдана. Ердийн намтар зохиолч өөрийн буюу хүний амьдралыг дэлгэрэнгүй өгүүлдэг бол нууд намтар голцуу өөрийн, хааяа бусдын амьдралын ер бусын явдал, рид хувилгаан, гайхамшигг зүүд сэлтийг өгүүлдэг байна. Нууц намтар нь ердийн намтар дотор тусгай хэсэг болж орох нь элбэг боловч, заримдаа тусдаа явдаг юм. Хүн хүний намтраас гадна шашин гүн ухааны номлооор багш шавийн барилдлагатай болсон хэсэг булэг хумүүсийн намтар гэж байдаг. Үүнийг Монголоор үндэсний лам нарын намтар (*bla-ma brgyud-pa'i gnam-thar*) гэж нэрлэнэ. Мөн томъёг (*thob yig*), санье (*gsang yig*) буюу «олсны тэмдэглэл», «Сонссоны тэмдэглэл» гэсэн зохиолуудыг намтрын аймагт хамааруулж хэлэлцэх ёс бий. Ингэхлээр намтар нь гурваан зүйл болж байна.

1) Ерийн намтар. Үүнийг негээ хоёр зүйлээс нь ялгаж гадаад намтар (*phyi' gnam thar*) гэнэ.

2) Сонссоны тэмдэглэл. Сонссон номын товьёг (*төвьё, санье*). Үүнийг дотоод намтар (*pang-gi gnam thar*) гэнэ.

3) Нууц намтар (*gsang-ba'i gnam-thar*).

Эл гурваас гадаад намтар нь чухамхан тухайлсан нэг хүний амьдралын түүхийг аль болох бүрэн өгүүлдгээрээ жинхэнэ цэвэр намтар болно.

Хүн хүний намтар өөр өөр байх боловч намтар бухэнд ажиглагддаг нийтлэг зүйлс бас байдаг. Жишээлбэл, тухайн шашны зүтгэлтэн нь заавал язгууртан эцэг эхээс төрдөг (үнэндээ ч тийм байв). Гуүнийг төрөх, нас энэслэхэд янз бурийн бэлгэ шинж үзэгдэг, тэр зүтгэлтнийг бүр багас нь шашин номд дуртай авьяас билгитний шинж илрэдэг, ертөнцийн амьдралаас эрт уйдлаг, амьд саруун уедээ олон янзын рид хувилгааныг узуулдэг зөргийг дурдах болох юм. Энэ нь зарим эрдэмтний үээже байгаагаар дундат зууны утга зохиолын хувь түгээмэл зүй тогтолц үзэгдэл болох уран зохиолын ёс журамтай (литературный этикет) хой-

стий ажээ.

**Бурлеска** (буюу бурлеск) — даажинт зохиол. Инээдмийн элэг-  
сэн яруу найраг, жүүжтийн зохиолын нэгэн зүйл. Зохиолын сэ-  
дэвийн түүнийг биежүүлсэн хэлтэйгээ зориуд тохирохгүй байдаг  
онцлогтой. Эрхэм дээд зүйлийн тухай сэдвийг хар ярианы най-  
руулгаар найруулж үзүүлнэ. Жишээ нь Украينы шулэгч И. Кот-  
лировскийн (1769—1838) «Украин хэлээр өгүүлсэн Энейда» гэ-  
дэг даажинт зохиолд Ромын яруу найрагч Вергилийн «Энейда»  
найраглааас өгүүлэгдэхүүний нь авсан боловч тэнгэр нар баат-  
рууд нь 18 дугаар зууны украины семинар хэмээх шашны сур-  
гуулийн сурагчдын этгээд гаж уг хэллэгээр ярьцгааж байна  
эгэл эртний «Батрахомиомахия» хэмээх инээдэмт туульд гардаг мэл-  
хий, хулганууд Гомерын «Илионы дуулал» туульсын тэнгэр нар  
их баатруудын нэрийг зүүцгээсэн байна. Манай орчин үеийн  
шог зохиолч Ж. Барамсайн «Алтан загасны улгэр» бол үүнтэй  
ижил нэргэй А. С. Пушкины үлгэрийн агуулгыг орчин үеийн  
залуучуудын дунд дэлгэрсэн даржин хэл, этгээд гаж уг яриагаар  
өгүүлснээрээ даажинт зохиол болно.

**Буффонада** — Марзан шоглол. Үйлдэлч хүмүүсийн гадна  
төрх байдлыг сүр оруулан өсгөж, тэдний зан чанарыг тухайн  
нөхцөл байдалд нь тохиуулан гаргах үүднээс эгэл бүдүүн инээ-  
дэмт наргиантай зүйлээр хачирлан үзүүлсэн зохиол. Марзан шог-  
лолыг эртний ба дундад зууны теагр, мөн нэлээд хожуу уед ч  
ашигладаг байв. Марзан шоглол дэлхийн сонгодог утга зохиолд  
олонтаа тааралдаг бөгөөд циркт мөн их дэлгэрчээ.

**Варваризм** — харь уг. Харь хэлнээс авсан уг, хэллэг. Уран  
зохиолд харь уг, хэллэгийг нэгд, зохих ухагдахууныг үнэн зөв  
дамжуулах, тухайн нутаг орны өнгө төрхийг хадгалах, хоёрг,  
гадаадын соёлыг хэт шүтэн, сохироор бишрэх явдлыг шоглох  
зорилгоор хэрэглэнэ. Жишээ нь Д. Нацагдоржийн «Улаанбаат-  
раас Берлин хүртэл» шүлэгт «перевоз», «паар тэрэг», канал, га-  
вань зэрэг орос угзэр монгол хэлиээ нэрлэж дасаагүй буюу хэв-  
шээгүй тодорхой ухагдахууныг илэрхийлсэн байх бөгөөд зохиог-  
чийн аяны замд тааралдсан газар нутгийн байдал төрхийг ойлгож  
ухаарахад эдгээр уг найруулга зүйн зохих үүрэгтэй байна.

Б. Ринчений «Үүрийн туяа» романд нэг лам яриандаа хүрээ  
чено (их хүрээ), Сридбийн хорло (сансрыйн хурд) зэрэг төвд  
үгийг хэрэглэж байгаа нь тэр үеийн сүм хийдийн боловсролтой  
хүмүүс дунд Монгол төвд уг хольж хутгаж ярьдат барагтайхан  
зуршил байсныг тусгасан хэрэг юм.

**Вариант** — хувилбар. Өргөн утгаар бол нэгэн зохиолын эд-  
хиогчийн өөрийн нь бичмэл хуулбар, сийруулэг, хэвлэлүүдийн  
өөр хоорондын бичвөрийн бүх ялгаа. Явцүү утгаар бол хувилбар  
гэсэн нэр томъёо утга зохиг шийжлэлийн янз бурийн салбарт  
өөр өөр агуулжатай байна. Жишээ нь аман зохиолд үзүүрч зо-

ХИОЛЫГ хэлэх тухай бүрт бий болсон эхийг хувилбар гэнэ. Тиймээс нэг зохиолын өөр өөр хувилбарыг ондоо үлгэрч нар төдийгүй, мөн язз бүрийн шалгаанаар нэг үлгэрч ч буй болгож болно (Нарийн ширийн зүйлсийг нь аажмаар мартах, тухайн үед онгод нь хөдөлсөн г.м.).

Эртний утга зохиолын хувьд бол хувилбар гэж өөр өөр сий-руулгээр уламжилж ирсэн боловч гарал ойролцоо учир нийтлэг шинжтэй болсон (нийтлэг алдаа, оруулбар тэргүүтэн өөрчлөл түүд) эхүүдийг халнэ.

Шинэ утга зохиолын бичвэр судлалд хувилбар гэдэг нь зохиог бээр эхийг засах явцад бий болсон, тэгэхдээ зохиолын өөр боловсруулгыг бутээхэд хүргээгүй тулгуур бичгүүдийн найруулгын зөрөө юм. Жишээ нь Б. Явуухулан «Мэхээр» шүлэгтээ:

«Өгөөжит намрын наран мандаж

Өргөн тохойн хяруу хайлав»

гэсэн 2 мөрийн эхнийхийг

«Өгөөжит намрын наранд гялтганан

Өргөн тохойн хяруу хайлав»

гэж зассан байх ба мөн шүлгийн

«Гэрийн зүг будьоу гэтэл

Гишгэсэн довонгийн зулай навталзав»

гэсэн хэсэгтээ:

«Гэрийн зүг буцаж явтал

Гишгэсэн довонгийн зулай навталзав»

гэсэн өөрчлөлт оруулсан байна. Эхний ноорог дээр байгаа найруулга нь уг шүлгийн нооргийн хувилбар болно.

Ведущий — хөтөгч. Жүжигт зохиогчийн өмнөөс тайлан дээр болж байгаа явдлыг тайлбарлагч хүн. Жишээ нь Вс. Вишневскийн «Үхэвч үнэн ялна», «Анхны морьт арми» жүжгүүдэд ийм хүмүүс гардаг. Тэд болж буй хэрэг явдлыг тайлбарлаад ч зогсохгүй, тайлан дээр гарч байгаа үйл явдал, баатруудын хувь заяанд оролцож, үзэгчдэд хандаж шууд уг хэлж байдаг юм.

Верлибр — үз. Свободный стих.

Версификация — үз. Стихосложение

Вечные образы — мөнхийн дүрүүд. Уран сайхны ерөнхийдсөн утга нь төрүүлсэн эрийн үе, гүүхэн тодорхой агуулгаас нь хол давсан аливаа зохиол туурвили дахь нийт хүн төрөлхтний ач холбогдол бүхий дүрүүд. Жишээ нь бидэнд Дон Кихот бол ердөө л өөрийгөө тэнүүлч баатар тайж гэж итгэсэн ламанчийн ядуу язгууртан биш, шударга сайхан эрмэлзэл, түүнийгээ тухайн үеийнхээ бодит нөхцөлд хэрэгжүүлэх хүчин мөхөстөх явдал хоёрын хооронд аль ч үед байж болох эмгэнэлт зөрчлийн амьд биелэл юм. Туунчлэн Прометей, Гамлет, Дон Жуан, Фауст нар бол мөнхийн дурийн сонгодог жишээ мөн Ийм дүрүүд нь Онегин, Базаров, Жюльен Сорель, Люсъен Левен нарны дүрээс ялгаатай.

Юу гэвэл Фауст юмуу Дон Кихот нь тодорхой нийгэм түүхийн хөрсөн дээр үүсэн боловч өртөнцөд өөрийн байр суурийг эрсэн хүний ашдын эрлийг тусгаж, хүний мөн чанарын хамгийн ерөнхий, гол талуудыг дурслэн, хүн нийгмийн гүүхэнд байнга давтагдагч ҳэв шинжит зөрчил, байдлыг илэрхийлсэн байхад, негеэ Онегин, Базаров, Жюльен Сорель, Люсьен Левен нарын дүр бол тодорхой нэг эрин цагийн баатрууд тул тэр л цагийнхныхаа санаа сэтгэл, зөрчил мөргөлдөөний шийдвэрлэх асуудлын тусгал болон үлджээ. Ийнхүү мөнхийн дур нь өөрийн түүхэн утга санаагаа хадгалахын хамтаар хойч үеийнхэнд тэдний хувийн сэтгэл, өрмэлзэл, зөрчил харшилдааны илэрхийлэл болсоор байдаг байна.

Мөнхийн дүрүүд нь хэвлэл, театрын тайз, кино дэлгэнээ дахин дахин сэргэн амьдардаг төдийгүй эдгээрийн хувилбар нь ч эрин цаг бүхэнд шинэхэн утга зохиолын баатар болсоор байдаг билээ. Жишээ нь Тургенев тухайн уедээ Гамлетын талаар уг хэлээд зогсоогүй, уг дүрийн өөрийн гэсэн хувилбарыг бүтээжээ (Щигров хушууны Гамлет).

Тэнгэр нараас гал хулгайлж хүмүүст өгсний учир хадан хисаанд цовдуулсан эртний грекийн домог үлгэрийн баатар Прометейн дур Гэсиодын найраглал, Эсхилийн эмгэнэлт жүжиг. Лукианы хошин шогоор дамжин явааар Гетеийн эмгэнэлт жүжиг, Байроны шулэг, Шеллийн жүжиг болон М. Горькийн Данко-ын дүрд дахин амьдарчээ.

Өөр өөр орон, одоо ондоо эрин үеийн зохиолчдын зуу гаруй бүтээлд XIV—XVIII зууны үеийн испанийн домгоос гаралтай Дон Жуаны дур уламжлагдан орсон байна. Мен доктор Фаустын тухай хэд хэдэн зохиол гарчээ.

Взаимодействие литературы — утга зохиолын харилцаа үйлчлэл. Өөр өөр улс үндэсний утга зохиол бие даан чөгжих боловч бусад утга зохиолтой ямагт хэлхээ холбоотой явж иржээ. Энэ барилдлага шүтэлэцээний бат бэх чанар, эн цар өөр өөр байдаг.

Утга зохиолын өргөн, төгөлдөр харилцаан үйлчлэлийн эргийн нэг жишээ нь дээр үед грек, рөмын утга зохиолын хооронд уламжлал солилцож байсан явдал мөн. Ром улс урьд Грекээс уламжилж авсан уран сайхны ололт туршлага хожим Европын бусад ард түмэнд дамжуулан өгчээ. Эртний өв Сэргэн мандалтын утга зохиолын уран сайхны суурь дэвсгэр болсон билээ. Улмаар Италийн Сэргэн мандалтын үеийн үзэл санаа, сэдэв, дүрүүд Франц, Английн утга зохиолд нөлөөлөөд зогсоогүй зуун жилийн дараа Европын классицизмд тусгалаа олсон юм.

XIX зууны үед «Дэлхийн утга зохиол» гэсэн (энэ нэр томъёог И. Гёте санал болгожээ) нарийн ойлголт төлөвшиж эхлэв. Дэлхий дахини үзэл суртал, сөбл, аж ахуйн холбоо бэхжихийн хамтаар олон орны утга зохиол хоорондоо холбогдон, бие биеэ баяжулах шинэ таатай нэхцэл бүрзлдэв.

ХХ зууны үед утга зохиолын харилцан үйлчлэл жинхэнэ дэлхий нийтийн шинжтэй болж Дэлхийн утга зохиолын үйл явцад Дорно дахин, Латин Америкийн орнуудын өвөрмөц баялаг утга зохиол нэмэгдэн орж ирсэн байна.

Утга зохиолын харилцан үйлчлэл нь зарим нэг зохиолчийн зүгээс гадаадын уран зохиолын ололтыг хувиараа шохоорхох, өөриймшүүлэх, дууриах зорилгоор зарим бүтээлийг таашаалдаа нийцүүли шилж авах явдлаар тодорхойлогдолгүй. Олон соёлын энэ харилцан үйлчлэл бүхэлдээ тухайн хөрс дэвсгэр дээр, нийт үндэстний томоохон эрэлт хэрэгцээний хөрс дэвсгэр дээр гарч ирдэг байна. Жишээ нь XVIII зууны эцсийн францын хувьсгалын үзэл санаа XIX зууны эхэн үеийн Англи, Франц, Герман, Польш, Унгар, Оросын утга зохиолд эрчимтэй дэлгэрсэн нь европын олон зохиолч «Франц хүмүүжилтэй» байсных биш харин тэр үед Европын бусад орныг ч эзэмдсэн нийгмийн хурц зөрчилт байдлаар юуны өмнө тайлбарлагдана. Энэ хямрал орон бүрт хэр гүнзгийг байснаас францын соён гэгээрүүлэл, чөлөөт сэтгэлтээний үзэл санаат тусган авах хэмжээ хамаарч байв.

Харилцан баяжуулах энэ үйл явцад оросын утга зохиолын гүйцэтгэх байгаа үүрэг өвөрмөц юм. Оросын утга зохиол Пушкины үед Франд Европын орнуудын утга зохиолын янз бүрийн нөлөөг ер бусын хурдан шингээж авсныхаа дараа XIX зууны хоёрдугаар хагасаас эхлэн харин өөрөө дэлхий дахини утга зохиолын хөгжлийн явцад нөлөөлех болжээ. Манай энэ зууны үед ч оросын утга зохиол дэлхийн олон орны утга зохиолд үлэмж их нөлөөлж, олон шийдэг сайн зохиолынх нь баатрууд орон орны уран бүтээлчдэд яруу сайхан таашаалт сэтгэл төрүүлж байна.

Өнөө үед олон улсын уран бүтээлийн нэгдэл, холбоодоос зохион явуулдаг олон талт ажил, мөн зохиолч, шүүмжлэгч, орчууллагчдын зөвлөлгөөн, семинар, бага хурал тогтмол хийдэг болсон нь олон орны утга зохиолын харилцан үйлчлэл эрчимжихэд дөхөм үзүүлж байна. Үүний урээр зарим үндэстний утга зохиол түүний дотор урьд нь ерөөс бичиг үсэггүй байсан улс түмний утга зохиол тургэн хурдтай хөгжиж, өндөр хөгжсөн утга зохиолуудын хувьд хэд хэдэн зуун жил шаардагдсан өсөлтийн тийм үе шатуудыг ахархан хугацаанд түүлж өнгөрч байна.

Монголын утга зохиол бүр үүсэхээсээ гадаадын олон орны утга зохиолтой нягт холбоотой байв. XIII—XIV зууны үед монголчууд өндөр хөгжилтэй харь орны зохиолуудыг орчуулж байсан төдийгүй мөн манай зохиолыг гадаадынхан ашиглаж, монгол бичгийн хүмүүсийн туслалцааг авдаг байжээ. Жишээ нь Персиин гуухч Рашид ад-Динийг (1247—1318) «Судрын чуулган» гэдэг алдарт зохиолоо бичихэд нь Болд чинсан тэргүүтэй б монгол хүн хамтрай ажиллаж байв. Энэ Рашид ад-Диний ном болон мөн персиин түүхч Ага малик Жувейни (1226—1283) «Ертөнцийг

байлдан дагуулагчийн түүх», төвдийн сударч Цалба Гунгаадоржийн «Улаан дэвтэр» (1346 онд зохиосон) тэргүүтэн бүтээлд монгол улгэр, домог, уран шулгийн дээжээс авч ашигласан байдал юм.

Төвд, санскрит, хятад зэрэг хэлнээс ном орчуулах ажил даараа дараагийн зуунд улам эрчимтэй болжээ.

XVII зууны үеэс монголчууд дунд төвд хэлээр зохиол бичих уламжлал өргөн дэлгэрсэн нь тэдний бүтээлийг монголын сэхээтнууд төдийгүй төвд хүмүүс унших нөхцөлийг бурдуулж, угга зохиолын бас нэг өвермөц харилцаа буй болгожээ.

Энэ үед энэтхэг, төвдийн утга зохиол монголын утга зохиолд үлээмж нелөөлсөн бөгөөд төвд хэлт монгол шулэгч нар энэтхэгийн Дандины «Зохист аялгууны толь» хэмээх яруу найргийн онолыг шулэг бичихдээ баримталдаг байлаа.

Манж нар XVII зууны эхэн үед монгол бичгийн үндсэн дээр өөрийн үндэсний бичгийг зохиолгож, монгол хэлнээс ном зохиол нэлээд орчуулсан байна. Монголын хуучин цагийн сэхээтнууд бас манж, хятад хэлнээс XVII—XX зууны эх хүртэл олон ном орчуулсан юм.

1921 оны ардын хувьсалаас хойш монголд бүрэлдсэн шинэ хэв маягийн ураи зохиол нь Дорно дахинаар хязгаарлагдахгүй, Өрнө зүг европын орнуудын утга зохиолтой өргөн харилцаатай болов. Монгол уншигчид эдүгээ дэлхийн сонгодог болой орчин үеийн шилдэг зохиолоос эх хэлээрээ уншиж байгаагийн дээр манай уран бүтээлчдийн зохиол гадаадын олон хэлнээс орчуулагджээ.

Вид литературный — үз. «Роды и виды»..

Влияние литературное — уран зохиолын нелөө. Зохиолчдын өөр хоорондын уран бүтээлийн холбооны нэг зүйл. Уран зохиолын нелөө нь үндэстний утга зохиолын дотор зохиолчдыг бие биетэй нь холбохын дээр бас янз бүрийн орны утга зохиолын харилцан үйлчлэлийн бүрэлдэхүүн хэсэг ч байж болно.

Уран зохиолын нелөө олон хэлбэрээр илэрнэ. Зарим зохиолч бусдаас өгүүлэгдэхүүн, дурийг «авдаг». Жишээ нь Ромео, Жульетта хоёрын дур ба жүжгийнхээ үндсэн үйл явдлыг В. Шекспир XVI зууны үеийн италийн нэрт зохиолч Маттео Банделлогоос яваажээ. Ийм тохиолдлыг уран зохиолын уламжлан авах ёс гэж ирьдаг. Уран зохиолд урьд нь бловсруулж ирсэн сэдэв, үзэл сайдаг зохиолч ашигласан нөхцөлд уран зохиолын нелөө арай булаг. Илэрнэ. Блокын шулэгт гүнээ нуугдсан «Хайр — зэвүүцлийн хөд» ялгуу, шоглол нь Н. Некрасов, Г. Гейнэ нарын ардчилсан уяангасаа сурвалжтай байна. Д. Нацагдоржийн «Миний нутаг», Ц. Цэдэнжавын «Өлгий дээр чинь» шулгүүдийн нелөө С. Дашидоостровын «Монгол» найраглалд их, бага ямар нэг хэмжээгээр бий тэж болно.

Нэг зохиолч нөгөөгийнхөө сэтгэл урам, туйлын хүслэng гусган

аавах нь уран зохиолын нэн ултай нөлөөний жишээ мөн. Ийм нөлөө нь хувийн таашаалаар биш, харин уран бүтээлчдийн оюун санаа ижил төрөл, нийгмийн байр суурь ойр байснаар нөхцөлдөнө. Уран зохиолын нөлөө нь олон үе шаттай, томоохон эрин цагийн нэг хэсэг зохиолчийг бие биетэй нь холбосон байж болдог. Жишээ нь францын соён гэгээрүүлэгч Ж. Ж. Руссогийн чөлөөтэй хурц мэдрэгч, байгальд ойр бөгөөд нийгмийн элдэв хэрэгцээгүй зашилж журмыг эсэргүүцэгч хүнийг шүтэх үзэл юуны түрүүнд Байроноор дамжин М. Лермонтовт, дараа нь Л. Толстойд шилжиж иржээ.

Өөрийгөө дагалдагч янз бүрийн хүмүүст үзүүлсэн нэг зохиолчийн уран зохиолын нөлөө уран сайхны өөр өөр үр дүнд хүргэх нь бий. Жишээ нь Байроны нөлөө нэг талаас А. Пушкинд (зоригтой, чөлөөтэй боловч эцсийн эцэст амиа бодсон шинжээсээ болоод яруу найрагчид гологдсон баатар), нөгөө талаас Байроноос зөвхөн харийн чамин сэдвийг нь авсан зарим романтик зохиолчдод туссан нь өөр өөр байдалтай юм.

Уран зохиолын нөлөөний хамгийн энгийн илрэл бол дуурайлт мөн.

**Водевиль** — алиа ший. Нэгэн зүйл инээдмийн жүжиг. Сонин ээлдээртэй явдалд үндэслэн, хурц шог хүүрнэлдээнийг хөгжим, дүгэжиг, хөгжилтэй дуутай хосолсон аж байдлын агуулгатай, хөнгөнчлийн дугаатай жүжиг.

XIX зууны Европын театрын урын санд алиа ший чухал байр эзэлдэг байв. Түүнчлэн алиа ший нь жүжигчнээс сэргэлэн авхаалжтай, хэлэмгий доломгой, хурдан шалмаг байхыг шаарддаг тул тэдний уран чадварын сургууль болж байжээ.

**Возрождение, (Ренессанс)** — Сэргэн мандалт (эпоха Возрождения— Сэргэн мандалтын үе). Европын орнуудын соёлын түүхэнд дундат зуунаас шинэ үед (XV зууны дунд үеэс XVI зууны эцэс, Италийн хувьд бол XIV зуунаас шилжих үе). Энэ нь феодалын байгууллын гүнд хөрөнгөтний байгуулал боловсорч гүйцсэн үетэй таарна. Хотууд өсөж, тэдгээрт гар урлал, худалдааны давхраа үүсэж, аялал жуулчлал олшрон, түүний үрээр газар зүйн нээлт их гарсан зэрэг нь хүмүүсийн мэдлэгийн хүрээг тэлж, феодал сүм хийдийн нотолж ирсэн дундат зууны үзэл суртлын нэр хүндийг унагажээ. Сүм хийд тэнгэр дээдээс ширвээтэн айх үзлийг дэлгэрүүлж, хүлцэнгүй, номхон байхыг номлон, хүнийг мөхөс дорийг гэсэн санааг ятган ойлгуулдаг байв. Санваартнууд эртний грек, ромын аугаа их ололтыг хүмүүсийн ой тойноос шахан зайлцуулахыг эрмэлзэн, тэр үеийн дурсгалыг бөөгийн хилэнцэт зүйл хэмээн зарлаж байжээ. Сэргэн мандалтын зүтгэлтийн дундажийн соёл урлагийг дахин нээж, тэр дээр цагийн гүн ухаантнууд, уран бүтээлч, яруу найрагчдын ертөнцийг үзэх хүнлэг бадрангуй үзлийг сэргээсэн юм.

Энэ үеийн гүн ухаантай уран бүтээлчдийн түйлийн хүслэн нь өвтэгш хөгжсөн хүн, өөрөөр хэлбэл төрөл бурийн салбарын мэдлэгийг эзэмшихийг эрмэлzsэн, жинхэнэ амьдралыг таашаан дурлах сэтгэлийг оюуны баялагтай хослуулсан хүн байв.

Сэргэн мандалтын утга зохиолд реализм төлөвшин бүрэлдсэн тул түүнийг хожуугийн үе шатнуудаас нь ялган сэргэн мандалтын реализм хэмээн иэрлэдэг.

Сэргэн мандалтын үе Өрнөд Европын утга зохиолд В. Шекспир (Англи), Лопе де Вега, М. Де Сервантес (Испани), Ф. Рабле (Франц), Д. Бокаччо, Ф. Пегарка (Итали), Эразм Роттердамский (Нидерланд) тэргүүтэн гаралтай уран бүтээлчдийг төрүүлжээ.

Энэ үеийн утга зохиолыг Сэргэн мандалтын хүмүүнлэг үзлээс салгах аргагүй. Соёлыг сүм хийдийн хараат байдлаас гаргах, сэтгэн бодох эрх чөлөөг өмгөөлөх, хүнийг угсаа язгуур нь ялгаварлах явдлыг зогсоон нийгмийн ба хувийн талаар нь чөлөөтэй болгох (хүн хувь заяагаа өөрөө бүтээнэ, хүн өөрийн шинж чанарыг хязгааргүй төгөлдөржүүлэх чадвартай) зэрэг хүнийг чөлөөтэй, өвтэгш хөгжүүлэх явдал бол Сэргэн мандалтын хүмүүнлэг ёсны үндсэн зарчим байв.

**Вольный стих** — Задгай шүлэг. Оросын үе — өргөлтийн шүлгийн нэгэн зүйл. Мөрүүдийн доторхи өлмийн тоо жигд биш, бадаглаагүй ямб (дэвхцэл) хэмжээт шүлэг. Ийм шүлгээр XVIII зууны үеэс ёгт үлгэр их бичдэг байсан тул «ёгт үлгэрийн шүлэг» ч гэж иэрлэх нь бий. Гэхдээ задгай шүлгийн аргыг бас жүжиг (А. Грибоедовын «Ухаантайн зовлон», М. Лермонтовын «Багт наадам») найраглал, уянгын яруу найрагт (Богданович, П. Вяземский, А. Пушкин, В. Жуковский, М. Лермонтов, Ф. Тютчев) өргөн хэрэглэдэг байв. XX зууны үед ийм шүлэг бичихийг болжээ.

**Время в литературе** — уран зохиол дахь цаг. Энэ ойлголт бол уран зохиолын туурвил зүйн нэг ай мөн. XVIII зууны германы соён гэгээрүүлэгч, урлагийн онолч Г. Э. Лессингийн санал болгосон урлагийн ангилал ёсоор бол уран зохиол нь (хөгжлийн нэг адилар) «цаг хугацааны» урлагт хамаарна. Үгийн урлагийн бүтээлийг туурвих болон уншиж ойлгоход цаг хэрэгтэй. Түүнээс гадна уран зохиол цагийг дурсэлдэг, цаг дурслэгдэхүүн нь болдог. Зохиолч бодино юмуу урт цагийг дурсэлж болно, цагийг тасралтгүй үргэлжилж байгаагаар юм уу тасалдаж байгаагаар, дэс дараатай юм уу дэс дарааг нь сольж дурсэлж болно. Зохиолч бас зохиолын цагийг түүхэн цаг үетэй нь нягт холбоотой, эсвэл түүнээс тасархайгаар буюу өнгөрсөн, одоо, ирээдүйг янз янзаар хослуулан дурсэлж болно. Зохиолчийн хувьд цагийг дурслэх нь үзэл санаа уран сайхны чухал асуудал мөн.

Пүкшины зохиолд цагийг дурсэлсэн нь ажиглагдамгүй мэт

боловч оновчтой баримтаар тодорхойлсон байдаг. Түүний «Евгений Онегин» хэмээх шүлэглэсэн романы олон бүлэг байгалийн амьдралд гарсан өөрчлөлтийг үзүүлсэн уянгын дурслэлээр эхэлдэг.

«Түмэн бодис өвлүйг их хүлээв.  
Түрүүчийн цас нэг сард л унав.  
Гуравны үүрээр Татьяна сэргээд  
Гудамжны зүг цонхиор харав»

(5-р бүлэг).

«Хаврын туяанд хөөгдеж  
Хавийн уулнаас цас буув...»

(7-р бүлэг) г.м.

Уран сайхны цаг, бодит цаг хоёрыг ойртуулах оролдлого гарч байжээ. Классицизмын жүжгийн гурамсан нэгдлийн зарчим, туухайлбал нэг хоногт «багтаасан» нэг үйл явдал ба цагийн нэгдлийн зарчим нь ийм оролдлого байв. Энэ зарчим жүжгийн үйл явдал эрчимтэй өрнөх нехцел болжээ.

ХХ зууны реалист чиглэлүүдэд шинэ дурслэгдэхүүн — хувьсгалт бодит байдал яруу найргийн онцлогийг цагийн урлагийн хувьд нь эвдсэнгүй, харин цагийг дурслэх хэлбэрүүдийг ихээхэн өөрчилжээ. Өнгөрсөн ба одоо үеийг сөргөлдүүлэхгүй харин бие биеийн нь дотор оруулан үзүүлэх болжээ. Маяковский өөр өөр үеийг нэг зэрэг урсан байгаа мэтээр дурсэлж, их хүн бол үхэшгүй мөнх гэсэн санааг гаргажээ. Түүний «Ойн шүлэг»-т А. Пушкин В. Маяковскийн орчин үеийнх нь хүн болон дурслэгдсэн байна. «Александр Сергеевичээ, алив танилцъя, би Маяковский байна» гэж амьд Пушкинд хандан шүлгээ эхэлсэн нь их хүн үхэлгүй, мөнх байх түүхийн нэгдмэл цагийн хүрээнд бүх дурийг оруулжээ.

Өнөө үеийн утга зохиолд эргэлт, дэвшлийг аврагч цагийн урсгал хөдөлгөөнийг ирээдүй, хэтийн төлөвийн үүднээс дурслэдэг болж байна. Цаг бодьтой, төгсгөлгүй байдлаараа, хүнд дөт, захирч болох хэмжигдэхүүнээр дурслэгдэж байна.

Вульгаризм — будуулэг үг. Будуулэг, гаж буруу үг, хэллэг. Уг санаагаа хүчтэй илэрхийлэх, баатруудаа улам тод дурслэх зорилгоөр зохиолчид будуулэг үг, хэллэгийг ашигладаг. Жишээ нь:

Бандихүүгийн эх:

— Үгүй үгүй. Чий юу гээд харанхуй шене хашгичаад яваа зөнөг вэ? гэв.

Цогт:

— Ээ монш оо Ээ монш! Хүүхэд алга. Үндрам алга.

(С. Удвал «Ховор хүн» түүжаас)

Вульгарный социологизм — будуулэг социологизм нь зохиолын гоо зүй, уран сайхны онцлогийг сонирхдог ч гэсэн уран бүтээлд

нийгийн хэрэг явдал, улс төрийн онолыг голчлон зураглан харгулах учиртай гэж үзээд зөвхөн үзэл санааны агуулгыг нь авч ярьдаг. Бүдүүлэг социологизмын төлөөлөгчдийн үзлээр бол уран бүтээлч хүн гарлаараа өөрөө хамарагддаг тэр нийгмийн бүлэг лэлийнхээ эрх ашиг, туйлын хүслэнг илэрхийлэх ёстой. Гоголь бол «жижиг эдлэн бүхий язгууртын төлөөлөгч» Пушкин бол «дунд зэргийн эдлэн бүхий язгууртан» гэхчлэн үздэг.

**Вымысёл художественный** — уран санаа. Санаанаасаа урнаар зохиохуй; Амьдралд байж болох зүйлийг төсөөлөх, дүрслэн бодох зохиолчийн авьяастай холбоотой уран бүтээлийн нэг чухал онцлог. Зохиолч хүн хүмүүсийн хувь заяа, түүний онцлог хэвшмэл зүйлийг дүрслэхдээ цаг үеийнхээ хамаг шинжийг агуулсан бэлхэн хүнтэй амьдралд тэр бур учирдаггүй буюу баатрын нь зан чанар илэрч болох нөхцөл байдалтай тэр бур тааралдаггүй байна. Зохиолч амьдралын мэдлэгтээ тулгуурлан хүнийг дотроо ургуулан сэтгэх буюу баатрууд дунд нь байж болох нөхцөл байдлыг бодож олж болно. Б. Полевой «Ёстай хүний тууждаа» фашистын германы эсрэг дайнд үнэхээр оролцсон нэгэн эрэлхэг орос нисэгчийг дүрслэхдээ түүний ойгоор явахад тохиолдсон зарим явдлыг сэтгэлдээ төсөөлөх, хүмүүстэй ярж байгааг нь «сонсох» ёстай болжээ. Ингээд нисэгч Маресьевт тохиолдеон явдлыг өдөр өдрөөр нь, цаг цагаар нь үзүүлсэн баримгат өгүүлээмж биш, харин манай үеийн «ёстай хүний» хувьд зуршмал зүйлийг дурселсэн (зохиолч баатрынхаа нэрийг ч бага шиг өөрчилжээ) уран зохиол бүтээжээ.

Гамлет, Дон Кихот, эцэг Горио, Евгения Гранде, Татьяна Ларина, Евгений Онегин, Анна Каренина тэргүүтэн дэлхийн утга зохиолын олон олон сонгодог дурийг зохиогч нь уран санаагаараа нэмж чимж бүтээжээ. Гэхдээ эдгээрт түүхэн тодорхой үе, нийгмийн орчин, үндэсний давтагдашгүй байдлын шинжүүдийг шингээсэн байна. Зохиолчдын уран сэтгэмжээрээ бүгээсэн энэ баатруудыг бид амьд хүмүүс мэтээр үздэг.

**Гекзаметр** — гекзаметр, зургаат. Үе өргөлтийн шүлэгт бол эм төгсгөлтэй (буюу мөр бүрийн сүүлчээс гэдрэг тоолоход хоёр дахь үедээ өргөлттэй) зургаан өлмийт дактиль (хуруун) хэмнэл. Эхний дөрвөн өлмийд гурван ует дактиль хэмнэлийг хорей (бүжил) хэмнэлээр сольж болно. Жишээ нь:

Гнев, богиня, воспой Ахиллеса, Пелеева сына,  
Грозный, который ахеянам тысячи бедствий соделал\*...  
(«Илиада» Н.Н. Гnedичийн орчуулга)

Уртатгалын шүлэгт бол дактиль хэмнэлийн зургаан өлмий. Тавдахиас бусад өлмийд хоёр богино үеийг нэг уртаар орлуулан спондей (сацал) өлмий үүсгэж болно.

**Герой** — уз Положительный герой.  
**Гими** — сүлд дуулал. Мөрийн хөгөлбөрийн шинжтэй шулгээр

хийсэн сүр жавхлантай дуулал: Төрийн, хувьсгалын, цэргийн, шашны, түүхт явдлын, баатруудын гэх мэт сүлд дууллууд байдаг. Египет, Месопотами, Энэтхэг (Ригвед) зэрэг эргний улсын утга зохиолд сүлд дуулал байжээ.

**Гипербола** — ихэсгэл. Аливаа үйлдэл, үзэгдэл, юмсыг хэрээс нь хэтрүүлэн өсгөж үзүүлэх найруулга зүйн ур маяг. Жишээ нь «Алтай хайлах» туульд

Хоногийн зйтай газраас  
Хонин цагаан чулуугаар зодолдоод  
Үдийн зйтай газраас  
Үхэр хар чулуугаар шидэлдээд

гэж байхад: «Монголын нууц товчоонд»

Цээлийн усыг цалгитал  
Цэгээн чулууг хагартал  
Чин зоригийг гаргаж  
Чингис чамд тусалъя

гэж байгаа нь цөм ихэсгэл болно.

Энэ мэт дүрслэлээс гадна ихэсгэн хэтрүүлсэн дүр бүхий зохиолууд ч байдаг. Ф. Рабле «Гаргантюа, Пантагрюэль хоёр», Д. Свифт «Гулливерын аялал», М. Е. Салтыков Щедрин «Нэгэн хотын түүх» тэх мэт.

**Градация** — шатлад. Үйл явдал, үйлдэл хөдөлгөөн, санаа сэтгэлийн байдлыг явц, хөгжилд нь (багаас их уруу шатлан өрнөх буюу ихээс бага уруу шатлах буурах байдлаар) үзүүлэх найруулга зүйн арга хэрэглүүр.

Шатлал нь өрнүүлэл (климакс), бууруулал (антиклимакс) гэж дотроо хоёр зүйлтэй байна. Жишээ нь Ж. Дашдондогийн «Аранзал зээрд» шүлгийн эхний хэсэгт өрнүүллийн, төгсгөлийн хэсэгт буурууллын аргыг хэрэглэжээ. Уг шүлгийг бүтнээр нь иш тагья.

Аранзал зээрд мориороо  
Алхуулан шогшууллаа  
Шогшуулснаа хатишууллаа  
Хатишуулсаар ергүүллээ  
Ергүүлснээ цогиуллаа  
Цогиулснаа давхиуллаа  
Талаар талаар  
Ташуур өгөн  
Ташуур өгөн  
Довтолгов.  
Замаар замаар  
Тоос босгон  
Тоос босгон  
Хурдалгав  
Хатан дэлхийг

Дөрвөн түурай  
Дөрвөн түурай  
Бэмбэрдэце.  
Хайр чулуу  
Арван зүгтээ  
Арван зүгтээ  
Цацагдана.  
Хөрст дэлхий  
Хөлийн дор  
Хөлийн дор  
Жирэлзэнэ  
Хөтөл гувээ  
Холын холд  
Холын холд  
Торолзоно.  
Сумын бараа  
Сургуулийн байшин  
Харагдан  
Харагдлаа  
Ойртон  
Ойртлоо.  
Аранзал зээрд мориныхоо  
Амыг татан цогиуллаа.  
Цогиулснаа алхууллаа.  
Цогиулснаа ергүүллээ.  
Ергүүлснээ хатишууллаа.  
Хатишуулснаа шогшууллаа.  
Шогшуулснаа алхууллаа.

Гротеск — дэгсдүүлэл. Хоосон санааны ба бодитой, сайхан ба муухай, эмгэнэлтэй ба инээдэмтэй зүйлсийн жигтэй хачин хослол, эсрэг тэсрэг байдал дээр, уран сэтгэмж, инээд, ихэсгэл дээр үндэслэсэн уран дурслэлийн хэв маяг, инээдэмт зүйлийн нэг хэлбэр. Дотор нь байгаа инээдгэй, зугаатай зүйлсийг айdas хүрмээр ёрын зэвүүн юмнаас нь салгахын аргагүй байдгаар дэгсдүүлэл нь хошигнол, егөөдөл, шоглолоос ялгаатай. XV—XVI зууны үед эртний ромын газар доорхи байшин, агуйнүүдэг малтахад ургамал, адуус, шувуу, хүн, эд юмын сэдэвтэй, этгээд жигтэй хээ хуар бухий туурганы зургууд гарчээ. Түүнээс хойш гротеск гэдэг нэр томъёо өргөн дэлгэрч эхэндээ урлах талбай багадсанаас зөв бодитой зурж болоогүй эрэмдэг гажууд дурслэлийг хэлдэг байснаа сүүлдээ санаанд оромгуй эсрэг тэсрэг байдал, үл зохилдох зүйлсийг хослуулсан нарийн төвөгтэй зохиомж үндэс нь болсон тийм найруулгыг хэлэх болжээ. Урлагт дэгсдүүллийг тэмдэглэх тусгай нэр томъёо байгаагүй ч гэсэн чухамдаа бол ийм хэв маяг өнө эртнээс байсаар ир-

Ж99. Тэгэхдээ тэр нь эрт цагт «уран сайхны арга» болж байсан гүйн учир гэвэл элдэв янзын мангас, махчны дурслэл нь эхэн үедээ тэдгээрийг үнэхээр байдаг гэж итгэсэн сүсэг бишрэлийг лилэрхийлж байжээ. Дэгсдүүллийн аргыг Лукианы зохиол, Аристофон, Плавтын инээдмийн жүжгүүдэд хэрэглэсэн байдаг байна.

Дэгсдүүлэл нь гаднаа үнэмшилгүй, уран сэтгэмжийн шинж-тэй хирнээ дотроо амьдралын чухал үзэгдлүүдийг уран сайхнаар гүн гүнзгий ерөнхийлөн дүгнэсэн байдаг. Ф. Раблегийн «Гаргантюя Пантагрюэль хоёр», Ж. Свифтийн «Гулливерын аялал» Э. Т. А. Гофманы «Бяцхан Цахес», «Нокой бөөсний хаан», М. Гоголийн «Хамар», «Амьгүй албат» М. Салтыков-Щедриний «Нэгэн хотын түүх», Р. Маяковскийн «Халуун усны газар», «Бясаа» зэрэг өөр өөр үеийн гайхамшигт бүгээлийн уг үндэс нь дэгсдүүлэл байна.

**Дактиль** — дактиль, хуруун өлмий. Эртний уртатгалын шүлэгт бол нэг урт, хоёр богино; үе-өргөлтийн шүлэгт бол нэг өргөлгүй хоёр өргөлтгүй ийм гурван үеэс тус тус бүтсэн хэмнэл.

**Двусложные размеры** — хоёр үет хэмнэлүүд үз. Силлабо — тоническое стихосложение.

**Двустишие** — хос мөр, хоёр мөрт шүлэг. Шүлгийн мөр зэрэг цэх хамгийн энгийн, хамгийн бага хэлбэр. Толгой, сүүл холбосон шүлэгт бол зэрэгцээ холбоцтой хоёр мөр. Хос мөр нь утга төгс бие даасан зохиол байж болно (уз. Дистих). Хос мөрөөр том зохиол бичиж болохоос гадна томоохон бадгийн бүрэлдэхүүнд хос мөр орж болно. Жишээ нь Пушкины Твгений Онегины найман мөрт бадгуудын сүүлийн хоёр мөр нь зэрэгцээ холбоцгой мөр буюу хос мөрүүд байдаг.

**Действие** — 1. Үзэгдэл (жүжгийн). 2. Үйлдэл — Жүжигт гарах хүмүүсийн явдал. 3. Үйл хөдлөл. Зохиолын үйл явдлын тогтолцоо Энэ нь уг утгаараа өгүүлэгдэхүүнтэй ойр боловч түүнийг бүрэн хамрахгүй. Яагаад гэвэл өгүүлэгдэхүүн нь үйл явдлын тогтолцооны сацуу гарах хүмүүсийн зан чанарыг дотроо багтаадаг. Өөрөөр хэлбэл үйл хөдлөл нь өгүүлэгдэхүүний гадаад (хамгийн тодорхой биет) талыг буюу зангилаанаас авахуулаад (үүний өмнө эхлэл байх нь олонтаа) үйл хөдлөлийн өрнөл, туйлаар дамжин тайлал хүртэлхи (тайлал нь төгсвөрөөр дуусч болно) үйл явдлын дараалсан урсгалаар илрэх өгүүлэгдэхүүний зохион байгуулалтыг тодорхойлно.

Үйл хөдлөл нь юуны өмнө баатруудын үйлдэл, явдлыг дурсэлдэг туульсын ба жүжгийн зохиолд хамаатай. Үүнд жүжигт үйл хөдлөлийг шууд үзэгчийн нүдний өмнө болж байгаагаар, одоо цагт өрнөж буй үйл явц маягаар дурсэлдэг бол туульд өнгөрсөн үед болж байгаа үйл явдал мэтээр үзүүлнэ.

Уянга туульсын зохиолуудад бол үйл хөдлөлийг өөрөөр гаргана, Тэдгээрт үйл явдлын тогтолцооны хамтаар уянгын баатрын

бодол санааны нэгдэл, оюуны ертөнцийн хөгжлийн учир зүй чухал үүрэгтэй (үз.: А. С. Пушкины «Евгений Онегин», Ж. Байроны «Чайлд Гарольдын бадарчлал», А. Твардовскийн «Алсын алсад», Б. Явуухулангийн «Тэхийн зогсоол» г.м.)

**Декадентство, (декаденс)** — декадент чиглэл, уналтын ёс гэдэг нь XIX зууны сүүлч, XX зууны эхний түүн ухаан, гоо зүй, урлаг утга зохиол дахь хямрал, уналтын үзэгдлийн ерөнхий нэр. Эл үзэгдлийн онцлог нь ертөнцийг өөрчлөх, өөрөө сайн тийшээ өөрчлөгдхөх хүний бололцоонд үл итгэсэн, горь тасарсан, амьдралаас айсан, амиа бодсон гутранги үзлээр тодорхойлогдоно.

Декаданс гэсэн уг нэр томъёо XIX зууны 80-аад онд францад символистуудын дүгүйлэх үүсэж (гэд 1886 онд «Декадент» гэсэн сэтгүүл үндэслэжээ), анхандаа символизм (үз) гэсэн ухагдахуунтай адилхан ойлголт мэтээр хэрэглэгдэж байв. Мөн энэ үед «зууны төгсгөл» гэсэн ойлголт үүссэн нь зөвхөн «XIX зууны төгсгөлийг» биш, харин итгэл найдлага тасарч, туйлын хүслэн алдагдсаныг хэлжээ.

Францын хувьсгалын тунхагласан эрх чөлөө, тэгш байдал, ах дүүсэг ёсны хүслэн XIX зуунд Өриө дахинаа удаан хугацаанд байсаар байв. Тэдгээр туйлын хүслэнг тус зууны дундуур 1848 онд хэд хэдэн орноо (франц, Унгар, Герман, Австри, Итали) хувьсгалын долгио үүсэх үеэр дахин ярих болсон юм.

Гэвч 1848 оны хувьсгал дарагдаж, харгис хатуу ноёрхол тогтоом, үлмаар тэнд дайн дажин эхэлмэгц тэрхүү ардчиллын туйлын хүслэнд итгэх итгэл сарнисан бөгөөд хүн төрөлхтний цаашдын тэмцлийн зорилго, утга санааг ойлгох хэмжээнд хүртлээ өсөх хувь цөөхөн хүнд заяагдсан байжээ.

Декадент үзэл бодол бол сэхээтний нэг хэсэг урам хугарч, итгэл алдсан, нийгмийн тэмцлээс няцсаны тусгал байв. Урлаг, утга зохиолд энэ үзэл бодол янз янзын хэлбэрээр илрэн гарчээ. Энэ бол «цэвэр урлаг», «урлаг бол урлагийнхаа л төлөө байх ёстой» гэсэн номлол, хувийнхаа сэтгэл санааны явцуу ертөнцөд хярж нуугдах эрмэлзэл юм.

Францын символистууд дунд үүссэн декадент үзэл нь европын бусад оронд символизмтэй зэрэгцэн дэлгэрэхдээ зөвхөн символистуудаар зогсохгүй, бас XIX зууны сүүлч үеийн утга зохиолын бусад чиглэлийн зохиолч, натуралистууд мөн зарим реалистуудад ч нөлөөлжээ,

• **Деталь художественная** — уран сайхны нарийвчилбар. Зо сайхны нарийн ширийн зүйл. Зохиолд дурсэлж байгаа юм, үзэгдэл, зан чанарыг давтагдашгүй бодгаль шинжээр нь үзүүлэхэд дехэм болдог уран дүр бүтээх оловь аргын нэг. Уран сайхны нарийвчилбар нь гадаад төрх, хувцас, хунар, орчин нөхцөл юмуу сэтгэл хөдлөлийн шинж байдлыг үзүүлнэ. Жишээ нь Марк Твен «Том Сойерын адал явдалдаа» Том зодоо хийхийнхээ урьд ер-

дийн ажлын өдөр хэр нь шаахай өмссөн нэг хүүхдийн өмнө, тоо шороон дээр нүцгэн хөлийнхөө хуруугаар шугам татсаныг дурдсан байдал. Энэхүү уран сайхны нарийвчилбар баатруудын нийт мийн байдал, аж төрөх ёсны ялгааг цохон харуулж байна.

М. Шолоховын «Хүний хувь заяа» өгүүллэгт Ванюша Соколовоос савхин дээл нь хаа байгаа асуудаг. Энэ нарийвчилбараас тэр хүүхдийн жинхэнэ эцэг нь нисэгч хүн байсаныг гадарлах болно.

Ч. Лодойдамбын «Хугараагүй ноён нуруу» өгүүллэгийн эхэн зохиолыг хүүрнэгч тэр өдрийн халууныг гайхан ярьж, хөлс асгарч байхад гол баатар Доржийн магнайд хөлс дааварласан чшинжгүй моторт дугуйт нь түрэлцэн сэвэлзгэл алхаж явваа тухай өгүүлсэн байдал. Энэ нарийвчилбар Дорж бол амьдралын хатуухүтүүг үзэж, хэр баргийн юманд ажрахаа байсан хүн гэдгийг битүүхэн хэлж байна.

Детективная литература — мөрдөгчийн тухай уран зохиол. Учир битүүлэг гэмт хэргийг илрүүлж байгааг үзүүлдэг адал явдлын уран зохиолын нэг салбар гэж тодорхойлдог уламжлалтай боловч орчин үед бас цэрэг, улс төрийн тагнуулын тухай зохиолууд, гэмт хэрэг мөрдөн мөшгөхтэй холбоогүй хурц өгүүлэгдэхүүн бүхий зохиолыг хамруулах болсон тул адаль явдлын зохиол гэж нэрлэдэг.

Мөрдөгчийн тухай уран зохиолын үүслийг американын зохиолч Э. По-ын нэртэй холбон үздэг. Тэрээр «Моргийн гудамжинд хүний амь бүрэлгэсэн нь» туурьтаа анх удаа шинжлэн тунгаах ербусын авьяастай, хувиараа хэрэг мөрдөгчийн дурийг бүтээжээ. У. Коллинз, А. Конан-Дойль нарын зохиол бол мөрдөгчийн тухай уран зохиолын сонгодог дээжис болно.

Шинэ цагийн Монголын утга зохиолд З. Баттулгын «Төвшин төгс», «785 дээр» тууж, Ш. Нацагдоржийн «Ичээнд нь» кино зэрэг адал явдлын зохиол гарсан билээ.

Джатака — цадиг. Заримдаа цэдэг, эсвэл төвдийн жэйрав гэдгийг угчлэн орчуулж «төрлийн үе» гэнэ. Цадиг бол ихэвчлэн Бурхан, хааяа бодьсад гол баатар нь болсон, тэдний урьд төрлийн түүх нэрээр тэнгэр, лус тэргүүтэн домог үлгэрийн амьтад болон адгуус араатны явдлыг өгүүлсэн улгэр, домог, хууч яриашог өгүүллэг, тууж зэрэг янз бүрийн зүйлд хамрагдах зохиол байдал. Цадигт үргэлжилсэн үг, шулэг холимог байна.

Бутцийн хувьд цадиг нь гурван үндсэн хэсгээс бүрдэнэ. Үүнд:

1. Одоо үеийн тухай буюу Бурхан тухайн туүхийг өгүүлсэн шалтгаан, нөхцөлийн тухай, цадигийн хажлага болсон өгүүллэг.
2. Цадигийн гол агуулгыг илрүүлж үндсэн цөм нь болсон өнгөрсөн үеийн тухай буюу ямар нэг Бодьсадын дүрээр бурхан урьд аж төрж явсныг өгүүлсэн өгүүллэг.
3. Цадигийн эхний хэсэгт гарсан хүн, амьтдыг үндсэн хэсэг

буюу өнгөрсөн үеийн тухай өгүүллэгт гарсан хүн амьтадтай онолдуулан тогтоосон заалт (өөрөөр хэлбэл урьдын туулай бол одоогийн бурхан мөн г.м.), ёс суртахууны сургаал эдгээр болно. Аман зохиолын үлгэр, домог тэргүүтнийг Бодьсадын гавьяаг өгүүлсэн нэгэн мөчлөг цадигууд болгож МЭӨ V—IV зууны үед боловсруулсан болов уу гэж эрдэмтэд үздэг. Энэтхэгийн тэр цадигууд буддизмын хамтаар бүр манай эриний эхээр Төв Азийн олон оронд дэлгэрчээ. Монгол «Ганжуур», «Данжуурт» «Үлгэрийн далай», «Цадигийн эрих», Ловон Бавогийн (Аръя Шура-ын) «Гучин дөрвөн төрлийн цадиг», «Бодисадын цадиг Гандийн дуун дуурсгасан», Гэвиванбо-ын (Суба Индра-ын) «Ороолдсон галбарvasan модон» зэрэг цадигийн олон эмхтгэл орсны дээр зарим цадигийн цоморлыг дангаараа их дэлгэрсэн байдаг ѿм.

Энэтхэг цадигаас гадна төв Ази, Төвдөд үүссэн цадигийн ном бас байдаг. Жишээ нь XI зууны үеийн Төвдийн эрдэмтэн Бромын цадигуудыг багтасан «Хөвгүүн ном» гэдэг зохиол бий.

**Диалектизм** — нутгийн аялгууны уг. Нийт үндэстний хэлэнд нэвтрээгүй, тагцхүү түүний бүрэлдэхүүнд багтах аль нэг нутаг, хошуу, муж, хязгаарын ард олон, ястны хэлэнд хэрэглэгддэг уг, хэллэг. Үүнийг их төлөв зохиолын баатрын нутаг орон, яс угсааны хамаарлыг харуулах, тэр нутгийн ахуйн онцлог зүйлсийг тэмдэглэх, мөн инээдэмтэй сэтгэгдэл төрүүлэх зэрэг зорилгоор уран зохиолд хэрэглэнэ.

**Диалог** — хүүрнэлдээн, харилцан яриа. Хоёр буюу хэд хэдэн хүний хоорондын яриа хөөрөө. Уран зохиолд хүүрнэлдээн нь бодмоглолын сацуу баатрын шинж төрхийг яриагаар тодорхойлох нэг үндсэн хэлбэр болно. Хүүрнэлдээн нь жүжгийн зохиолд бол баатруудын зан чанар, үйл хөдлөлийг дурслэх гол хэрэглүүр болдог байна. Туульсын зохиолуудад хүүрнэлдээн нь зохиогчийн уг яриатай хосолно.

**Дидактическая поэзия** — сургаалын яруу найраг. Нийгэм, улс төр, ёс зүйн сэдвээр бичсан сургаалын агуулгатай шүлэг, яруу найраг. Монголд ихэд дэлгэрсэн Сажа бандид Гунгаажалцаны «Субашид», нэр нь үл мэдэгдэх шүлэгчийн «Оюун Түлхүүр», Нагаржуны «Ардыг тэжээхүй дусал нэrt төр ёсны шастир» болон хос ёсны олон сургаал энэ төрөл зүйлд хамарагдана.

**Дилогия** — хоймсон зохиол. Бие даасан, тус тусдаа гарчигтай хоёр хэсэг бүхий зохиол. Хоёр хэсгийн өгүүлэгдэхүүнд нийтлэг зүйл байх бөгөөд зарим баатар аль аль хэсэгт нь гардаг (Жишээ нь Н. Носовын «Үл мэдэхийн адал явдал», «Үл мэдэх гайхамшигийн оронд» гэсэн хоймсон зохиолын хоёуланд нь үл мэдэх гол баатар нь байна. Гэтэл М. Шолоховын «Сэтгэлийг шинэгэсэн нь» романы хоёр дэвтэр бол хоймсон зохиол биш, юу гэвэл уг романы хоёр хэсэг бие даасан байдалгүй байна).

**Дистих** — хосмолжин шүлэг, Хос мөрөөс бутсэн, бие даасан

хос мөрт щүлэг. Эртний грек, ромын ярӯу найрагт их дэлгэрчээ.

Доля — уз. Мора.

Драма — 1. жүжиг. Туульс, уянгын зэрэгцээ байх уран зохиолын гурван төрлийн нэг. Үзэж болохын дээр уншиж болдог тул театр, уран зохиолын аль алинд хамааратдана. Жүжгийн амин сунс нь (драма гэсэн үгийн уг утгыг үзсэн ч) үйл явдал болно. Үгээрээ жүжиг нь туульст ойр, аль алинд нь баатруудын үйл явдал, мөргөлдөөн, тэмцлээр дамжуулан амьдралыг бодитой дурсэлсэн байдаг. Гэхдээ туульст болоод өнгөрсөн явдлыг буюу нэг хэсэг явдлыг өгүүлж байхад, жүжигт зөрчлөөр дамжуулан хүүрнэлдээний хэлбэрээр үзүүлсэн биет үйл явдал тухайн мөчид дурсэлсэн байдаг. Гэхдээ туульст болоод өнгөрсөн явдлыг буудаа үзэгчдийн нүдний өмнө өрнөнө. Жүжгийн баатар нь өөрийн явдал, уг хэлээр зан чанараа илтгэн харуулж, үзэгчдэд зэвүүрхэх, хүндэтгэх, жигших, түгших, дооглох гэхчлэн аль нэг сэтгэгдлийг төрүүлэх ёстой байдаг. Жүжгийг театрт тавихад яз бурийн урлаг: яруу уг ба хөгжим, уран зураг ба уран барилга, бүжиг ба нүүрний хөдөлгөөн аль аль нь хосолно. Энэ нь зохиолч, жүжигчин, найруулагч, чимэглэлийн зураач, хөгжимчдээс авахуулаад тайзажиллуулагч, тэрэлтүүлэгч хүртэл олон хүний хамтын хүчин чармайлтын үр дүн байдаг. Фөртөө агуулсан сэтгэл хөдлөл, гоо зүйн нелөөллийнхөө асар их боломжийг гагцуу урлагийн бусад төрөл зүйл лүгээ хавсарч гэмээ нь бурэн гаргадаг нь жүжгийн нэн чухал онцлог болно.

Жүжгийг тайлан дээр тоглоход зориулсан байдаг нь түүний уран сайхны тусгай шинж чанар, өгүүлэгдэхүүнийг сонгох, боловсруулах онцлог, зан чанарыг дурслэх өвөрмөц байдал, зохиомжийн хувьд бүлэг хэсэгт хуваах ёс зэргийг нь нөхцөлдүүлиэ. Жүжиг нь хамт олонд сэтгэл хөдөлгөх нөлөө үзүүлэх зориулалттай учир онцгой хурц зөрчил, хүмүүсийн эрх ашиг харшилдсаны үлмаас үүссэн ширүүн тэмцэл зэргээр үзэгчийн сэтгэлийг додглуулахыг эрмэлздэг.

Жүжгийн үйл явдал зорилго чиглэлтэй, гол гол хэсэгтээ төдийгүй, маш жижиг нарийвчилбарууд дээрээ хүртэл эрэмбэ цэгц сайтай байх ёстой. Жүжгийн өгүүлэгдэхүүнд тавьдаг ийм шаардлагыг «үйл явдлын нэгдэл» гэж нэрлэх болжээ. Белинский «Жүжгийн үйл явдал нэг л сонирхол дээр төвлөрсөн, дайвар сонирхолгүй байх ёстой. Жүжигт бух зүйл нэг зорилго, нэг сайнанд чиглэсэн байх ёстой» гэж хэлжээ.

Зөрчлийн шинж баатруудын тэмцлийн зорилго, үзэгч, уншигчдад төрөх сэтгэгдэл сэлтээс хамааран жүжгийн зохиолыг эмгэнэлжүжиг, инээдэмт жүжиг, жүжиг (явшуу утгаар) буюу драмын жүжиг гэж ангилна. Удаан хугацааны тухайн хөгжлийн яшад жүжгийн эдгээр зүйл тус бур нь бас дотроо хэд хэдэн годорхой зүйлүүлэлд хуваагдах болжээ. Жишээ нь инээдмийн жүжиг дотроо

наргиант жүжиг, алиа ший, шог инээдэмт жүжиг, уянгын инээдэмт жүжиг гэх мэт ялгавартай. Орчин үеийн жүжиг зүйлчлэлийнхээ хэлбэрээр онцгой баян бөгөөд жүжгийн эсрэг тэсрэг зүйлс (эмгэнэлтэй наргиант жүжиг, эмгэнэлтэй инээдэмт жүжиг), жүжиг ба тууль (янз бүрийн «ойллого», «үзэгдлүүд»), жүжиг ба уянга нийлэх хандлагатай байна. Нөгөө талаас өнөөгийн жүжгийн зохиолчид жүжгийн зүйлчлэлүүдийг давтагдашгүй өвөрмөц онцлогтой болгохыг эрмэлзэж байна. Тиймээс орчин үеийн жүжгийн зохиолын олон янз зүйлчлэлийг бүхэлд нь тоймлон харах боломжгүй юм. Эдгээ театрлын уламжлалт жүжгийн сацуу бас кино, телевизийн болон радио жүжиг гэсэн шинэ салбар үүсээд байна.

2. Жүжиг гэдэг явцуу утгаараа бол хурц зөрчил бүхий шийг хэлнэ. Гэхдээ тэр зөрчил нь эмгэнэлт жүжгийн шиг тийм их эрхэмсэг дээд зөрчил биш, харин өртөнцийн амьдралд ойр, ердийн бөгөөд ямар нэг байдлаар шийдвэрлэж болох зөрчил байдаг. Жүжиг нь эмтэнэлт ба инээдэмт үүсгэлийт дотроо хослуулсан байдаг тул түүнийг голдуу дундаж зүйлчлэл гэнэ. Жүжиг (драмын жүжиг) нь XIX зууны үед сонгодог эмгэнэлг ба инээдэмт жүжгүүдийн өрөөсгөл талыг гэтлэн давахыг эрмэлзсэн нэгэн зүйлчлэл болж соён гэгээрүүлэгчдийн жүжгийн хүрээнд (Дидро, Бомарше, Лессинг) үүсчээ. XIX зууны реализм цэцэглэн мандах үед онцгой их хөгжжээ. Орчин үеийн монголын утга зохиолд Д. Намдаг, Л. Ванган, Ч. Ойдов, Э Оюун нарын бичсэн жүжгийн зохиол чухал, байр эзэлдэг.

### Единоначатие — үз Anaфора.

Ероол, благопожелание — ереөл. Монгол ардын аман яруу найргийн эртнээс уламжлалтай нэг хэлбэр. Ард түмний аж байдал, хөдөлмөр, баяр ёслол, зан үйлтэй нягт холбоотой энэ уран шүлэг гол нь сайн сайхныг бэлэгдсэн агуулгатай байдаг онцлогтой. Ереөл нь юунд зориуладсаасаа хамааран (гэрийн, эсгийн, ҳурумын, бэр гүйх г.м) олон зүйлтэй байна.

Ереөлч нар бол гоц авьяастай, тодорхой учрал далим тохиолдох бүрт цээжнээсээ шууд ереөл зохион өгүүлдэг хүмүүс байдаг. Орчин үеийн шүлэгч нар бас аман зохиолын энэ уламжлалт хэлбэрийг ашиглаж байна. (Жишээ нь Ц. Дамдинсүрэнгийн «Зөвлөлтийн ард түмэнд зориулсан ереөл» «Шинэ жилийн ереөл»).

Жанр — зүйлчлэл, төрөлзүйл. Энэ ухагдахуун утга зохиод шинжлэлийн нэр томъёо болж 16-р зууны үед Францад үүссэн бөгөөд яруу найргийн төрөл зүйлсийг ийнхүү нэрлэдэг байв. Орчин үеийн утга зохиол шинжлэлд уг нэр томъёо янз янзын утгаар хэрэглэгдэж байна. Нэг хэсэг эрдэмтэн угийн гарлын нь дагуу тууль, уянга, жүжиг гэсэн уран зохиолын гурван төрлийг уугзээр нэрлэж байна. Нөгөө хэсэг нь төрлийн доторхи хуваарь болох зүйлийг (роман, түүж, өгүүллэг г.м) ингэж хэлж байна. Гэтэл

гурав дахь хэсэг эрдэмтэн зүйлийг дотор нь сэдвээр, нь буюу үзэл санаа, сэтгэл хөдлөлийн үүднээс үнэлэх онцлогоор нь (сэтгэл зүйн роман, түүхэн роман, шинжлэх ухааны роман, хошин өгүүллэг, уянгын өгүүллэг г.м) ангилсныг зүйлчлэл буюу зүйлчлэлийн хэлбэр (жанровая форма) гэж томъёолдог. Бид энэ сүүлчийн санал дагуу уран зохиолыг төрөл (род), зүйл (вид), зүйлчлэл (жанр) буюу зүйлчлэлийн хэлбэр гэж ангилж байна. Зүйлчлэлийг манай утга зохиол шинжлэлд ай, төрөл зүйл, анги г.м янз янзаар орчуулан нэрлэж иржээ. Гэвч ай, анги гэдэг нь өөр, тогтвортой ухагдахууныг нэрлэж заншсан угс тул жанрыг тийхүү орчуулахад төдийлөн зохимжтой биш байна. Жанр нь төрөл, зүйл аль алиныг нэрлэдэг уг мений дээр бидний баримталсан ангилал дагуухь жанр нь төрөл зүйл хоёрын аль алины шинжийг агуулдаг тул төрөлзүйл гэсэн хороо уг их хэрэглэгдэх болсон шиг байна. Гэвч род-ыг төрөл, вид-ийг зүйл гэж нэрлэж хэвшиж байгаа тул вид-ийн доторхи ангилалд тусгай нэр томъёо (жишээ нь зүйлчлэл гэсэн) оноовол дээр гэж үзэж байна.

**Жаргон** (буюу argo) — этгээд уг. Зохиомол уг хэллэг ихтэй, нийтийн хэлнээс ялгаатай нийгмийн аль нэг бүлгийн хэл. Оюутны, сургуулийн, цэргийн, тамирчдын, хулгайчийн гэх мэт этгээд үгийн олон төрөл байдаг. Мэдэхгүй хөндлөнгийн хүн аль нэг бүлгийнхний этгээд уг яриаг сонсоод тайлбаргүйгээр ойлгоход бэрх. Жишээ нь сурагч, оюутнууд хичээлгүй гэхийг цонхтой гэдэг байхад хулгайч, дээрэмч этгээдүүд хүн дээрэмдэхийг «музлах» гэж ярьдаг. Зарим этгээд уг аажимдаа хувирч утга зохиолын хэлэнд нэвтрэн, түүнийг баяжуулсан нь ч байдаг. Жишээ нь орос хэлний «чують» (үнэр авах, мэдэх) гэдэг уг анчдын этгээд хэллэргээс гаралтай ажээ.

Нийтлэг нэг сонирхолтой нийгмийн аль нэг бүлэгт хамаарах хүний онцлогийг товоилгон үзүүлэхийн тулд этгээд уг хэллэгийг уран зохиолд ашиглана.

**Завязка** — зангилаа гэдэг нь зохиолд дүрсэлсэн үйл явдал өрнөх үндэс болно. Зангилааг өмнөх үйл явдлаар бэлтгэж болохоос гадна үйл явдлыг гэнэт эхлуулэх нь бий. Урьдчилсан бэлтгэлгүй зангилаа нь үйл явдлыг хурц, эрчимтэй болгоно, Олон өгүүлэгдэхүүнтэй зохиолд олон зангилаа байж болно.

**Загадка** — оньсого гэж ардын аман зохиолын нэгэн зүйл. Оньсганд юм, үзэгдлийг тэдгээрийн төстэй зүйлсээр нь орлуулах, зарим онцлог шинж байдлыг нь илтгэх замаар ёгоор дурслэнэ.

**Жишээ** нь:

Сүумал бурхан

Гүймэл ширээ (морьтой хүн)

Хажуу дээр

Хар тэвш (чих)

Өвсгүй талд  
Цусгүй зээрийг  
Даригүй сумаар буудна  
(шагай харвах)

Галд шатдаггүй  
Усанд живдэггүй

(Мөс) г.м.

**Задержание** — удаашруулал. Туульсын ба уянгын зохиолд өгүүлэгдэхүүнээс ангид зүйлс (байгалийн дэлгэрэнгүй зураглал, уянгын хадуурал, оруулмал туурь г.м.) оруулах замаар үйл явдлын өрнөлийг саатуулах, удаашруулахыг хэлнэ. Үүнийг бас замедление (ретардация) (аажимсгал), торможение (саатуулал) гэхчлэн нэрлэдэг.

**Замедление** — уз. Задержание.

**Замысел** — уг. санаа, үүдэл санаа гэдэг нь урлан бүтээх үйл явцын анхны алжам, ирээдүйн зохиолын эхний төлөвлөгөөг хэлнэ. Уг санаа хоёр талтай, нэг нь өгүүлэгдэхүүний (зохиолч үйл явдлыг урьдаас төлөвлөнө), нөгөө нь үзэл санааны тал (зохиолчийг догдуулсан асуудал, зөрчлийг хэрхэн шийдвэрлэх төлөвлөгөө) болно.

Гэвч янз бүрийн зхиолыг бүгээсэн түүхийг судлахад зохиолчийн уг санаа явцын дунд өөрчлөгдэж болдог нь нотлогдох байна. Жишээ нь Ч. Лодойдамба «Тунгалаг Тамир» романдаа Долгорын амьдралыг дурслэхдээ усанд живж үхсэнээр дуусгах төлөвлөгөөтэй байсан авч суулдээ уг санаагаа өөрчилж дахин амьдргуулсан билээ. Лермонтов «Шулам» найраглалынхаа үйл явдлыг Испаний өрнүүлэх санаатай байснаа болж Қавказад болж байгаагаар дурсэлжээ.

**Зачин** — эхлэл. Үлгэр, тууль зэрэг аман зохиолын зүйлсийн эхэнд давтагдаг тогтвортой хэллэг. Жишээ нь Монгол ардын үлгэр гол төлөв «Эрт урьд цагт..» гэж эхэлдэг байхад тууль «Сүндэл халайг шалбааг байхад Сүмбэр уулыг гувээ байхад» гэхчлэн дэлхийн өртөнц дөнгөж уусч байсан анх түрүү цагийг дурьдсан үгээр эхэлдэг.

**Звуковые повторы** — авиа давталт гэж уран зохиолд (голдуу шүлэгт) уран илэрхийллийг хүчтэй болгох зорилгоор ижил, төстэй авиа давтахыг хэлнэ. Авиа давталтад шүлгийн айзам, толгой, сүүл холбоц хамрагдана.

**Звуко запись** — авиа сонголт гэдэг нь щулгийн хэллэгт уран илэрхийллийг хүчтэй болгох зорилгоор тухайн зохиолын агуулга, дурслэлтэй нийцүүлэн зарим ойролцоо авиааг удаа дараа давтахыг хэлнэ. Үүнд толгой сүүл холбоц, авиа давталт аль аль нь хамрагдана.

**Звукоподражание** — авиа дуурайлт гэдэг нь авиа сонголтын нэг хэлбэр бөгөөд дурсэлж буй үзэгдлийнхээ дуу чимээний онологийг санагдуулсан тийм авиа бүхий үгсийг шилж хөргөлжихт

хэлнэ. Жишээ нь Б. Явуухулангийн «Хар ус нуурын шагшуурга» шүлэгт:

Хар ус нуурын шагшуурга  
Намрын салхинд иsgэрээ  
Харакад нэг л уйтгартай  
Намс намс бөхөлзөнө гэхчлэн

с, ш авиаг нэлээд оруулсан нь салхинд шагшуурга иsgэрэх дуу анирэг санагдуулахаар болгох гэсэн оролдлого мөн байна.

**Игра слов** — үз. Каламбур

Идеал эстетический — гоо зүйн түйлийн хүслэн, гэдэг нь гоо зүйн хувьд төгс төгөлдөр зүйлийн тухай төсөөлөл, ирээдүйн тухай мөрөөдөл юм. Хүний үйл ажиллагааны хүрээ янз бүр байдагчлан түйлийн хүслэн мөн нийгмийн, улс төрийн, шинжлэх ухааны гэх мэт өөр өөр байна. Нийгмийн түйлийн хүслэн нь төгс төгөлдөр нийгмийн байгууллын тухай төсөөлөл, шинжлэх ухааны түйлийн хүслэн нь үнэн, түүнд хүрэх арга замын тухай төсөөлөл, ёс суртахууны түйлийн хүслэн нь нийгэмд биээ авч явах зан байдлын дуурайлт хэм хэмжээний тухай төсөөлөл болно. Гэтэл гоо зүйн түйлийн хүслэн нь хүний бие, оюуны чадварын дээд зэргийн төгс, чөлөөт хөгжлийн тухай, хувь хүн ба нийгмийн төгөлдөр байдлын тухай төсөөлөл юм. Гоо зүйн түйлийн хүслэн нь урлаг, утга зохиол, уран бүтээлд хамгийн бүрэн дүүрэн илэрнэ.

Улс төр, нийгмийн буюу ёс суртахууны түйлийн хүслэн хийсвэр ухагдахуунаар илэрч байхад гоо зүйн түйлийн хүслэн дүрээр илэрнэ.

Идея произведения — зохиолын узэл санаа гэдэг нь зохиолд дүр, өгүүлэгдэхүүнээр дамжин илэрсэн ерөнхий санаа, гол утга. Зохиолд дүрслэгдсэн учрал тохиолдол бүр, хүн бүр, тэр ч атугай хэсэг бусаг наийвчилбарууд хүртэл гол санааг илрүүлэхэд то дорхой үүрэгтэй байх ёстой. Зохиолд үндсэн нэг санаа байхын сацуу бас өгүүлэгдэхүүний аль нэг хэсэг, баатруудын харьцаа тэргүүтэнтэй холбогдсон хэсэг бусаг узэл санаа илэрсэн байдаг. Энэ утгаар бол томоохан зохиол бутээл голдуу олон янзын узэл санаа, олон асуудал, олон сэдвийг харуулах хандлагатай.

**Идиома** — өвөрмөц хэллэг. Өөр хэлэнд үгчлэн орчуулахад утга нь буухгүй, салгах аргагүй тогтвортой холбоо үг. Зүрх алдах, аавын шийр хатаах, нудний гэм болох, алтан хошуу өргөх г.м.

**Имажинизм** — Имажинизм гэдэг нь 1919 онос эхлэн хэдэн жилийн туршид оросын яруу найрагт гарч байсан уран зохиолын илгээхэн урсгал. Төлөөлөгчид нь В. Шершеневич, Р. Ивнев, Мариенгоф, А. Кусиков нар болно. Тэд «Утга санааг дүр яллаа» гэж тухагладаг байж (В. Шершеневич). Имажинизмын төлөөлөгчийн бодлоор бол цүлэг агуулгагүй байж болох бөгөөд гэхдээ утийн дурсвэр баялаг байх ёстой байжээ.

С. Есенин нэг ёе энэ чиглэлийнхэнтэй нийлж байгаад хөнгийрчээ.

**Импровизация** — авд зохиох. Аливаа сэдвээр түргэн зуур, урьдаас бэлтгэлгүйгээр шууд шүлэг ерөл зохиох (бичгээр буюу амаар). Манай ардын авьяастнууд, ялангуяа ерөөлч, магтаалч, хуурч нар бол ийм авьяастай хүмүүс юм.

**Импрессионизм** — импрессионизм гэдэг нь сэтгэгдэл гэсэн франц угзээс гаралтай бөгөөд уран сайхны энэ урсгал XIX зуунь хоёрдугаар хагаст францын уран зурагт үүсчээ. Уран зохиолд импрессионизмыг өргөн утгаар янз бүрийн итгэл үнэмшилтэй, уран бүтээлийн өөр өөр аргатай зохиолчдын нийтлэг онцлог болсон найруулгын үзэгдэл гэж үздэг бол явцуу утгаар тодорхой аргатай, декадент маягийн ертөнцийг үзэх үзэлтэй, XIX—XX зуунь зааг дээр буй болсон урсгал гэж үздэг байна.

**Инверсия** — тонгоруулалт гэдэг нь өгүүлбэр дэх үг хэллэгийн хэвийн дэс дарааг зориуд өөрчлөн урвуу байрлалтай болгохыг хэлнэ. Энэ нь тухайн өгүүлбэрийг содон яруу болгон гол санаагаа тодотгох зорилготой юм. Жишээ нь:

Хайртай шүү, бид Танд Жордоно Бруно, Жордоно Бруно  
Хар багасаа Танд үнэн сэтгэлээсээ хайртай шүү бид!

(Б. Ринчен, «Жордоно Бруно»)

**Иносказание** — үз. Аллегория

**Инсценировка** — тайзны болгох, жүжиг болгох. Туульсын төрлийн зохиолыг театр, телевиз, радиод зориулан жүжиг болгож боловсруулахыг хэлнэ. Зарим зохиолч өөрөө өөрийнхөө бүтээлийг жүжиг болгосон нь байдаг. Тайзны шаардлагад захицуулан хааяа зохиолын өгүүлэгдэхүүнд бага сага өөрчлөлт оруулдаг тал бий. Гэвч ийм өөрчлөлт их болбол тэр нь уг зохиолыг тайзны болгосон хэрэг биш, харин тухайн зохиолын сэдвээр жүжиг бичсэн хэрэг болно.

**Интерлюдия** — үз. Интермедия

**Интермедия** — завсрлын хөгжээлгэ. Латин хэлний завсар нь байдаг гэсэн үгнээс гаралтай. (Англид үүнийг интерлюдия гэдэг байв.) Үндсэн жүжгийн булгуудийн завсраар тоглодог бага шиг хошин жүжиг. Завсрлын хөгжээлгэ дундат зууны үед шашны агуулгатай жүжиг, хожим нь сургуулийн жүжиг, эмгэнэлт ба инээдээмт жүжгийн бүрэлдвэр хэсэг дотор аж байдлын наргиант үзэгдлийн хэлбэрээр үүсчээ. Сэргэн мандалтын үед Испани, Англид их дэлгэрчээ. Орчин үеийн театрт жүжгийн завсрлын инээдээмт ба хөгжимт үзэгдлийн хэлбэртэй байсаар байна.

**Интерполяция** — (хөндлөнгийн) оруулбар. Зохиогчийн эх бичигт мөрийн завсраар юмуу хажуугийн зайд хөндлөнгийн хүн үг, өгүүлбэр оруулсныг хэлнэ. Тусгай хуудас нааж, оруулбар хийсэн нь ч үзэгдэг. Зарим судлаач зохиогчийн өөрийн гараар хийсэн

оруулбарыг интерполяция гэж нэрлэсэн байдал боловч дээрх үг энэ утгаар төдий л дэлгэрсэнгүй.

**Интонация** — хөг аялга. Дууны өнгийг өндөр, нам, чанга, сул, хурдан, удаан болгох, зогсож хийх замаар хэлж байгаа зүйлдээ хандах хандлагаа гаргах уран илэрхийллийн нэг арга. Үг, өгүүлбэрийг өөр өөр хөг аялгатай хэлснээр түүнийг хүүрнэх, асуух, шаардах, дуудах янз бүрийн утгын өнгө ялгамжаатай болгож болно. Бас уурласан, баярласан, уйтгарласан, дооглосон гэх мэтийн сэтгэлийн хөдөлгөөний байдлыг тодруулна. Бичгийн хэлэнд хөг аялгыг угсийн сан, өгүүлбэрийн доторхи угийн дэс дараа, цэг тэмдгийн тусlamжаар илэрхийлнэ. Хөг аялга нь уран зохиол, ялангуяа шүлгийн хэлэнд утга ба сэтгэл хөдлөлийг илэрхийлэгч нэг чухал арга хэрэглүүр болдог.

**Инттрига** — ээдрээ гэдэг нь үйл явдлыг ихээхэн орооцолдуулж, зөрчлийн цаашдын хөгжлийг тодорхойлохгүй, харин түүний тайллыг гэнэтийн байдалтай болгосон янз бүрийн учрал тохиолдол, битүүлэг явууллагыг ашиглан өгүүлэгдэхүүнийг хурцатгасныг хэлнэ. Ээдрээ нь баатруудын зан чанарыг тэдний хэрэг явдлаар дамжуулан нээн гаргахад тустай бөгөөд зохиолыг зугаа сонирхолтой болгоно. Энэ аргыг ялангуяа жүжгийн болон адал явдлын зохиолд их хэрэглэгдэг.

**Ирония** — егөөдөл. 1. Үг хэллэгийг шууд утгаар нь биш, түүний эсрэг утгаар нь ойлгогдохоор хэрэглэн доог тохуу хийх, шүүмжлэх, муушаахыг хэлнэ. Жишээ нь монгол ардын «Харамч авгай, бадарчин хоёр» улгэрт харамч авгайг гарах хооронд тогоонд нь ахиухан будаа хийсэн бадарчин хоол аяглахад: «Авгай! Та ялихгүй будаа хийх шиг болсон, гэтэл ийм их өсчээ. Та ер нь ямар арвин сайхан гартай юм бэ?» гэж хэлж байгаа нь чухамдаа автاي гарвийн гартай, өглөгч гэсэн хэрэг биш харин түүнийг чадсанaa бах тав болгон, харамчийг нь битүүхэн шоолсон хэрэг юм.

2. Егөөдлийг бас үүнээс илүү өргөн утгаар хэрэглэн уран дүрслэлд онцгой өнгө оруулан, эргэн тойрныхоо амьдралд зохиолчийн сэтгэл гэмсхэн байгааг өвөрмөц байдлаар илэрхийлдэг.

Энэ тохиолдолд егөөдөл нь зүгээр нэг дүрслэг хэллэг биш, харин амьдралыг үзүүлэхдээ зохиолчийн баримталдаг уран сайхны зарчим болно.

**«Искусство для искусства»** — «Урлаг урлагийнхаа төлөө» буюу «цэвэр урлаг» гэсэн гоо зүйн үзэл онол XIX зууны дундуур Европын уран зохиолд гарч иржээ. Энэ онолыг баримтлагчид урлаг бол улс төр, нийгмийн шаардлагаас хамаарахгүй байх ёстой бөгөөд түүний цорын ганц агуулга, эцсийн зорилго нь гоо сайханыг тунхаглах явдал мөн гэж нотлодог. Тэд нийгмийн харилцааны шударга бус байдал, мөнгөний боолчлолын бэрхшээлээс зайлж өөрсдийн санаанаасаа зохиосон гоё сайхан ертөнцөд нуугдахыг мөрөөддөг байв.

**Историзм** — түүхэн зүй. Аливаа түүхэн үеийн дүр төрхийг биет зураглал, хүмүүсийн тодорхой хувь заяа, зан чанараар дамжуулан гаргах уран зохиолын нэгэн чухал шинжийг тэмдэглэх угга зохиол шинжлэлийн ухагдахууны нэр. Үүнд «түүхэн зүй» гэсэн нэр томъёо хоёр утгаар хэрэглэгдэнэ:

1. Түүхэн зүй нь өргөн утгаараа жинхэнэ уран сайхантай бүх зохиолд хэвшмэл байна. Энэ шинж нь эдгээр зохиол орчин үеийг дурсэлж үү, өнгөрсөн үеийг дүрсэлж үү гэдгээс хамаарахгүй.

Жишээ нь Д. Намдагийн «Цаг төрийн үймээн» роман хувьсгалын өмнөх ба хувьсгалын үеийн түүхэн бодит байдлыг дурсэлсэн юм. Энд хаад, ноёд, сүм хийдийн төлөөлөгчид, харийн түрэмгийлэгчид гарах бөгөөд тэдний хэл яриа, хувцас хунаар, эдлэл хэрэглэл, үзэл ойлголт, ёс заншил, ахуй амьдрал аль аль нь тэр үеийнхээ онцлогийг тусгасан тул өнөөгийнхөөс мэдэгдэх өөр байна. Суварганы ёроолд хамуутай, тамиргүй ноход дунд өвчинд нэрвэгдсэн малчин эр Аравгайн хэвтэж байгаа зэрэг нь чухамдаа тэр л үед зуршмал үзэгдэл болно. Гэтэл Ч. Чимидийн «Хавар намар» бол атар газар эзэмшихээр залуучууд мордож байсан 60 аад оны бодит явдлаас сэдэвтэй тул тэр үеийн хүмүүсийн хувьд нийглэг ёс суртахуун, оюуны төлөв байдал, аж амьдралыг дурсэлсэн байна.

2. Түүхэн зүй гэдэг нь XIX зууны утга зохиолд бий болсон, урьд үеийг дурслэхэд хандах шинэ хандлагыг тэмдэглэх ухагдахуун болно.

Энэ хандлага нь зохиолч хүн өнгөрсөн үеийн өвөрмөц байдал, хүмүүсийн зан чанар, үйл явдлын онцлогийг аль болох түүхэн үүднээс зөв ойлгож, үзүүлэхийг чармайдагт оршино. Ийм хандлага түүхэн өгүүлэгдэхүүнтэй роман, жүжиг, найраглал зэрэг зүйлчлэлийн зохиолыг бүтээхэд илэрнэ. Түүхэн зүйлчлэлүүд XVII зууны сүүлч, XIX зууны эхэн үеийн утга зохиолд үүссэн бөгөөд романтизмын гоо зүйтэй юуны түрүүнд холбоотой юм. Романтизмын түүхэн зүйн нэн чухал онцлог нь «нугийн өнгө ялгамж», хүмүүсийн үндэсний өвөрмөц зан чанар баатарлаг дүр төрхийг үзүүлэх явдал гэж үздэг байв. Романтик түүхэн зүйн зарчмууд шотландын алдарт зохиолч В. Скоттын (1771—1832) уран бүтээлд төгс биеллээ олсон юм. Түүхэн зүй нь реалист утга зохиолд цаашдаа уламжлан хөгжсөн байна.

**Каламбур,** (игра слов) — үгийн наадам, угзэр наадах. Ижил буюу төстэй дуудагдах боловч өөр өөр утгатай үгс, бүлэг үгсийг, эсвэл нэг үг юм уу холбоо үгийг утгын ялгамжийг нь ашиглан инээд наргиантай болж ойлгогдохоор бодож бүтээсэн хэллэг буюу тодорхой зохиолчийн бие даасан бэсрэгхэн зохиолыг үгийн наадам тэнэ. Угзэр наадах нь санааг дамжуулах нэгэн хэлбэр болохын хувьд уг санаагаа яруу тод, сонин зугаатай болгож, уран сайхны нө-

лөөллийг нь эрчимжүүлнэ. Жишээ нь Нэг хиа давхиж ирээд:

— За ус ямар байна? гэв

Бадарчин

— Ус хар байна гэтэл

Хиа:

— Чамаас би усны хар цагааныг асуув уу? Харин ус их байна уу, бага байна уу? гэж байна.

Бадарчин:

— Аа бүү мэд! Би муу хумбан тогоогоороо нэг дүүрэн цай чанаж учихаад дахиад нэг тогоо ус хийж аваад цай буцалгаж байна. Энэ завсар хоёр үхэр, нэг ямаа ус уугаад гарна билээ. Цаана нь нэлээн ус үлдэж байх шиг байна. Гэвч та өөрөө хардаа.

Хиа:

— Чийний илүү уг ч гайгүй, мөдхөн энэ замаар манай дархан нөён морилж ирнэ. Зам зайл!

Бадарчин:

— Танай ноён тийм дориун дархан юм бол түүгээр чинь муу тогоогоо гагнуулъя байз.

Хиа:

— Манай ноёнд ам гарлаа. Чамайг ноёнд аваачиж...гие дөө.

Бадарчин:

— Ээ хөөрхий. Төрөлх амнаас нь өөр ам хаана нь гаралт вэ? Ам биш яр байлгүй дээ. Би ч ямар эмч биш, очоод ч яах вэ дээ гэжээ.

### «Бадарчны үлгэрээс»

Калька — хуулбар уг. Харь хэлний уг хэллэгийг эх хэлний хээ арга хэрэглүүрээр яг таг буулгах замаар үүсгэсэн уг, хэллэг. Жишээ нь: улаан булан (оросоор красный уголок), ашиглалтад өгөх (оросоор сдать в эксплуатацию), цөвийн цаг (төвдөөр сныгс - май дус, санскритаар калпакашая), өглөгийн эзэн (төвдөөр свинин-вдаг), арга билиг (төвдөөр тхав шэс, санскритаар упая пражния), хоосон чанар (төвдөөр стонг-па-ньид, санскритаар шуньята), нэгэн үзүүрт сэтгэл (төвдөөр сэмс-рзэ-гжиг) г.м.

Киносценарий — үз. Сценарий.

Классика — сонгодог зохиолчид. Явцуу утгаар бол шинэ үеийн зохиолчдоос ялгаж грек, ромын зохиолчдыг ийнхүү нэрлэнэ. Мөн классицизмын төлөөлөгчдийг энэ үзээр нэрлэх нь бий. Өргөн утгаар бол аль нэг үндэстний соёлын цэцэглэлтийн тодорхой үед төрсөн бүх зохиолчийг (жишээ нь грекийн хувьд МЭӨ 5-р зуун, францын хувьд 17-р зуун, Орос орны хувьд 19-р зуун г.м.) сонгодог зохиолчид гэнэ. Бас уран бүтээл нь дэлхийн юм уу үндэсний утга зохиолын эрдэнэсийн санд орсон гарамгай зохиолчдыг дэлхийн сонгодог зохиолч, үндэсний сонгодог зохиолч гэхчлэн нэрлэдэг.

**Классицизм** — классицизм. XVII—XIX зууны эхэн үеийн урлаг, утга зохиолын нэгэн чиглэл. Энэ чиглэлийн онцлог нь иргэний эрхэм дээд сэдвийг чухалчилдаг, эртний грек-ромын утга зохиол, урлагийн дүр, хэлбэрийг гоо зүйн туйлын хүслэнгийн загвар болгон дуурайдаг, уран бүтээлийн тодорхой хэм хэмжээ, гөрим дүрмийг чанд баримталдаг байсанд оршино. Өрнө дахиинд классицизм нь тансаг бароккогийн эсрэг тэмцэх явцад бүрэлдэн тогтжээ.

**Кли макс** — ернүүлэл. Үг, хэллэгийг утга санаа нь улам өсч өрнөхөөр дараалалтай байрлуулдаг найруулгын ёр маяг, шаталын нэг хэлбэр.

Зүү хураавал  
Сүх болно  
Сүх хураавал  
Сүм болно

Монгол ардын цэцэн үг

Убashi хун тайж хөвүүний тэр угэнд боогдоод. Ойрдын наад захад хэн байна. Цэрэг, нутаг алины ч хэл гэв.

Хөвүүн мэдүүлнэ: Ойрдын наад захад тож мөнгөн дуулгатай, товруут улаан хуягтай, таж торгон улбатай (хүрэмтэй), толботой цоохор морьтой Мангадын хөвүүн сайн Сэргэнги хоёр мянган залуугаа дагуулж, хоёр мянган жадаа хатгаж, хоёр мянган морио сойж, дайрах гөрөөс хaa байна? Дайлалдах дайсан хаа байна гэж шүдээ хавирч, шүлсээ залгиж сууна. Ноён түүнд дур чинь ямар байна? (гэв). Исал тэр чинь гайгүй (түүний цаана хэн байдаг вэ, хэл гэв).

Эрчис голын эхэнд буугаад Эрчин Харчин хоёр нутгаа цуглувуулж, хар эрдэгчийн цагаан элэг мэт хамгаас тодорч, хойд Исальбайн Сайн хиа дөрвөн мянган залуугаа дагуулж, дөрвөн мянган жадаа хатгаж, дөрвөн мянган морио сойж байна. Үхэлдэх дайсан билүү, угцэх залуу билүү гэж шүдээ хавирч, шүлсээ залгиж сууна. Ноён түүнд дур чинь ямар байна? гэв.

Исаль тэр чинь гайгүй, түүний цаана хэн байдаг вэ, хэл гэв. Сүрэг хонинд довтолсон сурхий чонын дүртэй өнжин юм идээгүй өлөн бүргэдийн нүйтэй, зүүн гар хотгойдын ноён хар хул зургаан мянган хүнтэй байна гэв. Байdag ноён түүнд дур чинь ямар байна (гэв). Исаль тэр чинь гайгүй. Түүнээс цаана хэн байдаг вэ, хэл гэв. Нарийн голын эхэнд, нарийхан шарга морьтой, найман мянган цэрэгтэй, урт голын билчирт Ойрдын сайн Тэмнэ баатар тэр байна гэв. Байdag ноён түүнд дур чинь ямар вэ? гэв.

Исаль тэр чинь гайгүй. Түүний цаана хэн байдаг вэ? хэл гэв. Алах булахдаа дуртай, арван барсын дуутай, айхавтар таван барсын ах хошууд Байбагус хан, түм зургаан мянган залуугаа

иүү гол үүрэгтэй байгаагаас хамааран «нөхцөл байдлын» инээдэмт жүжиг, «зан чанаарын» инээдэмт жүжиг гэж ялгах нь бий.

Гэвч ихэнх инээдмийн жүжигт зохиомжийн энэ хоёр төрөл хосолсон байдаг.

**Композиция** — зохиомж гэдэг нь зохиолын уран сайхан хэлбэрийн бүрдвэрүүд, дүр, дүрслэл, үйл явдлын хэсгүүдийн байршил, харьцаа, харилцан уялдаа буюу өөрөөр хэлбэл агуулга, зүйлчлэлийн нь онцлогоос хамааран бий болсон тухайн зохиолын байгууламж болно.

Зохиомжийн шинж чанар нь уран зохиолд цагийг дүрслэх онцлогтой нягт холбоотой байдаг. Зохиолын өгүүлэлмийг хөглөхдөө он цагийн дарааллыг баримтлах (Л. Түдэвийн «Уулын үер», Д. Намдагийн «Цаг терийн үймээн») юм уу, уг дарааллыг зөрчиж болдог (Лермонтовын «Маний үеийн баатар»). Зохиолд бас үйл явдлын гол шугамын хажуугаар уянгын хадуурал, завсын явдал (Шолоховын «Сэтгэлийг шинэггэсэн нь» роман дахь Шукарь өвгөний яриа), тодорхой дүрслэл оруулах нь бий. Энэ бүх зүйлс нь үйл явдлын өрнөлийг saatуулж, баатруудыг олон талаас нь харуулсан, зохиолчийн уг санааг бүрэн гаргах, заримдаа өгүүлэлмийг сонирхох уншигчийн сэтгэлийг улам боргуулах бололцоог олгоно. Зохиолын эхэнд эхлэл (пролог), эцэст төгсвөр (эпилог) хийх нь бий. Мөн хэний нүдээр үйл явдлыг харж дурсэлж байна гэдэг нь зохиомжид чухал юм (Л. Толстойн «Дайн ба энх» романд Бородины тулалдааныг Пьер Безуховын нүдээр харж үзүүлжээ).

**Контаминация** — эвцүүлэг. Бичвэр судлалд нэг зохиолын хоёр өөр боловсруулгын (редакцийн) эх бичгүүдийг нийлүүлж нэг бүрэн хувилбар байдалтай болгосон нь.

**Конфликт** — зөрчил. Зохиолын өгүүлэгдэхүүнээр илрэх гэмтэл, мөргөлдөөн (уз. сюжет), Амьдралын ба уран сайхны зөрчлийг ялгаж ухаарах хэрэгтэй. Уран бүтээлч амьдралын зөрчил, мөргөлдөөн, тэмцлийг зохиолдоо зүгээр нэг тусгадаггүй, өөрийн бүтээсэн баатруудын хувь заяа, үйл явдалд шингээн ихэд өөрчилж үзүүлдэг. Уран сайхны зөрчил хэр үнэмшилтэй, агуулга төгс болсноос тухайн зохиолын нийгмийн ач холбогдол хамаарна.

Зөрчил нь зохиолын үйл явдлын үндэс, хөдөлгөгч хүч болохынхоо хувьд өгүүлэгдэхүүний өрнөх шатуудыг тодорхойлно (зөрчлийн үүсэл нь зангилаа, дээд зөргээр хурдадсан нь — туйл, зөрчлийг шийдвэрлэсэн нь — тайлал). «Зөрчил» гэсэн нэр томъёог жүжгийн ба туульсын зохиолд голчлон хэрэглэдэг.

**Концовка** — уз. Эпифора.

**Критика литературная** — утга зохиолын шүүмжлэл. Утга зохиол шинжлэлийн нэг бүрэлдэхүүн хэсэг. Уран зохиол ба түүнд туссан амьдралын үзэгдлийг үнэлж тайлбарлана. Уран зохиолын түүхээс ялгаатай нь гэвэл орчин үеийн уран зохиолын үйл явц,

дагуулж, арван таван тэрмэтэй алаг байсан ордондоо... дөрвөн зүгт надтай айлдах нэгэн чинээ хүнгүй биз гэж амаа ангайж, алгаа сарвайж сууна гэдэг... гэв.

Монголын Убashi хун тайжийн түүх

**Коллизия — харшилдаан.** Уран зохиолын үйл явдлын үндэс болсон, тэнд гарах хүмүүсийн зөрчил, мөргөлдөөн, тэмцэл. Харшилдаан нь зөрчил (конфликт) гэсэн нэр томъёотой ойролцоо утгагай хэрэглэгдэнэ.

**Колыбельная песня — өлгийн дуу, бүүвэйн дуу.** Хүүхдийг нойрсуулах гэж бүүвэйлэхдээ дуулдаг, ардын яруу найрагт өргөн дэлгэрсэн, нэгэн зүйл уянгын дуу.

Өлгийтэй бяцхан үр минь бүүвэй

Өлсөөд ээжээ дуудав уу бүүвэй

Бүүвэй бүүвэй бүүвэй

гэх юмуу

Хараацай шувууны дэгдээхэй шиг

Харцан дундуураа дуудаад байна уу заа

Ээ бүүвэй, бүүвэй, ээ бүүвэй бүүвэй

гэх мэтийн үгтэй монгол ардын дуунууд байдаг нь цөм намуун уянгалаг аятай, өхөөрдөн энхрийлсэн санаатай байна.

Орчин үеийн шүлэгчид бас бүүвэйн дуу зохиосон нь бий. Жишээ нь Ц. Дамдинсүрэн «Учиртай гурван толгойг» засварлахдаа

Хаяанд байгаа хашаанд

Халзан хурга хэвтэж байна

Хар сайхан нүдээ

Хамхиж аниад унтжээ

Хайртай хүү минь унт даа

Бүүвээ, бүүвээ, бүүвээ гэхчлэн өгүүлсэн

бүүвэйн дуу зохиож оруулсан билээ.

**Комедия — инээдмийн жүжиг.** Гарах хүмүүс, орчин нөхцөл, үйл явдлыг нь инээдэмтэй хэлбэрээр дүрсэлсэн нэгэн зүйл жүжиг. Энэ жүжиг уран зохиол дахь инээдмийн зүйлийн нэг хэлбэр болохын хувьд түүний нэн чухал нарийн ялгаанууд, хошигнол, егөөдөл, ёжлол ба шоглолыг туйлын оновчтой тусган авч гаргадаг. Тийм учраас инээдмийн жүжгийн төрөл зүйл нь хөнгөн зуугаатай хэлбэрээс эхлээд шог үзэгдэл (фарс), завсрлын хөгжөөлгө (интермедия), алиа ший (водевиль), гүн·гүнзгий үзэл санааны зорилтыг агуулсан дорвилог инээдмийн жүжгийг хүртэл олон янз байна.

Хөгтэй учрал тохолдол, эндүүрэл мундрал мөн хурц шог хэллэг, үгийн наадам юм уу тохиromжгүй үед, зохимжгүй орчинд хэлсэн үг, тухайн баатрын амнаас сонсоход инээд хүрмээр хэллэг сэлтээр дүүрэн харилцан яриа тэргүүтэн дээр үндэслэсэн үйл явдлын тусlamжтайгаар жүжгийг инээдэмтэй болгоно. Жүжигг инээдэмтэй орчин нөхцөл юм уу баатрын хөгтэй зан төрхийн аль

саявтар гарсан ном, бүтээлийг гол төлөв авч үзнэ. Ном сэтгүүл гарч байгаа зохиол бүтээлийн үзэл санаа, гоо зүйн шинж чанырыг тодорхойлоходоо утга зохиолын шүүмжлэл нь юуны түрүүн нийгмийн хөгжлийн тухайн шатнаа тулгарсан зорилтыг иш үндэс бөлгөнө.

Шүүмжлэл нь өгүүлэл, шүүмж, тойм, уран зохиолын хөрөн маргасан хариу (полемическая реалика), ном зүйн тэмдэглэл эргэцүүлэлмж зэрэг олон хэлбэртэй. Төрөл зүйл ба тавьсан зорилгоосоо хамааран шүүмжлэл нь гарсан номын тухай жирийн мэдээлэхээс авахуулаад нийгэм, утга зохиолын томоохон асуудлыг тавих хүртэл янз бүрийн үүрэг гүйцэтгэнэ.

**Кульминация** — туйл. Зохиолын үйл явдал, зөрчил хурцаас нэг тийш щийдвэрлэгдэхээс өөр аргагүйгээр дээд цэгтээ хүрсний туйл гэнэ. Зохиолын доторхи бүх зөрчил нь яв яваар туйлд хүрэх бөгөөд дараа нь тайлал залган гарна. Үйл явдлын олон шугам бүхий томоохон зохиолд хэд хэдэн туйл байж болно. (Жишиг нь Ч. Лодойдамбын «Тунгалаг тамир» роман). Туйл нь баатруудын зан чанарыг нээн гаргах, уран сайхны зөрчлийг өрнүүлэхэд чухал үүрэгтэй.

**Легенда** — домог. Ардын аман зохиолын нэгэн зүйл. Өгүүлэл дэхүүний үндэс нь үнэн түүхт хэрэг явдал, бодитой баримт байж боловч уран санааны зүйлсээр нэмж хачирлан ярьж ирсэн хүүр нэл зохиол. Монголын түүхийн ойллого бичиг «Нууц товчоо», Лувсандаанзын «Алтан товч», «Хураангуй алтан товч», «Шатууж», «Асррагч нэртийн түүх», «Эрдэнийн эрих» тэргүүтэнд «Алатуя хүүхдүүдээ сургасан домог», «Аргасун хуурчийн домог», «Гурван зуун тайчуудыг дарсан домог», «Мандухай сэцэн хатны домог», «Гүрвэлжин гуа хатны домог» зэрэг олон түүхэн домог орж үлджээ. Домгийн өгүүлэгдэхүүний зохиолчид уран бүтээлдээ нэлээд ашигладаг. Жишиг нь Д. Нацагдорж «Учиртай гурван толгой» зохиолдоо «Юндэн геегээ» гэдэг ардын дууны тухай домгийн үндэс болгосон байна.

**Лейтмотив** — хөтлөгч сэдэл. Өргөн утгаар тодорхой зохио юмуу зохиогчийн нийт уран бүтээл, өсвэл чиглэлийн гол сэдэвийн үзүүлэл санаа, сэтгэл хөдлөлийн үндсэн өнгө хөгжийг хөтлөгч сэдэв гэнэ. Арай явцуу шиг утгаар бол, зохиолчийн уг санааг илэрхийлэх тулхүүр болсон, бүтээлд нь нэвт щувт гарч байгаа тодорхой дүр, байн байн давтагдаж байгаа нарийвчилбар юмуу угийг хэлж нэ. Яруу найрагг бас авиа, айзам, хөг аялгын хөтлөгч сэдэл байдаг.

**Лексика** — үгсийн сан. Хэлний бүх үгийн нийлбэр цогц. Оричин үеийн монгол хэлний үгсийн сан нь гарал, хэрэглэгдэх хүрээний нийтуулга зүйн учир холбогдоороо өөр өөр бүлэг үгсээс бүрдсэн нарийн тогтолцоо болно.

Гарлын хувьд жинхэнэ монгол үгс («хүн», «суух», «хөх» г.м.)

зүүлдмэл ўгс (ном, судар, байшин, цүнх, замаѓ) гэж ялгана. Орчин үеийн монголын утга зохиолын хэлний нэг хэсэг ўг нутгийн аялгуунаас орж ирсэн (заядуулах, хөрш) байна.

Өргөн хэрэгцээний ўгсээс үадна хэрэглэгдэх хүрээ нь харилцаны тодорхой орчин нөхцөлөөр хязгаарлагддаг ўгс байдаг.

Жишээ нь шинжлэх ухааны нэр томъёо, ярианы хэлний ўгс, албан бичгийн ўгсийг үүнд хамааруулна. Үгсийн найруулга зүйн учир холбогдол нь тэдгээрийн утгын нэг адилдэр хувиршгүй зүйл биш. Үрд нь судар бичгийн гэж байсан ўгс нийтийн хэрэглээни болох, хуучирсан ўгс идэвхжиж өргөн хэрэглэгдэх явдал бий. Зохиолч хүн түүхэн цаг үеийн онцлогийг гаргах, дур бүтээх, уран шийтуулгатай бичихийн тул эх хэлнийхээ ўгсийн сангийн баялгийг үзүүмшиж чадварлаг, оновчтой хэрэглэж суралын чухал байдаг.

Лирика — уянга, утга уянга. Уран зохиолын гурван төрлийн нэг. Туульсын ба жүжгийн зохиолоос уянгын зохиолын гол ялгирах зүйл нь гэвэл яруу найрагч энд өөрөөсөө ондоо баатрыг биш, харин өөрөө өөрийгөө, өөрийнхөө догоод ертөнцийг харуулжин байдагт оршино. Уянгын бүтээлд туссан зохиогчийн бодол үргэцүүлэл нь хүй нийтийн түгээмэл утга агуулгатай байна.

Утга зохиолын хөгжилтэй уялдан уянгын шүлгийн агуулга, хүлбэр өөрчлөгдөж иржээ (ардын уянгын дуу, буддын бясалгалын уянга, сэргэн мандалтын үеийн арван дөрвөн мөрт шүлэг, эртний гуниглал шүлэг, дууль г.м.). Уянгыг бас сэдвээр нь улс төрийн, гүн ухааны, хайр сэтгэлийн, байгалийн гэхчлэн ангилах нь бий.

Лирический герой — уянгын баатар. Уянгын зохиол дахь яруу найрагчийг төлөөлөх дур. Уянгын «би» баагар ч гэж нэрлэх нь бий. Энэ бол яруу найрагчийн бүх зохиолыг хамарсан утга зохиол шинжлэлийн харьцангуй ойлголт. Яруу найрагч уянгын баатар хоёрын харьцаа бол амьд эх дур, уран сайхны хэв шинж хоёрын харьцаатай адил гэж голдуухан нотолгоодог.

Лирическое отступление — уянгын хадуурал, уянгын халилт. Туульсын ба уянга-туульсын бүтээлд зохиогч нь өгүүлэгдэхүүнээсээ хальж, дурсэлж байгаа хэрэг явдлаа тайлбарлак, үнэлэх зорилгоор юмуу эфвэл зохиолынхоо үйл явдалтай шууд холбогдолгүй өөр учир шалтгааны талаар өгүүлснийг уянгын хадуурал генэ.

Лиро-эпический жаир — уянга туульсын зүйлчлэл. Туульсын ба уянгын дурслэлийг хослуулсан зохиолууд. Ийм зохиолуудад үйл явдлын сацуу, хүүрнэгч этгээдийн санаа сэтгэл, бодол, бясалгалын өгүүлэж уянгын «би» баатрын дурийг бүтээж, тодорхой байр эзэлнэ.

Литература — утга зохиол. Энэ нь шинжлэх ухаан, техник, нийгэм улстэр, шийтгэл, захидал харилцааны зэрэг бичээр бичсон бүх төрийн зохиолыг хэлнэ. Үүнд мөн уран үтийн зохиол ч багтах тул литература гэхийг хааяа уран зохиол гэж орчуулдаг.

Орос хэлэнд нийт утга зохиолоос уран зохиолыг ялгахын тулд хааяа литература художественная (уран зохиол) гэсэн нэр томъёо хэрэглэдэг. Монгол хэлэнд орос хэлний нөлөөгөөр утга зохиол гэсэн угээр нийт утга зохиолыг болон уран зохиолыг аль алийн тэмдэглэж ерөнхийдөө занисан байна.

**Литература художественная** — уран зохиол. Угээр амьдралыг тусгадаг урлагийн нэгэн зүйл. Хэдийгээр уран зохиол гэх лээр бичгийн зохиол санаанд ордог (литера гэж үсэг гэсэн латин үг) боловч өргөн утгаараа уран зохиолд ардын аман зохиол ч багтдаг юм. Уран зохиолын (болон ер нь нийт урлагийн) дурслэгдэхүүн нь хүний амьдрал, тэмцэл, бодол санаа, бодиг байдалд хандах хандлага болно. Уран бүтээлч нар хүний амьдралыг зүгээр нэг үзүүлдэггүй, харин өөрийн хамгаалан тэмцэж бүхий нийгмийн туйлын хүслэнгийн үүднээс түүнийг дурсэлж, жинхэнэ хүний дүр бүтээхийг эрмэлздэг.

Зохиолчид угээр дур бүтээнээр бодит байдал, хүний дотоод гадаад ертөнцийн бүх талыг хамран үзүүлэх болблцоог олж авна. Уран бүтээлч хүн урлагийн бусад төрөлд амьдралын үзэгдлийн нүдэнд үзэгдэж гарг баригдтал дурслэх боломжоор илүү байдаг бол зохиолч хүн зураг дээр юмуу театрт үзэж чадахгүй хүний тийм онцлогийг уран зохиолд тал талаас нь харуулах, цаг хугацааны дотор үргэлжилсэн үйл явдлыг үзүүлэх, зохиолынхоо баатруудыг янз бүрийн эрин үе, аль дуртай хот, орондоо, түүний дотор үлгэр, уран сэтгэмжийн оронд аваачиж харуулах боломжтой байдаг.

Уран зохиолд хүнийг хэдийгээр тодорхой дурсэлдэг ч гэсэн уул дурслэл нь уг үндсээрээ томъёолсон шинжтэй байдаг. Юу гэвэл зохиолч амьдралд тааралдсан аль нэг хүнээ шууд тэр чигээр нь үзүүлдэггүй, харин тохиолдлын шинжуудийг нь орхин тиймэрхүү байр төлөвтэй хүний хувьд хэвшмэл шинжуудийн нэмж, хамгийн чухал гэсэн шинжээ улам тодотгон хүний зам байдлын талаархи өөрийн туйлын хүслэнтэй нийцүүлж үзүүлдэг бөгөөд дурслэлдээ санаанаасаа зохиосон зүйл бас оруулдаг байна. Үншигч нар амьдралд чухамхан ийм хүн байгаагүй гэж мэдэж байвч энэ хүн байж болох л байсан гэж ойлгодог. Зохиолч ямар уран сайхны арга хэрэглэснээс хамааран томъёолсон шинжийн хэр хэмжээ янз, янз байна.

Нэг тодорхой хэл дээр юмуу тодорхой улсын хил хязгаар дотор зохиогдсон зохиолууд тэр үндэстний утга зохиолыг бурдүүлнэ (монголын утга зохиол Г.М.); нэг үед бүтээгдсэн, үүний улмаас уран сайхны шинж чанар нь нийтлэг, болсон зохиолуудыг тухайн тэр үеийн утга зохиол гэж ярьж болдог (сэргэн мандалгын утга зохиол Г.М.); бие биедээ улам бур харилцан нөлөөлөх болж багаа олон үндэстний утга зохиол хамтдаа дэлхийн буюу дэлхийн нийтийн утга зохиол болно.

Уран зохиол дотроо туульс, уянга, жүжигт гэсэн гурван төрөлд хуваагддаг. Төрөл нь цаашаа зүйл, зүйлчлэлүүд болж задарна. Нийгмийн ўйл явц, хүний ўйлдэл явдал, сэтгэлийн хөдөлгөөн янз янз байдаг нь уран зохиолын олон янзын төрөл, зүйлсийг нөхцөлдүүлжээ. Төрөл тус бүрээр бичсэн зохиолууд өөр хоорондоо зарчмын ялгаатай боловч тэдгээрт нийтлэг зүйлс, нэгдэл байдаг. Аливаа зохиолд хүмүүсийн дүр ( зан чанар буюу баатрууд), сэдэв, үзэл санаа байна. Утга зохиолд мөн янз бүрийн уран бүтээлийн арга, найруулгыг ялган үздэг.

Литературный процесс — утга зохиолын явц. Нэг үндэстэн, орон, бус нутаг буюу дэлхийн нийт түүхийн турши болон аль нэг тодорхой үе дэх утга зохиолын түүхэн хувьсал, хөдөлгөөн. Утга зохиолын явц бол мөн гоо зүй, оюун санаа, зан суртахууны үнэт зүйлс хуримтлагдаж, хүмүүнлэг үзэл шулуун замаар биш ч гэсэн хэлбэрэлтгүй өргөжиж ирсэн түүх юм. Тодорхой нэг үеийг хүртэл утга зохиолын явц харьцаангуй түгжигдмэл, үндэсний шинжтэй байдаг. Хөрөнгөтний үед эдийн засаг, соёлын холбоо хэлхээ хөгжихийн хамтаар «үндэсний ба орон нутгийн олон утга зохиолоос дэлхий дахины нэгэн үтга зохиол бүрддэг байна. Утга зохиолын явцын нэг чухал тал нь урлагийн бусад зүйлтэй, мөн нийт соёл, хэл, үзэл суртал, шинжлэх ухааны үзэгдлүүдтэй уран зохиол харилсан үйлчлэлцэх явдал болно. Уран бүтээл нийгэм — улс төрийн хөдөлгөөнүүдтэй шууд холбоотой байх нь ч цөөнгүй (Ж.ны: декабристын утга зохиол, Парижийн коммуны утга зохиол, чартистын утга зохиол г.м.).

Утга зохиолын явц нь гүн ухааны цогц үзлүүдийг өөртөө бүтээлчээр тусгаж чаддаг юм. Тухайн эриний утга зохиолын «өөрийгөө танин мэдэхүй» оролдлого (уран бүтээлийн хөгөлбөр, утга зохиолын тунхагууд) болон үзэл санаа — уран сайхны янз янзын чиглэл, урсгалуудын (Ж.ны: романтикууд классицистуудтай реалистууд романтизмыг сохроор дуурайгсадтай тэмцэж байв) тэмцэл сүүлийн хэдэн зуун жилд утга зохиолын явцын салшгүй бүрэлдэхүүн хэсэг болж иржээ. Дэлхий дахины хэмжээнд утга зохиолын явц нь нийгэм түүхийн ўйл явцын нэг хэсэг болж, түү нээс хамаарч байдаг. Утга зохиолын явцыг соёл түүхийн амьдрал нөхцөлдүүлдэг гэж орчин үеийн утга зохиол шинжлэл үзэж байна.

Утга зохиолын явц нь хүн төрөлхтний нийгмийн хөгжлийн олон үе шаттай холбоо шүгэлцээтэй юм (Домог улгэрэйн үе, эрт үе, дундад зуун, шинэ үе, шинэхэн үе). Түүхэн амьдралд гарсан ахиц өөрчлөлтийн талаар үгээ хэлэх, тэр амьдралд оролцох, нийгмийн ухамсарт нелөөлөх хэрэгцээ (тэр бүр ухамсарлаагүй) зохиолч хүнд гардаг нь утга зохиолын явцад дав дээр тулхэн болж байдаг юм. Ийнхүү утга зохиол нь юуны түрүүнд гадны «тулхээсний» нелөөгөөр түүхэн цаг хугацааны дотор өөрчлөгддөг юм. Үүний хамтаар утга зохиол хувьсан хөгжихэд уламжлал их ач холбог-

долтой хоёрдогч хүчин түлхээс нь болдог. Зохиолч хүн эрх бил уламжлалыг ашигладаг.

Түүхэн үүднээс байнга давтагдаг амьдралд хандах үзэл са наас-этгэл хөдлөлийц хэлбэрүүд (эмгэнэлт, инээдэмг, шогломг.м.), урлагийн «мөнхийн сэдвүүд», хүн нийтийн зан суртахуун, гүн ухааны асуудлууд (сайн, үнэн, гоо сайхан), олон зуун жилээр боловсруулж хуримтлуулсан уран сайхны хэлбэрүүд (юун түрүүнд төрөл зүйлийн) зэрэг нь «залгамжлалын сан» болох, багаад эдгээр нь байхгүй бол утга зохиолын явц гэж байх аргагүй юм. Утга зохиолын явц нь (үндэсний утга зохиолын хүрээнд болон дэлхий дахинь хэмжээнд) утга зохиолын өөр хоорондоо төсгэй болоод төсөөгүй олон эрин үеэс бүрдэнэ. Эрин үе тус бүр өөриймшүүлсэн хуучин юм, зохиосон шинэ юм хоёрыг өөртөө агуулсан байдал. Соёлын тодорхой нийтлэгт уламжлал, шинэчлэл хоёр нэгэн зэрэг хичнээн хурц илрэхийн хэрээр тэр нийтлэг нь төчнөөн баялаг, ур шимтэй байна.

Утга зохиолын явцын нэг салшгүй бүрэлдэхүүн нь олон улсын утга зохиолын холбоо харилцаа болно. Энэ нь утга зохиолын явцад голлох түлхээс болдоггүй ч гэсэн уран бүтээлд идэвхитэй нөлөөлдөг, харьцангуй бие даасан хүчин зүйл юм. Олон улсын утга зохиолын шүтэлцээ нөлөөлөл нь зөвхөн сэдэв, дүр, өгүүлэгдэхүүнээр хязгаарлагдахгүй мөн уран сайхны үзэл санаа, хэлбэр бүрдүүлэх зарчим, төрөл зүйл, тэдгээрийн тогтолцоо, уран бүтээлийн хөтөлбөр сэлтийг ч хамаардаг байна. Юуны түрүүнд нийгэм-түүхийн ахиц дэвшлийн хүчээр урагшлагч утга зохиолын явцыг өөрийн нь дотоод мөн чанарын үүднээс үзвэл үндэсний соёлын уламжлал, өөр үндэстний соёлын нөлөө гэсэн харилцан шүтэлцээтэй хоёр хүчин зүйл чиглүүлж байдаг байна. Өөрөөр хэлбэл түүнд «орон нутгийн зүйл» (өөрийн юм), «гаднаас» авсан зүйл (хүний юм) хоёр нэгдэн нийлж байдаг аж. Энэ нийлэгжилт бол аливаа үндэстний утга зохиол баяжин, өв тэгш хөгжихийн зайлбаргүй нөхцөл мөн.

**Литературный язык** — утга зохиолын хэл. Бүх ард түмний хэлний боловсруулсан, үлгэр жишээ хэлбэр. Өргөн утгаар утга зохиолын хэл гэдэг нь нийт утга зохиол — радио, телевиз, шинжлэх ухаан, нийтлэл, уран зохиол, албан бичгийн хэл.

**Литературоведение** — утга зохиол шинжлэл. Уран зохиол, түүний үүсэл, мөн чанар хөгжлийн тухай ухаан. Дотроо уран зохиолын онол, уран зохиолын түүх, уран зохиолын шүүмжлэл гэсэн гурван тол салбартай.

Онол нь уран зохиолын бүтэц, хөгжлийн ерөнхий хууль зүйг тодорхойлж, зохиолын онцлог, түүнийг задлан шинжлэх зарчмыг тогтоон, уран зохиолын хөгжлийн явцыг судлах арга замыг зааж - өгнө.

Уран зохиолын түүх нь уран зохиолын хөгжил, наиргуулга

(стиль), элдэв чиглэл, урсгал, арга сэлигдож ирсэн байдал олон орны уран зохиолын харилцан үйлчлэл, утга зохиолын явцын бусад хэлбэрийг судална.

Уран зохиолын шүүмжлэл нь ихэвчлэн орчин үеийнхээ үүд нээс шинэ тутам гарсан зохиолуудад үнэлгээ өгне.

Шүүмжлэгч хүн зохиолыг гүнзгий ойлгоход нь уншигчдад тусалдгийн дээр зохиолынхоо ололт, дутагдлыг олж мэдэхэд нь зохиолчид тусалдаг юм. Эдгээр салбар хоорондоо нягт холбоотой. Тухайлбал онолгүйгээр зохиолыг судлах, шүүмжлэх аргагүйчлэн уран зохиолын түүх, шүүмжлэлийн туршлагагүйгээр онолыг боловсруулах бололцоогүй юм.

Энэ гурваас гадна утга зохиол шинжлэлийн туслах салбарууд байдаг (Бичвэр судлал, ном зүй, түүх бичлэг г.м.). Туурвил зүй бол утга зохиол шинжлэлийн нэг чухал хэсэг болно.

**Магтаал** (восхваление, ода) — монголын аман зохиол, уран зохиолын нэг зүйлчлэл. Монголын нууц товчоонд магтаалын зарим дээжис байдгийн дээр (Өэлүн эхийн магтаал, Хөхөчсоын хэлсэн хаан эцэг, хатан эхийн магтаал) хожмын түүхийн өйллогуудад Чингисийн өрлөг жанжнуудын магтаал, Даян хааны зургаан түмэн монголын магтаал тэргүүтэн магтаал бий. Мөн уул ус, эдлэл хэрэглэлийн болон бусад сэдэвт магтаал ам бичгээр уламжилж иржээ.

Магтаал бол байгаль нийгмийн олон юм, үзэгдлийг хамарсан өргөн сэдэвтэй, тухайн юм, үзэгдлийнхээ аль өнгөтэй, сайн сайхан шинжийг өргөмжлөн дуулсан агуулгатай, шүлэглэсэн зохиол байдаг. Магтаалын зүйлд морь, бөхийн цолыг бас хамруулж үзэх нь зүйтэй. Магтаал үүсэхээсээ зан үйлийн зориулалгтай байв. Магтаалыг бэлэн цэцэн угтэй ардын авьяастан нар шууд цээжнээсээ зохион хэлдэг юм. Түүнээс гадна манай орчин үеийн яруу найрагч нар хааяа энэ төрөл зүйлийг бүтээлчээр ашиглан зохиол бичиж байна. Жишээ нь Ц.Дамдинсүрэнгийн «Гэсэрийн баатрын магтаал», С.Дашдооровын «Говийн магтаал» найрагч лал тэргүүтнийг дурдаж болох юм.

**Медитативная лирика** — бясалгалын уянга. XIX зууны утга зохиолын шүүмжлэлд хэрэглэгдэж байсан нэр томъёо. Гүн ухаан болон ерөнхий аж байдлын сэдвээр бичсэн бодол эрэгцууллийн хэлбэртэй шүлгийг ийнхүү нэрлэдэг байв. Өнөө уед уг нэр томъёог ховорхон хэрэглэх болжээ.

**Мелодрама** — аялгуут жүжиг. Дотроо олон янз байна.

1. Баатруудын хүүрнэлдээн, бодмоглолыг дагалдан хөгжим тоглодог хөгжимт жүжгийн зохиол.

2. Сонин, хурц ээдрээт явдалтай, баатруудыг сайн муу гэж эрс зааглаи, сэтгэлийн хөдөлгөснийг дэвэргэн үзүүлдэг (уярангийн байдааар) ёс суртажууны сургамжийн чиглэлтэй нэгэн зүйл жүжиг. XVIII зууны 90-ээд ойн уед францад бий болж (Ж.М.

Монвель, Г.де. Пиксерекур нарын жүжгүүд), ХХ зууны 30—40-еэд оны хэрд цэцэглэлтийнхээ оргилд хүрсэн (Ф. Пиа-ын жүжгүүд бөгөөд феодал, сүм хийдийн эсрэг санааг илэрхийлж байв. Гэвч сүүлдээ түүнд гаднаас нь хараад зугаатай, уян нялуун шинж нөлох болсон юм.

Мемуарная литература — дурсамжийн утга зохиол, дурдагал зохиол. Зохиолч өөрийн урьд нь нүдээр үзсэн, биеэр оролцсон хэрэг явдал, туулсан амьдралаа өгүүлсэн зохиол. Дурсамжийн сонгодог зохиолын жишээ болгон Гетегийн «Яруу найраг ба үнэн Миний амьдралаас», А. Герцений «Туулсан замд төрсөн бодол» ыг нэрлэж болох юм. Эдгээр зохиол гухайн үеийн нийгэм, утга зохиолын амьдралыг, тухайлбал, Гетегийн зохиолд XVIII зууны 60—70-аад он, Герцений зохиолд XIX зууны 20—60 аад оны явдлыг өргөн үзүүлжээ.

Дурсамжийн зохиолын ихэнх нь ашигласан хэрэглэгдэхүүнээрээ, үнэн магадтай, зохиомол уран сэтгэмжгүй байдаг тэргүүт нээрээ түүхийн сэдэвтэй үргэлжилсэн үгийн зохиол, шинжлэх ухааны үндэстэй намтар, түүхэн баримтат найруулал зэрэгтэй ойр байна. Өгүүлэлмжийн хэлбэр, он цагийн дараалал, баримтыг тоочдог, өгүүлэгдэхүүний аргыг эс .хэрэглэдэг зэргээрээ өдрийн тэмдэглэлтэй адил.

Местный колорит — нутгийн өнгө ялгамж. 1. Зохиолын үйл явдал болж байгаа алс холын орны ер бусын сонин хачин зүйлсийг (байгаль, орчин, хүмүүсийн зан чанар, аж байдал) дурсэлснийг хэлнэ. Энэ нь романтизмын зохиолд зуршмал байдаг нэг онцлог юм. Заримдаа бол холын орны биш, харин эрт үеийн өнгө ялгамжийг үзүүлэх нь бий (Скотт, Купер нарын романууд). Романтизмын зохиолд нутгийн өнгө ялгамжийн тусламжтай хөрөнгөтний уйтгартай бодит байдал юмуу язгууртны засдаг гоёч амьдралаас эрс ялгаатай яруу сайхан ертөнцийг дурсэлдэг байв.

2. Газар нутгийн төрх байдал, амьдрал хэвшлийн онцлогийг нээн үзүүлдэг реалист зохиолын уран сайхны онцлог. Энд романтизмаас ялгаатай нь зохиолч бодит байдлаас эрс ялгаатай зураглал бүтээхийн тулд биш, харин зарим талаараа ер бусын шинжтэй бодит байдлыг хамгийн яруу тод дурслэхийн тулд нутгийн ялгамжийг гаргах аргыг хэрэглэдэг байна. Жишээ нь:

Арван гурван насанд минь малдаад барьж өглөө  
Аз хувь чинь мэдэг гэж тэр чигт минь орхилоо  
Ном сайн үзсэнгүй гэж Жарлан лам зовоолоо.  
Номой дорой намайгаа аав минь даанч бодсонгүй  
...Хаа хуриктай гэвэл, би тэнд очдог байв  
Хангинах домбор тэгж хань болж эхэллээ  
...Мүше руу бүргэд шиг шуугин хашиграан ороод  
Мөн түрүүлэн гараяд найран царгиж ч явлаа  
(Б. Ахтаан, «Бага насаа дурсан санаам»)

Госен шүлгийг уншихад казахын ард түмний амьдрал ахуйн онцлогийг тусгаснаас бус халхчууд юмуу буриадуудын талаар яриагүй нь эрх биш мэдэгдэж байна.

**Метафора** — адилтгал. Нэгэн зүйлийн дурслэг хэллэг. Нэг юм, үзэгдлийг нөгөөтэй төсөөгөөр нь адилтгах үндсэн дээр угийн утга шилжүүлэн хэрэглэснийг хэлнэ.

Адилтгал нь шиг, мэт, өөрүүгүй зэрэг угийг хэрэглэдэггүй далд зүйрлэл болно. Жишээ нь «Монголын нууц товчоонд»:

«Зэв, Хувилай тэргүүтэй  
Зэлмэ, Сүбээдэй дараатай  
Тэмүжин андын тэжээсэн  
Тэр дөрвөн ноход  
Тэмүүлэн хүрч ирэв»

гэж гардаг нь дөрвөн хүнийг дөгшин ноходтой жишсэн адилтгал юм.

Чингисийн шарилыг хасаг тэргэнд тээж ирэхэд Сенедийн Ги-лүгэтэй баатар:

Хамгийн хаан, улсын эзэн минь  
Харцгай шувууны жигүүр болон одов  
Хангинах тэрэгний тээш болон одов  
Жиргэх шувууны жигүүр болон одов  
Жигдрэх тэрэгний ачаа болон одов

(ЛУ. Алтан товч) гэж өгүүлж байгаа нь мөн хааны таалал төгс сөнийг урнаар дурсэлсэн адилтгал болно.

**Метод творческий** — уран бүтээлийн арга. Утга зохиол 'шинж-лэлийн нэг чухал сийлголт. Энэ ойлголт олон зохиолчийн уран бүтээлд тогтвортой давтагддаг, тэгснээрээ нэг буюу хэд хэдэн оронд уран зохиолын ургалыг (чиглэлийг) бурдуулж байгаа (реализм, романтизм, символизм г.м), урлагт амьдралыг дүрээр тусгах хамгийн ерөнхий онцлогийг тэмдэглэнэ. Амьдралыг дүрээр тусгах шинж чанар нь уран бүтээлч хүн бодит байдлыг ямар аргаар дурсэлж байна гэдгээс юуны өмнө хамаарна.

Амьдралын үзэгдлийг сонгон авах, дурслэх, үнэлэх үндсэн зарчмууд болох уран бүтээлийн арга нь зохиолчийн ертөнцийг үзэх үзэл, нийгмийн байр суурьтай шууд холбоотой байдаг.

Уран бүтээлийн арга нь түүхийн тодорхой нөхцөлд үүсэн бүрэлдэх бөгөөд туйлын хүслэн, тэр хүслэнд тохирсон (тохироогүй) хүн, улмаар баатрын хэв шинжийн тухай ба зохих өгүүлэгдэхүүнийг сонгон авах тухай төсөөлэл сэлт тухайн аргыг баримтлагч зохиолчдыг нэгтгэнэ. Зохиолчийн найруулга ямагт хувийн өвермөц шинжтэй ч зохиолчийн баримталдаг уран бүтээлийн аргатай заавал холбоотой байна.

Нийгмийн түүхэн амьдрал олон янз байдалтай байдаг нь уран бүтээлийн аргыг мөн олон янзын илрэлтэй болгодог тул урла-

гийн зорилтыг үзэх уран бүтээлчийн үзлээс хамааран уран бүтээлийн өөр өөр арга бас зэрэгцэн оршиж болдог юм.

Аргыг тодорхойлоходоо амьдралын үзэгдлийг үзүүлэхэд объектив, субъектив үүстгэлийн аль нь давамгайлж байгааг харгалзаа ёс бий. Энэ үүднээс уран зохиол, урлагт реализм, романтизм гэсэн хоёр үндсэн аргыг дав дээр ялган үздэг. Реализм нь амьдралыг ийм байна гэж байгаагаар нь бодтой дүрсэлдэг бол романтизм нь амьдралыг ийм байх ёстой гэж, туйлын хүслэнгийн үүднээс хийсвэрлэн үзүүлнэ. Гэхдээ реалист зохиолд зохиолчийн үзэл, туйлын хүслэн тусаагүй гэж болохгүйтэй адил романтик зохиол бодит байдлаас тасархай гэж болохгүй билээ. Объектив, субъектив үүсгэл нэг зохиолчийн уран бүтээлд эрхбиш харилцан шүтэлцсэн байдаг юм.

**Метонимия** — төлөөлөл. Юм, үзэгдлийг өөр уг, ухагдахуунаар төлөөлүүлэн нэрлэх нэгэн зүйлийн дүрслэг хэллэг. Төлөөллийг бүтээхэд шинж төрхөөрөө төсөөгүй боловч ямар нэг шижмээр холбогдсон хоёр буюу хэд хэдэн юм, үзэгдлийн нэгийг негеөгөөр нь орлуулж утга шилжүүлж хэрэглэнэ. Юм, үзэгдлүүд хоорондоо олон шижмээр холбоотой байдаг тул төлөөллийг бүтээх аргач мөн янз бүр, байна. Зарим аргыг дурдвал агуулсан саваар агуулагдсан зүйлийг нь (гурван хундага уув), зохиолчоор зохиолыг нь (Мягмарыг уншив), үйлийн зэвсгээр үйлийг нь (Ойн модчины сухнээс цуврац унах, олон цагаан шив шинэхэн зоргодос шиг... Р. Чойням. «Шүлгийн дэвтрийн тухай шүлэглэл»), бүтсэн эдээр уг юмыг нь (тулсан хоёр мод нь Туулын голын бургас. Ц. Дамдинсүрэн «Толь Гэндэн»), үйлийн тодорхой хэлбэрээр үйлийг нь (уул хэрэв дайралдвал даваад бид гарна. Уул хэрэв дайралдвал дэвээд бид ярна. Ц. Гайтав «Монголын залуучуудын марш») төлөөлүүлж болдог.

**Метр** — хэмнэл гэдэг нь шүлгийн хэмжээ. Явцуу үтгаар бол шүлгийн аймын үндэс болсон зарчим. Эртний грек ромын шүлэг зохиомжид урт, богино эгшгийн давтагдал хэмнэлийн зарчим болж байв. Үеийн шүлэгт мөр бүрийн үеийн тоо тэнцүү байх, үеөргөлтийн шүлэгт бол өргөлттэй, өргөлтгүй үеүд зөв зохистой ээлжлэн хослох нь хэмнэлийн зарчим болно.

**Метрика** — хэмнэлзүй. 1. Шүлгийн хэмнэлийн ерөнхий онцлог, тухайн хэлнийхээ хууль зүйгээс хамаарагч уг хэмнэлийн үндэсний шинжийг судалдаг шүлэг зохиомжийн ухааны нэг хэсэг.

2. Аль нэг үндэстний шүлэг зохиомжийн хэмнэлийн онцлогийг тэмдэглэнэ (эртний грек ромын хэмнэлзүй г.м.).

**Миф** — домог-үлгэр гэдэг нь өнө балар цагт үүссэн домог, ардын аман зохиолын эртний нэгэн зүйл болно. Домог-үлгэр нь байгаль, нийгмийн ба сэтгэхүйн олон үзэгдлийн утга учир, уг шалтгааныг, мөн тэдгээрийн өмнө өөрийн хүчин мөхсийг тайлгох, тайлбарлах гэсэн хүмүүсийн эрмэлзлийг тусгасан байдаг. Ийм

учраас домог-үлгэрт бодг тэнгэр нар заавал баатар нь болж гардаг, эсвэл тэнгэр нар биш ч гэлээ угтаа түүнийг л төлөөлсөн баатар дурслэгдсэн байдаг. Эртний хүмүүс тэнгэр дээдэс ертөнцийг бүтээсэн гэж төсөөлдөг байсан юм. Домог-үлгэрүүд нь ул ойлгоход хүчний өмнө хүн арчаагүй байдалтай байсныг төдийгүй бас амьдралын зүй тогтлын тухай таамаглал, аж байдлын туршлагыг тусгажээ. Домог-үлгэрт гэнэн цагаан уран сэтгэмжийн хэлбэрээр нийгмийн амьдрал, хүний сэтгэл зүйн хуулиудыг нээн гаргадаг юм. Дайсагнагч хүчинтэй хийсэн хүний тэмцэл мөн домог-үлгэрт туссан байна. Домог-үлгэр нь хэлбэрийн хувьд үлгэртэй ойролцоо, домогтой төсөөтэй байдаг. Гэвч өгүүлсэн зүйлээ ямагт тайлбарласан байдгаараа үлгэрээс ялгаатай, жинхэнэ баримтыг биш, санаанаасаа зохиосон зүйлсийг эш үндэс болгосон байдгаараа домгоос өөр юм. Ийнхүү домог шиг хэлбэртэй мөртөө үлгэр шиг зохиомол байдаг тул домог-үлгэр гэж монголын аман зохиолын судалгааны бүтээлүүдэд мифийг нэрлэх болжээ.

**Многосоюзие, полисиндетон** — холбоос олшуулалт. Өгүүлбэрийн зэрэгцэн орсон гишүүдийг бүгдийг нь буюу бараг бүгдийг нь нэг төрлийн холбоос үгээр холбож, тоочсон зүйлсийн хээ зорилго, нэгдлийг цохон заах ур маяг.

Дээр тэнгэр ханы аху хийгээд  
Дэлхий дэх хан бодгсын аху газар  
Дээр дорын ялгал болбоос бээр  
Жаргал хайрлад хоёрын агаараа нэгэн буй  
Агнистын агуй дахь бодисун нар хийгээд  
Алтан дэлхий дэх бодь сэтгэлтэй хоёрын  
Аху газар ангид болбоос  
Асрал нигүүлсэхийн агаараа нэгэн буй  
Олз идэш олон ядагч хүн хийгээд  
Уул модонд явагч араатан хоёрын  
Аху бие ангид болбоос  
Алан идэхийн агаараа нэгэн буй  
Хол ойр хулгай хийгч хүн хийгээд  
Хотыг эргэн гэтэгч чоно хоёрын  
Илт бие дүр өөр болбоос  
Идэх хүсэх сэтгэлийн агаараа нэгэн буй г.м.

(Цогт тайжийн хадны шүлэг)

**Модернизм** — эдүгээчлэх ёс гэдэг нь урьд үеийн урлаг, юуны гүруунд XIX зууны реализмтай харьцуулахад шинэ байдалтай, чухамхан XX зууны төрүүлсэн утга зохиол, урлагийн олон үзэгдлийг тэмдэглэдэг нэр томъёо. Ийм болохоор модернизм гэсэн ухагдахуунаар хааяа янз бүрийн реалист бус чиглэл, түүний доор төлөөлөгчид нь нийгмийн дэвшилттэй байр суурь баримталж байсан чиглэлийг ч (эүүн экспрессионизм, футуризм) тодорхой-

лох нь бий. Эдгээр чиглэл дэлхийн дайнууд, капиталзимын хямралын үеийн шийдвэрлэшгүй зөрчлүүдийн хахир хатуу уур амьсгалд, нийгэм, түүхийн нарийн ээдрээтэй шинэ нөхцөлд үүсэн бүрэлджээ. ХХ зууны бүх хурц зөрчлийг иж бүрнээр нь үзүүлэх гэсэндээ тэд уран сайхны онцгой арга хэрэглүүр эрж хайцгаадаг юм. Амьдралыг яруу тод үзүүлэх арга сувэгчлэх явцдаа уран бүтээлийнхээ янз бурийн шатанд модернист чиглэлтэй холбогдсон урлагийн гарамгай зүтгэлтэн олон бий (Зөвлөлтийн геатрыг шинэгээч В. Мейерхольд, францын зураач Пикассо, америкийн зохиолч В. Фолкнер г.м.).

**Монолог** — бодмоглол. Зохиолын баатар өөр баатарт хандаж хариу сонсох хүслээр биш, харин зөвхөн өөртөө юмуу жүжигт бол үзэгчдэд хандаж өөрийн санаа сэтгэлийг илэрхийлэн ганцаараа ярьсан яриаг бодмоглол гэнэ. Энэ нь жүжгийн зохиолд баатрын онцлог шинжийг үг яриатаар нь тодорхойлох нэг тохиromжтой арга байдаг. XIX—XX зууны үеийн хүүрнэл зохиолд баатруудын сэтгэл санааг харуулахын тулд «дотоод, бодмоглол» ыг их хэрэглэх болжээ.

**Мора** — түдэл. Эртний грек романын шүлэг зохиомжид үгийн богино үеийг дуудах хэвийн хэмжээ, шүлгийн шадад цагийг тоосоо хамгийн бага нэгж. Шадны бусад нэгжийг түдлийн давтамжаар тодорхойлно. Тухайлбал урт үе 2 түдэл, ямба өлмий гурван түдэл г.м. Мора гэдэг бол латин нэр гомъёо бөгөөд үүнтэй ижил утгатай грек хэлний протос (язгуур цаг), орос хэлний доя (хувь) гэсэн нэр томъёонууд бас байдаг.

**Мораль** — сургамж. Егт улгэрийн төгсгөлд (хааяа эхэнд) байдаг зан суртахууны дүгнэлт бүхий мөр, бадаг.

**Мотив** — сэдэл. Зохиолын эхийн агуулга-хэлбэрийн тогтвортой бүрэлдэхүүн хэсэг, нэг зохиолчийн нэг юмуу хэд хэдэн зохиол болон түүний нийт уран бүтээл, мөн утга зохиолын аль нэг чиглэл юмуу тодорхой нэг үеийн утга зохиолоос сэдлийг ялган авч үзэж болно.

Александр, Н. Веселовский, В. Я. Пропп нарын бүтээлд ХХ зууны эхнээс сэдлийг утга зохиол шинжлэлийн ай болгон судалж эхэлжээ. Тэд сэдлийг өгүүлэлмжийн салгашгүй хэсэг-дурслэгдэхүүн, дүр, аман зохиолын өгүүлэгдэхүүний хамгийн бага нэгж (шидэг толь, тэнэг эхнэрийн дүр, эцэг нь хүүтэйгээ тулалдсан нь, гүнжийг могой хулгайлсан нь) гэж үзжээ. Зарим төрөл зүйл, ялангуяа хатуу тогтсон төрөл зүйлс өгүүлэгдэхүүний тогтвортой сэдэл бүхий байдаг байна (их тууль, адал явдлын романд бол тэнүүчлэл, онгоцны сүйрэл, туурьт бол урвагч морь, зөнч хэрээ г.м.).

Хожим нь сэдлийг зохиолчийн онцлог, түүний ертөнцийг үзэх үзэлтэй, мөн зохиолын бүхэл бүтэн бүтцийн задлан шинжлэлтэй

холбож үзэх болжээ. Сэдэл сэдэв хоёрыг адилтгаж үзэх явдал бас нэлээд дэлгэрчээ.

**Надпись** — бичээс. Сүм хийд, орд харшийн хана, гэрэлт хөшөө, элгэн хад тэргүүтэнд сийлсэн эртний (Египет, Ассир-Рави-лон, Перс, Грек зэрэг орны) уран зохиолын нэгэн зүйл дурсгал. Монголд Цавчаал боомтын хаалган дээрх бичээс, Цогт тайжийн хадны бичээс зэрэг уран шулэг уламжилж иржээ.

Бас баримал, хөрөг, ном, зургийн цомог тэргүүтэнд бичиж үл-дээсэн щүлгүүдийг бичээс гэнэ.

**Направление и течение литературные** — уран зохиолын чиглэл, урсгал гэдэг нь олон зохиолч хэд хэдэн бүлэглэл, дэгийн уран бүтээлд хэвшмэл байгаа оюун санаа, агуулгын ба гоо зүйн тулгуур зарчмуудын нийлбэр цогц, мөн эдгээр чухал зарчмуудыг нэхцэлдүүлсэн уран бүтээлийн мөрийн хөтөлбөрийн чиг зорилго, сэдвийн хүрээ, төрөлзүйл, найруулгын тохирох нийцэх талуудыг багтаасан ойлголт юм. Чиглэл, урсгалуудын өрсөлдөөн тэмцэл, халаа сэлгээнд утга зохиолын явцын зүй тогтол туйлын тод илрэнэ. Эдгээр нэр томъёог янзаар тайлбарлан хэрэглэж байна. Заримдаа ижил утгаар хэрэглэж, заримдаа урсгалыг утга зохиолын дэг юмуу бүлэглэлтэй, чиглэлийг уран сайхны арга юмуу найруулгатай адилтгаж байна.

Хамгийн их дэлгэрсэн үзэл ёсоор бол чиглэл гэдэг нь соёл-уран сайхны уламжлалын нэгдэл, зохиолчийн ертөнцийг ойлгох ойлголт ба өмнө нь тулгарсан амьдралын асуудлын нэг хэв маяг, эцсийн бүлэгт цагийг эзэлсэн нийгмийн болон соёл-түүхийн нэхцэл байдлын төсөөтэйн улмаас буй болсон уран сайхны агуулгын оюун санаа-гоозүйн гүн үндсийн нийтлэгийг хэлнэ. Гэхдээ нэг чиглэлд хамарагддаг зохиолчдын тавьсан асуудалдаа хандах хандлага, түүнийг шийдвэрлэх арга замын тухай төсөөлөл, үзэл санаа, уран сайхны цогц үзэл, туйлын хүслэн нь өөр өөр байж болдог. Жишээ нь ертөнцийг ойлгох романтик ойлголтын үндэс нь нэг талаас соён гэгээрүүлэгчдийн туйлын хүслэн, орчин үеийнхээ бодит байдал, нийгмийн дэвшлийн хэтийн төлөвт урам хугарсан явдал; нөгөө талаас бүхнийг хамарсан сайн сайхны туйлд хүрэхийн хүслэн, бүх нийтийн, үнэмлэхүй туйлын хүслэнгээрмэлzsэн их эрмэлзэл байв. Гэвч романтик зохиолчдын «мөрөөдлийн» тодорхой агуулга харилцаан адилгүй — нэг хэсэг нь нийгмийн амьдралыг үндсээр нь өөрчлөн байгуулахыг хүсч байхад (Ж. Байрон, П. Б. Шелли, Ж. Санд, А. Мицкевич, Ш. Петефи), нөгөө нь шашин (Ф. Р. Шатобриан, А. Ламартин, В. А. Жуковский), урлагаас (Иений романтикууд, Э. Т. А. Гофман) байгальтай нийлэх, ардын хуучин ёсонд эргэж орох явдлаас аврал эрж байв (В. Вордсворт, гейдельбергийн романтикууд). Энэ хувьдаа чиглэл нь бүрэлдэхүүндээ багтагчдаас үзэл санаа-уран сайхны талаар шууд адил бөгөөд гоозүй-мөрийн хөтөлбөрийг нэгдэлтэй

байхыг шаарддаг утга зохиолын бүлэглэл, дэгээс, мөн өөрийн нь салбар буюу ялгамжит хэлбэр болох урсгалаас ялгаатай (Ж. нь оросын романтизмын «гүн ухаан», «сэтгэлзүй», «иргэний» урсгалууд гэхчлэн ярьдаг билээ).

Народность — ардач чанар. Нийгмийн өргөн хүрээнийхийн оюуны сонирхолтой сёёлын уламжлал, хамгийн ардчилсан давхрааны туйлын хүслэнтэй нягт холбогдсон зохиол бүтээлийн үзэл санаа уран сайхны чанар. Урлаг, утга зохиолын ардач чанар нь олон утгатай ухагдахуун болно.

1. Хувийн бүтээл хамтын бүтээлийн харьцааг болон аман зохиолын сэдэв, дүр, туурвил зүйг мэргэжлийн урлаг, утга зохиолд хэр бүтээлчээр өвлөн авсныг;

2. Ард түмний дүр төрх, ертөнцийг үзэх үзлийг уран зохиолд хэр гүнзгийн үнэн тусгасныг;

3. Урлаг гоозүйн болоод нийгмийн талаар олон түмэнд хэр ойлгомжтой байгааг тус тус годорхойлно.

Ардач чанар гэсэн ойлголтыг XVIII зууны гүн ухаантнууд (Монтецкье, Гердер) нээж, анх хамгийн өрөнхий хэлбэрээр төмъёолжээ.

Натурализм 1. XIX зууны сүүлчээр Европ, АНУ-ын утга зохиолд үүсч бүрэлдсэн уран сайхны чиглэл. Энэ чиглэлийн толгойлогч, онолч нь францын зохиолч Э. Золя байжээ. Бусад оронд төрсөн томоохон натуралист зохиолч гэвэл германы зохиолч Г. Гауптманыг нэрлэж болох юм. Натуралистиуд бодит байдал, хүний зан занарыг бодьтой тодорхой, яг байгаагаар нь дурслэхийг эрмэлздэг, байгаль шинжээч байгалийг судалдаг шиг нийгмийг мөн тийм бүрэн төгс судлахыг зорьдог байв. Тэд уран сайхны танин мэдэхүйг шинжлэх ухааны танин мэдэхүйтэй адилтган үздэг байжээ. Э. Золя гадаад орчныг үзүүлэхдээ ч, биологийн бүтээгдэхүүн амьтан болсон хүнийг дүрслэхдээ ч шинжлэх ухаан шиг нягт нарийн байхыг шаарддаг байв. Натуралистиуд удамшиг ёсыг их ач холбогдолтойд тооцоод биологийн хууль хүнд хэрхэн нөлөөлж байгааг үзүүлэх замаар нийгмийн амьдралын зураглалыг өргөтгеж, гүнзгийрүүлэх хэрэгтэй гэж үзжээ. Ийнхүү тэд хүмүүсийн зан байдлыг тайлбарлахдаа нийгмийн ба биологийн шалтгааныг нэг төвшинд тавьснаараа уран сайхны өрөнхийллийн хүчийг гүнзгийрүүлсэнгүй харин ч сулруулжээ. Хөрөнгөтний нийгмийн төрүүлсэн дутагдал согог, гэмт хэргийг муу удамшилаар тайлбарлах нь цөөнгүй байв. Гэхдээ натурализмын шаардлага дагуу амьдралын үнэн утга зохиолд их нэвтэрсэн нь уран сайхны гойд хүч, нөлөө бүхий зохиолууд нилээд гарахад хүргэжээ. Бас натуралистиуд гоёж будаагүй үнэнийг үзүүлэхийг шаардан, зохиолч хүнд хориотой сэдэв нэг ч байхгүй гэж зарласнаа-

раа уран зохиолын сэдвийн хүрээг өргөжүүлсэн нь эргэлзээгүй юм.

2. Явцуу утгаар зохиолын аль нэг хэсэгт хэрцгий догшин үйлдэл, хүний амьдралын физиологийн талыг ил шууд, хэтэрхий тодорхой дүрсэлснийг бас натурализм гэж нэрлэдэг.

**Научная фантастика** — шинжлэх ухааны уран сэтгэмжийн зохиол. Уран сэтгэмжийн утга зохиолын үндсэн хэсгийг тэмдэглэх нэр томъёо. Уран сэтгэмжийн зохиолын гол зорилго бол шинжлэх ухаан-техникийг сурталчлах явдал гэж үзэж байсан ХХ зууны 30—50-иад оны үед энэ нэр томъёо тогтжээ. Угтаа уран сэтгэмжийн зохиол нь шинжлэх ухааныхаас гадна бас шинжлэх ухааны бус уран сэтгэмжийн зохиол ч гэж бий. Жишээ нь үлрэр, домог-үлгэрийн сэдэв, хэлбэрийг ашиглан бичсэн шинжлэх ухааны бус уран сэтгэмжийн зохиол байдаг.

Манай судлаачид шинжлэх ухааны уран зөгнөлийн зохиол гэсэн нэр томъёог их хэрэглэгдэг боловч энэ нь төдий л оновчтой биш. Уран сэтгэмжийн зохиол бүрд ирээдүйг урьдчилан харсан буюу зөгнөсөн зүйл байдаггүй билээ. Шинжлэх ухааны уран сэтгэмжийн зохиолын нэг гол зорилго нь амьдралд шинжлэх ухаан техникийн хувьсгалын оруулсан өөрчлөлтөд хүмүүсийн ухамсарыг бэлтгэх явдал мөн.

Гэхдээ ХХ зуунд шинжлэх ухааны уран сэтгэмжийн зохиол эрчимтэй хөгжсөн нь нийгмийн дорвitoй ахиц дэвшлээр их төлөв тодорхойлогоно. Тиймээс шинжлэх ухааны уран сэтгэмжийн зохиолд гол анхаарал шинжлэх ухаан техникт биш харин хүн төрөлхтний үзэж өнгөрүүлж байгаа их өөрчлөлтийн нийгэм, улс төр, зан суртахуун, сэтгэл зүйн үр дагаварт ханджээ. Шинжлэх ухааны уран сэтгэмжийн зохиол уншигчдад ирээдүйн олон загварыг толилуулсан юм. Орчин үеийн шинжлэх ухааны уран сэтгэмжийн уг эх Т. Мор, Т. Кампанелла, Сирено де Бержерак нарын сонгодог үл гүйцэлдэх үзлийн зохиол, Ф. Рабле, Ж. Свифт болон XIX зууны зохиолч Э. По, Мэри Шелли, М. Твен, Р. Стивенсон, А. К. Дойл нарын зохиол, ялангуяа Ж. Верний шинжлэх ухаан-техникийн уран сэтгэмжийн романуудаас тод харагддаг. Орчин үед А. Н. Толстой, М. А. Булгаков, А. Р. Беляев, Г. Уэллс, А. Кларк Ж. Уиндем, Веркор, Р. Мерль нарын зэрэг зохиолч олон гарамгай уран сэтгэмжийн зохиол бичжээ.

**Неологизм** — шинэ уг. Амьдралд (шинжлэх ухаан, техник, соёл, ахуйд) шинэ ухагдахуун гарч ирсэнтэй холбогдон үүссэн уг. Уран зохиолд зохиолч нар шинэ уг зохион нэвтрүүлэх нь бий. Тэр шинэ уг нь зөвхөн тухайн зохиолд хэрэглэгддэг боловч хааяа хэрэглээний уг болж хувирдаг.

**Новаторство** — үз: традиция и новаторство.

**Новелла** — туурь. Өгүүллэг, туужтай ойролцоо бага шиг хэмжээний хүүрнэл зохиолын зүйл. Их төлөв нэг юмуу хэд хэдэн

хүний амьдралын нэг, хоёр төхийлдлыг дурслэнэ. Энэ нь голцуухан хүрц, этгээд сөнин өгүүлэгдэхүүнтэй байдаг. Гетегийн хэлсэнчлэн «туурь нь ...шинэ, үзээгүй явдал» юм. Туурь сэргэн мандалтын үед европын утга зохиолд бий болжээ (Ж. Бонкаччо Ж. Чосер, Маргарита Наварская, М. Сервантес). Сүүлд Э. Т. А. Гофман, П. Мериме, Э. По, Ги де Мопассан, О. Генри, С. Цвейг, Г. Бёлль, Ф. О. Коннор, А. Зингер, А. П. Чехов, И. А. Бунин, А. Грин, М. М. Зощенко нарын бүгээлд цаашид үлам хөгжжээ.

**Образ** — дүр гэдэг нь бодит байдлыг урлагт тусгах хэлбэр уран сэтгэмжийн үрээр бүтсэн, гоозүйн ач холбогдол бүхий хүний амьдралын тодорхой бөгөөд үүний хамтаар бас нэгтгэн ерөнхийлсэн зураглал болно. Уран дүр бол өртөнцийг танин мэдэж, хувиргах арга хэрэглүүрийн нэг, уран бүтээлчийн бодол санаа, эрмэлзэл тэмүүлэл, гоо зүйн сэтгэл хөдлөлийг тусган илэрхийлэх нийтлэг хэлбэр мөн. Үндсэн үүрэг нь гэвэл танин мэдүүлэхүйн, харилцааны, гоо зүйн болон хүмүүжлийн ач холбогдолтойд буй.

Урлагт дүр гэдэг ойлголт их төлөв хүнийг дурслэхэд холбогдоно. Энэ утгаар, дүр гэж зохиолд гарч байгаа хүнийг хэлнэ («Тунгалаг тамир» романы Эрдэнийн дүр, «Тожоо жолооч» жүжгийн тооромсог Төмөрийн дүр г.м.). Гэхдээ хүнийг дангаар нь зохиолд үзүүлдэггүй, байгаль, нийгмийн орчин, амьдрал дунд дурсэлдэг тул дүр гэдэг нь хүний амьдралын зураглал мөн гэж тодорхойлох нь бий.

Орчин үеийн утга зохиолын судлал, шүүмжлэлийн бүтээлд дүр гэсэн нэр томъёог явцуу болон өргөн утгаар хэрэглэж байна. Тухайлбал дурслэг хэллэгийг ч (туулайн гүйдэл шиг салхинд Туулын шугуй найгана) дүр гэж нэрлэж байна. Ийм тохиолдолд үгийн дүр (словесный образ) гэж тодорхойлох нь зүйтэй юм. Бас дүр гэсэн ухагдахууныг хэт өргөсгөн эх орны дүр, ард түмний дүр гэхчлэн ярих нь бий. Үүний оронд ард түмний (эх орны г.м.) тухай сэдэв, асуудал гэхчлэн хэлэх нь зохимжтой гэж зарим судлагч үздэг.

**Образ автора** — үз: Образ повествователя

**Образ повествователя** — өгүүлэгчийн дүр, зохиогчийн дүр (образ автора), хүүрнэгчийн дүр (образ рассказчика) гэдэг нь зохиолын баатруудын аль нэгний яриатай холбоогүй боловч өгүүлэмжийн явцад тодорхой уран сайхны ач холбогдолтой зохиолын тийм хэлний онцлогийг тэмдэглэхэд хэрэглэдэг ухагдахуун. Зохиолын хүүрнэгч бол өөрийн зан чанарын онцлогийг илтгэсэн өвөрмөц яриатай хүн байх бөгөөд тэр нь өөрийнхөө тухай, бусдын тухай, нүдээрээ үзсэн, биеэрээ оролцсон хэрэг явдлынхаа тухай ярьж байгаагаар зохиолд гардаг. Жишээ нь М. Шолоховын «Хүний хувь заяа» өгүүллэгт өөрийнхөө амьдралыг Андрей Со-

колов ярьж байхад Пушкины «Ахмадын охинд» Гринев өөрийн биеэр үзсэн хэрэг явдлын тухай тэмдэглэлээрээ өгүүлж байна. Зарим зохиолд өгүүлэгч нь зохиогч өөрөө байдаг.

Образ рассказчика — үз. Образ повествователя

Обрядовая поэзия — зан үйлийн яруу найраг. Хүмүүсийн ёс заншил, зан үйл, баяр ёслолтой холбоотой аман зохиолын зүйлсийг хэлнэ. Цаг улирлын, хурим найрын, гэр ахуйн, хөдөлмөрийн, шүтлэг бишрэлийн гэхчлэн янз янзын зан үйл байдаг тул тэдгээрийг гүйцэтгэхтэй холбогдсон ерөөл, магтаал, бэлгэ дэмэрлийн угс, дуу зэрэг олон зүйлийн аман зохиол байдаг. Ийм аман яруу найргийн эртнээс уламжлалтай, ихэд боловсорсон дээжис нь уран зохиолд уг хэлбэрээрээ ашиглагдахаас гадна агуулга, хэлбэрийн талаар тодорхой нэлэөтэй.

Ода — магтаал. Жавхлантай, хөгжүүн, сургамжлангуй шинжтэй уянгын шүлгийн нэгэн зүйл. Эртний урлагт бүжиг бүхий найрал дуу байжээ. Үндэсний магтаалын тухай үз: Магтаал.

Оксиморон, оксюморон — эсрэгцүүлэл. Эсрэг тэсрэг утгатай угсийг хослуулж, шинэ ойлголт, төсөөлөл бий болгодог найруулгын ур маяг, нэгэн зүйл сөргүүлэл. Өрөвчхөн хулгайч, ухаантай тэнэг, хуурай дарс, доголон нулимтай нийнээд, хүний эрхэнд жаргахаар өөрийн эрхээр зовсон дээр г.м.

Уран зохиолд эсрэгцүүллийг нэлээд ашиглана.

Мөнгөн хазаарын будэг чимээ

Онгон зүрхийг зочоон баясгана

Б. Явуухулан, «Мөнгөн хазаарын чимээ»

Нуур шиг баян хэлээрээ та

намайг тэжээж

Нугарахгүй уян сэтгэлээрээ та

намайг хуяглалаа

Ц. Гайтав, «Ард түмэндээ»

Зарим зохиолын нэр эсрэгцууллээс бүтсэн байдааг: «Амьд хүүр» (Л. Толстой), «Хар цас» (Д. Пүрэвдорж) г.м.

Олицетворение — амьдчилал Амьгүй юмыг амьтай мэт болгон дурслэхийг амьдчилал гэнэ. Д. Нацагдоржийн «Од» шүлэгт:

Холхи газраас гялалзан харагдх өнгөт од оо-

Хязгааргүй огторгуйн дунд зугаалсан олон улаан оч оо!

Нарт ертөнцийн дотор суугаа марс од оо!

Манай хүн төрөлхтөн чамтай танилцахыг хэдийнээс хүсэв

гэх мэтээр яруу найрагч одонд хандан өгүүлж байгаа нь даруй амьдчилал болно. Энэ аргыг Монголын эртний уран зохиолд мөн өргөн хэрэглэдэг байв.

Омонимиы — ижил нэр гэж адилхан дуудагдах, бичигдэх боловч өөр өөр утгатай угсийг хэлнэ. Жишээ нь «Тал» (хээр, ха-

гас, бүлэг), булаг (чихний булаг, усны булаг), өрөм (сүүн өрөм, өрөмдөх багаж г.м.). Шог хошин зохиолд үгээр наадах (Каламбур) ижил нэрийг их ашигладаг.

**Очерк** — найруулал. Баримтат үргэлжилсэн зохиолын зүйлийн нэг хэлбэр. Зохиолчийн өөрийн нь үеийн амьдрал, барим хүмүүст гол төлөв зориулагдана. Үүний сацуу найруулал амьдралыг дүрээр тусгадаг онцлогийг хадгалдаг бөгөөд энэ талаараа өгүүллэгтэй ойр.

**Памфлет** — хочлол. Нийтлэл, шоглолын утга зохиол дахь илчлэн шүүмжилсэн агуулгатай зохиол. Хочлол нь орчин үеийн хээ чухал асуудлыг хөнддөг, бөдит баримтыг өргөн ашигладаа бөгөөд тухайн үеийнхээ улс төр, нийгэм, соёлын амьдралын гэснэгогийг хайр найргүй шүүмжлэн тэр дутагдлын биет эзээд, тэгэхдээ нөлөө бүхий төлөөлөгчдийг нь (нэртэй нам, улс төр, сүм хийдийн зүтгэлтнүүд, зохиолчид, эрдэмтэд) шууд нэрлэдэг онцлогтой. Эразм Роттердамский (Тэнэгийн магтаал, 1509), Ж. Свифт (Төрхны үлгэр, 1704), Ф. Вольтер, Г. Гейне, В. Гюго, А. Франс, А. Радищев, А. Герцен, В. Белинский, М. Горький нар дэлхийн томоохон хочлол бичигчид байжээ. Монголын уран зохиолд Л. Түдэвийн «Хөрөнгөтний биеийн байцаал» тэргүүтэн өгүүлэл, Д. Маамын «Гишгэх газаргүй хөл», С. Лочингийн «Сүйрэл» роман зэрэг хочлолын зүйлчлэлд хамаарах зохиолууд гарчээ.

**Парабола** — ёгт өгүүллэг. Сургамжийн агуулгатай ахархан ёгт өгүүллэг.

**Параллелизм** — зэрэгцүүлэл. Хоёр буюу хэд хэдэн өгүүлбэр (эсвэл тэдгээрийн зарим хэсгийг)-ийг нэг ижил байгуулалтаар бүтээж давтсаныг зэрэгцүүлэл гэнэ. Зэрэгцүүллийг ялангуяа ардын аман зохиолд өргөн ашигладаг байв.

Морин чих хоёрхон шүү  
Мордохын хундага гуравхан шүү  
Үнэгэн чих хоёрхон шүү  
Үдлэгийн хундага гуравхан шүү (Хөөлгийн дуу)  
Дашмагтайхан архинд нь  
Дашуурс хийсэн аваа уу даа?  
Даш л вандан хадагт нь  
Олзуурхас хийсэн ээж үү дээ?  
Хөнөгтэйхэн архинд нь  
Хөлчүүрс хийсэн аваа уу даа  
Хөл вандан хадагт нь  
Олзуурхас хийсэн ээж үү дээ

(Халх ардын дуу «Дашмагтайхан архи»)  
Цээлэнд байгаа загасыг  
Сэрээн төмөр хатгана  
Цээжинд байгаа үгийг

Шилтэй архи хатгана  
Нууранд байгаа загасыг  
Нуруун төмөр хатгана  
Нууцгай байсан үгийг  
Лонхтой архи хатгана

(Ардын ерөөлч Ч. Жигмэд «Архины шог»)

Монголын орчин үеийн яруу найрагт энэ уламжлалт арга мөн  
ур дүнтэй хэрэглэгдэж байна.

Холбоо хоёр нум  
Хотос хотос хийнэ  
Солбио хоёр хол  
Тахис тахис гүйнэ  
Ядуу тэрэгчний хөл дор  
Хүйтэн зам урсана  
Ямбатай эрийн хөл дор  
Хүний хөлс урсана

(Б. Явуухулан, «Сохор зоосны дууль»)

**Пародия** — элэглэл. Өөр зохиол, зохиогч юмуу урсгалыг дуурайж элэглэсэн бүтээл. Элэглэлд эх зохиолыг урвуулан өөрчилж, дуурайн шоглосон эрхэмсэг уран хэллэгийг нь бүдүүн хадуун инээдэмтэй хэлээр орлуулсан байдаг. Дэлхийн утга зохиолын алдарт элэглэл болох Серванtesын дон Кихот-д рыцарийн романаыг билгүүн сайхан элэглэсэн юм. Үүнд залуу язгууртан рыцарийн оронд хөгшин харинги, доорд гаралтай этгээд гажиг зантай Дон Кихотыг, үзэсгэлэнт хатагтайн оронд бүдүүн борог малчин бусгүй Альдонса лоренсаг, хөлөг морины оронд туранхай муу адсагыг дурсэлсэн байна.

**Пасквиль** — дайрал. Аль нэг хүн, бүлэг хүн, нэм, нийгмийн хөдөлгөөний нэр хүндийг унагах, доромжлох зорилгоор хорсон дайрч давшилсан агуулгатай зохиол. Үүнийг их төлөв улс төрийн дайснаа гутаах хэрэглүүр болгон ашигладаг. Дайрал нь илчлэн шүүмжилэх арга маягаараа хочлолтой ойр боловч уран зохиолын «хуульчлан зөвшөөрсөн» төрөл зүйл бишээрээ түүнээс эрс ялгаатай.

**Пейзаж** — байгалийн зураглал. Энэ нь зохиолчийн найруулга, утга зохиолын чиглэлээс хамааран уран сайхны янз бүр утга учиртай байна. Байгалийн зураглал нь уянгын зохиолд бие даасан утгатай, уянгын баатар байгалийг хэрхэн тусган ойлгож байгаагийн илэрхийлэл болдог бол ургэлжилсэн үгийн зохиолд өгүүлээмжийн шинж чанартай холбогдсон, баатруудын сэтгэл санаатай зохицсон байна.

**Пеон** — Пеон, бадранга өлмий. Эртний грек, ромын шүлэгт гурваан бөглийс, нэг урт үет өлмий.

**Перипетия** — огцом эргэлт. Зохиолын уйл явдлын хэвийн өрнөлийг хүндрүүлсэй санаандгүй явдал, оттуягэгдхүүний огцом.

Эргэлт.

Перифраза перифраз — тойруулал. Юм үзэгдлийн нэрийг тэдгээрийн өвөрмөц шинжийг тодорхолсон, зуршмал онцлогийг нь заасан хэллэгээр орлуулах найруулгын арга. Жишээ нь Д. Нагцагдоржийг «Миний нутгийг зохиогч», Монголыг хөх тэнгэрийн орон, арсланг араатны хаан гэхчлэн нэрлэх нь тойруулал болно.

Уран зохиолд ийм дүрслэг хэл-лэгийг өргөн ашиглана:

Андын урт нуруу шиг  
Асар урт  
Андын өндөр нуруу шиг  
Аймшигт өндөр  
Тэнгэрлэг сайхан  
Тэр орон  
Нерудын орон  
Найгийн орон  
Альяндын орон  
Амгалан орон

(П. Нямдорж «Нерудын брон Чили»)

Персонаж—баатар, гарах хүн, амьтан, бодгаль. Уран зохиолд гарах хүн, амьтан, зохиолын баатар.

Персонификация—хүнчлэл. Амьгүй юм, үзэгдэл, хийсвэр ойлголтыг амьд хүний хэлбэрээр үзүүлэх арга. Жишээ нь:

Салхи тэнгистэй наадаж  
Сайхан нойрыг нь сэргээнэ  
Хөх тортон хөнжил нь  
Хөвчилж байх шиг карагдана  
Хөнжил дотроо тэнгис  
Хүрхэрч байх шиг дуулдана  
Салхи тэнгис дээр бүжиглэнэ  
Сайхан хөнжлийг нь гишиглэнэ  
Бас унтах гэж оролдоно  
Салхи исгэрэн бүжиглэсээр  
Сайрхаж дээр нь гишиглэсээр

(Д. Сэнгээ, «Салхи тэнтис хоёр»)

Егт үлгэрт гарах амьтад хүнчлэлийн аргаар дүрслэгдсэн, хүний зарим шинжийг шингээсэн байdag. Хүнчлэл нь амьдчилалтай ойр төстэй.

Песня—дуу. Үг, аялгуут урлагийн нэт хэлбэр. Аман зохиолд үг, аялгуу нь зэрэг бий болж байхад утга зохиолд их төлөв шүлэг нь эхэлж зохиогдоод хожим түүнд аяхийдэг байна. Монгол ардын дуу нь аялгууны хувьд уртын дуу, богино (завхай) дуу гэж хуваагдана. Ардын дуу нь сэдвийн талаар маш олон янз бөгөөд бас хэлбэр, үүргийн хувьд ч дотор нь хэд хэд ангиж болно. Манай орчин үеийн зохиолчид дууны урлагийг хөгжүүлэхэд их хувь хандив оруулж байна. Монголын нэрт яруу найрагч Ц. Дам-

динсүрэн, Б. Явуухулан нарын олон шулэгт хөгжмийн зохиолчид ая хийсэн нь эдүгээ олон нийтийн дуртай дуу болж хувирчээ.

**Пиррихий—Пириг** өлмий. Эртний грек ромын шулэгт хоёр богино ует өлмий, үе-өргөлтийн шулэгт бол ямб, хорей өлмийн дунд дараалан орсон хоёр өргөлтгүй үеийг хэлнэ.

**Плагиат** —зохиолын хулгай. Бусдын зохиолыг юмуу зохиолын хэсгийг дур мэдэн авч өөрийн нэрээр (буюу нууц нэрээр) нийтлүүлэх. Дэлхий дахинд ийнхүү хүний бүтээлээс (уран зохиол болон шинжлэх ухааны бүтээлээс) хулгайлахыг хуулиар хориглодог.

**Плеоназм**—нуршилт. Ойролцоо уг, хэллэгийг давтан нурших, илүүц тодотгол хэрэглэхийг хэлнэ. Жишээ нь бид өдөр тутмынхаа ярианд үзэж, харах, ой мод, зам харгуй, гэр гэрлэх, түргэн алхаагаар алхах, нудээрээ үзэх тэх мэтийн хэллэг хэрэглэдэг нь ларуй нуршилт болно. Нуршилтыг бас найруулга зүйн арга хэрэглүүр болгон ашиглах нь бий.

Аморэ, Аморэ, амрагхан Аморэ.

Алс Сорентад бид уулзаагүй ээ, Аморэ

(Б. Явуухулан, «Аморэ»)

**Повествование**—өгүүлэмж, үз: Образ повествователя.

**Повесть**—тууж, Үйл явдлынхаяа өрнөлийн шинжээр роман шиг дэлгэр биш боловч өгүүллэгээс нэлээн нарийн төвөгтэй байдаг хүүриэл зохиолын нэгэн төрөл зүйл. Тууж нь голчлон үргэлжилсэн угээр байх боловч бас шүлэглэсэн тууж бичих нь бий (Жишээ нь Р. Чойномын «Залуу нас»). Тууж нь ихэвчлэн зохиогч юм уу баатар нь өөрөө өгүүлсэн нэг хүний амьдралын тух байна. Гэхдээ тэр хүний амьдрал нь бусад хүмүүсийн амьдралтай харилцан шүтэлцсэн байдаа дурслэгдэнэ.

**Полисиндетон**—үз: Многосоюзие

**Положительный герой**—эерэг баатар. Эерэг сөрөг баатар гэдэг нь хэдийгээр харьцангуй ойлголт, ялангуяа орчин үеийн реалист урлагт хүний зан чанарын нарийн зөрчилтэй талуудыг их бодтой дурслэх болсон нэхцэлд ийнхүү хуваах нь төвөгтэй, зарим тохиолдолд маргаантай хэрэг боловч энэ нь дэлхийн утга зохиолын олон зуун жилийн туршлагаар хэвшсэн нэлээд үндэстэй ухагдахуун юм. Эерэг баатар гэдэг нь чухамдаа тухайн үеийнхээ тэргүүний хандлага, зан суртахууны шилдэг чанарыг илэрхийлэгч байдаг тул хүмүүжүүлэх ач холбогдолтой. Зохиолч зерэг баатрын дурийт бүтээнээр нийгмийн хөгжлийн зорилго, тэдгээр зорилгод хүрэх арга замыг нээн харуулна.

Нийгмийн түүхэн хөгжил нь нийгмийн туйлын хүслэнгүүдийт өөрчилж байдаг учир эерэг баатар нь чухамхан өөрийн уетэй ямагт холбоотой байна. Эртний грек, ромын уран зохиолын баатрууд, домог-улгэрийн ойлголт төсөөллийг тусгасан байдаг; баатрын ёс суртахууны гавьяаг тагцхүү тэр-үеийн сэтгэлгээний онц-

лог, ёс заншлыг харгалзаж гэмээ нь ойлгох болно (Жишээ и Софоклын Эдип хаан, Антигона). Дундат зууны үед бол баатар тайж нарын-эр зориг, эзэндээ үнэнч чанарын үүднээс эерэг баатрыг узүүлдэг байв (Роландын дуулал). Сэргэн мандалтын үе нь хүмүүнлэг үзэлт баатрыг гаргаж иржээ. Шекспир Сервантес мэтийн зохиолчдын хувьд бол баатруудын бодол, үйлдэл хүн нийгмийн агуулгатай байх нь гол зүйл байв.

**Пословицы и поговорки**—зүйр, цэцэн угс. Аман зохиолын төрөл зүйлс. Амьдрал, хөдөлмөрийн явцад ажиглаж мэдсэн зүйлээ сургамж болгох зорилгоор цөөн уран угзэр илэрхийлсэн онч мэргэн хэллэг. Зүйр, цэцэн угсийг зохиолч хүн өөрийнхээ болон баатрынхаа уг ярианд тодорхой зорилгоор ашиглана. Жишээ нь: «Монголын нууц товчоонд»: «Бие тэргүүт дээл захт»; «Өлөнд хучивч ухэр үл идэх, өөхөнд хучивч нохой үл идэх»; «Сүүдрээс өөр нөхөргүй, сүүлнээс өөр ташуургүй» г. м. олон тооны цэцэн уг таарадаж байна.

**Постоянный эпитет**—тогтмол чимэг уг. Ардын аман зохиолын тогтвортой хэрэглэдэг уран тодотгол. Юм үзэгдлийг тодорхойлсон ийм тодотгол их төлөв тэмдэг нэрээр илрэх боловч хааяянаас угсийн өөр аймгаар ч байж болдог. «Саруул» тал, «хөх» тэнгэр, «уужим» сэтгэл, «алтан» нар, «мөнгөн» сар г. м.

**Поззия**—яруу найраг. Уран зохиолыг бүхэлд нь шулгээр бичдэг байсан эрт үед уран зохиолыг ерөнхийд нь ингэж нэрлэдэв байжээ. Сүүлд үргэлжилсэн үгийн уран зохиол үүссэн хойно шүлэглэсэн зохиолыг тэмдэглэх нэр томъёо болжээ.

**Поэма**—найраглал. Уянга-туульсын зохиолын нэгэн зүйл Хууринэл юмуу уянгын өгүүлэгдэхүүнтэй том хэмжээний шулэглэсэн зохиол. Нэг гол онцлог нь гэвэл уянгын баатар найраглалад гарч байгаа хүмүүсийн зан чанарыг тодорхойлоход хөндлөнгөөс идэвхтэй оролцдог байна. Энэ нь баатруудын амьдралын замналыг дэлгэрэнгүй дурслэхээс зайлсхийж, нэг талаас зохиолыг их товч авсаар болгох, нөгөө талаас бодол сэтгэлийн дурслэлээр онцгой баяжуулах бололцоог олгоно.

**Поэтика**—туурвил зүй. Утга зохиол шинжлэлийн нэн эртний салбар. Уран зохиолын тансаг яруу илэрхийллээс арга хэрэглүүрийн тогтолцоог судлах ухаан.

1. Өргөн утгаар «утга зохиолын онолыг» хэлнэ.

2. Арай явцуу болоод нийтэд дэлгэрсэн утгаар бол найруулга зүй, өгүүлэгдэхүүний зүй, шүлэг зохиомжийн асуудлыг үздээ «Утга зохиолын онолын» нэг хэсэг.

3. Энэ нэр томъёог мөн тодорхой зохиолчийн уран бүтээл (Пушкины туурвил зүй), төрөл зүйл (романы туурвил зүй), арга (реализмын туурвил зүй) тэргүүтний онцлогийг судлахад олон таа хэрэглэдэг. Энд уг нэр томъёо дээр дурдсан өргөн, явцуу аль ч утгаараа ойлгогдно.

Приключенческая литература — адал явдлын уран зохиол. Хүрд үйл явдал, хувийн ба нийгмийн амьдралын ширүүн зөрчлийг зугаатай сонин байдлаар үзүүлсэн уран зохиол. Шинжлэх ухааны уран зөгнөл, хэрэг мөрдөлт, аялал жуулчлалын сэдэвтэй нягт холбоотой. Ф. Купер, Ф. Марриэт, А. Дюма (эцэг), Э. Сю, Т. М. Рид, Р. Л. Стивенсон, Р. Хаггард, Ж. Конрад, Г. Эмар, Ж. Верн, П. Бенуа, Ф. Брет, Гарт, Ж. Лондон, А. С. Грин, В. А. Каверин, А. Н. Толстой, А. Гайдар, А. Р. Беляев, В. П. Кацаев тэргүүтэн адал явдлын уран зохиолын томоохон төлөөлөгчид байдаг. Монголын уран зохиолд З. Баттулга, Ж. Гал, Лха. Дарьсүрэн зэрэг зохиолчид адал явдалтай бүтээл туурвижээ.

Проза — үргэлжилсэн зохиол, үргэлжилсэн үгийн зохиол, хүүрнэл зохиол. Айхандаа уран үгийн бус бүх зохиолыг (гүн ухаан, шинжлэх ухаан, нийтлэл, мэдээллийн зэрэг) үргэлжилсэн зохиол гэдэг байснаа сүүлдээ шүлэглээгүй уран зохиолыг яруу найргаас ялган ийнхүү нэрлэх болжээ. Үргэлжилсэн зохиолын хэл нь ерийн ярианы ба бичгийн хэлнээс онцын ялгаагүй гэсэн санал зэгсэн дэлгэрчээ. Гэвч үүний сацуу олон судлагч, уран бүтээлчид үргэлжилсэн зохиол нь шулгийн айзмаас зарчмын ялгаатай боловч өөрийн гэсэн өвөрмөц нарийн айзамтай гэж үзжээ.

Үргэлжилсэн зохиолд зохиолчийн хэл, хүүрнэгчийн хэл, баатруудын хэл гэхчлэн өөр өөр төрлийн хэл харилцан шүтэлцсэн байна. Энд өгүүлэгдэхүүн их үүрэгтэй. Үйл явдал өрнөх явцад баатруудын зан чанар, тэднийг хүрээлсэн орчин ахуй, амьдралын нөхцөл байдал тодрон тарна. Яруу найраг уянгалаг шинжтэй байхад үргэлжилсэн зохиол ерөнхийдөө туульслаг шинжтэй байна.

Пролог — эхлэл. Зохиолын ерөнхий санаа, өгүүлэгдэхүүн, үндсэн сэдэв сэлтийн урьтал болсон өмнөх хэсэг. Заримдаа эхлэлд үндсэн өгүүлэгдэхүүний өмнөх явдлыг товч өгүүлэх нь бий. Оршлоос ялгаатай нь эхлэл ямагт уран сайхантай байна. Ихэнхдээ өгүүлэгдэхүүнтэйгээ нийлэх хандлагатай, чухамдаа түүний нэг бурдвэр хэсэг болж байдаг.

Просвещение (буюу просветительство) соён гэгээрүүлэх (ёс-, Соён гэгээрүүлэл. Өрнөд европын орнууд болон умарт Америкт 17—18-р зууны үед дэлгэрсэн үзэл санааны хөдөлгөөн. Энэ нэр томъёо Ф. Вольтер, И. Г. Гердер зэрэг хүмүүсийн бүтээлд тааралддаг боловч «Соён гэгээрүүлэлт гэж юу вэ?» (1784) гэсэн И. Кацтын өгүүлэл гарснаас хойш тогтвортой хэрэглэгдэж эхэлжээ. Соён гэгээрүүлэх үзэл санаа нь хөрөнгөтнүүд хурдан өсч, феодалын ёс дэглэмд дургүйцэх явдал өрнөсөн нөхцөлд нийт ард түмний дунд хөгжих бололцоотой болсон байна.

Соён гэгээрүүлэл нь хөрөнгөтний арчилал, нийгмийн дэвшил, тэгш эрхийн болон нийгмийн сайн сайхны төлөө хөдөлмөрлөх, бие хүнийг чөлөөтэй хөгжүүлэх үзэл санааг дэвшиүүлжээ. Сүм

хийдийн зэрэг хийсэн соён гэгээрүүлэгчийн темцлийг даталдаад деизм (төнгөр хэдийгээр ертөнцийг бүтээсэн ч цааныдын нь хөгжилд хөндлөнгөөс оролдох ёсгүй гэсэн узэл); шашингүйн узэл, механист материализм хөгжсөн юм. Соён гэгээрүүлэгчид байгалийг шууд судлах, техникийг хөгжүүлэх явдлыг эн төргүүд тавиад нийгмийн асуудлын тухайд идеалист узэл баримталж байв. Тэдний мэлзэд хэсэг нь гэгээрэн боловсорсон хаант засагт нийдлага тавыж байсан бөгөөд гагшгүү 18-р зууны хоёрдугаар хагаст Ж. Ж. Руссо сая бүтдээ найрамдах улсын тухай узэл санааг хөгжүүлж эхэлжээ.

Соён гэгээрүүллийн үндсэн зорилго нь оюун ухааны хүчээр юм мэдэхгүйн харанхуйт гэтлэн давах явдал байв. Соён гэгээрүүлэх узэл гүн ухаан, уран зохиолд хүрц тод илэрчээ.

Соён гэгээрүүлэх хөдөлгөөн нь олон тарамгай сэргэгч, зохиолчдыг төрүүлсний дотор Англид Д. Дефо, Г. Фильдинг, Франциад Ф. Вольтер, Д. Дидро, Ж. Руссо, Германнд Э. Лессинг, Ф. Шиллер, И. Гете, Орост Д. Фонвизин, И. Крылов, А. Радищев нарын зэрэг зохиолчийг төрүүлжээ. Энэ хөдөлгөөний хүрээнд бас соён гэгээрүүлэх реализм, сентиментализм, соён гэгээрүүлэх классицизм мэтийн уран зохиолын янз бүрийн чиглэл ургсал хөгжжээ.

**Прототип** — Эх дүр. Зохиолын баатрын дүрийг бүтээхэд уг үндэс болсон бодитой хүн. Нэг хэсэг зохиолд нийгмийн тодорхой давхаргын олон арван хүнд түгээмэл байх шинжүүдийг баатартайгаа нэгтгэсэн (Н. Гоголийн «Байцаагч түшмэлийн» түшмэд нар, А. Твардовскийн «Василий Тёркин») байхад нөгөө хэсэг зохиолд нэг бодитой хүнд тулгуурлан дур бүтээсэн байдаг. Бас зарим зохиолд эх дүр жинхэнэ нэрээрээ гарах нь бий (В. Инжинашний «Хөх судар» дахь Чингис хаан, түүний шадар нөхөд, ах дүүс, түүх хувьсгалын сэдэвт романууд дахь Сүхбаатар болон бусад хувьсгалчид).

**Псевдоним** — хуурамч нэр, нууд нэр. Зохиолчийн жинхэнэ нэрээ нууцлан, оронд нь зохиол дээрээ тавьдаг нэрийг хуурамч нэр гэнэ. Уран бүтээлчид хяналт мөрдлөгөөс зайлсхийх, ижил нэртэй зохиолчоос ялгарахыг хичээх, угсаа язгуурын мухар суусыг хөтлөгдөх, утга зохиолын ажилдаа амжилтгүй болохоос айх, өөрийн аль нэг чанарыг цохон заах зэрэг олон шалтгаанаар хуурамч нэр хэрэглэдэг. Дундат зууны монголын бичгийн хүмүүс дунд нэрээ санскрит, төвд, манжаар, мөн гадаад угзэр бүтсэн нэртэй бол түүнийгээ Монголоор орчуулж зохиолдоо бичдэг заншил их дэлгэрсэн байв. Жишээ нь: Лувсанчултэм гэхийг Сумадишила, Лувсанринчен гэхийг Сумадирадна, Галсанжинба гэхийг Өглөг нэрт очуухэн банди (Жинба гэдэг нь өглөг гэсэн төвд уг), гэх буюу Даны нэрт (Дана санскритаар өглөг гэсэн уг) г. м. Мен өөр янз бурийн ётт бэлтгэсэн нэрийг ч их хэрэглэдэг. Зөв-

хен иөн хутагт Равжай и таажэд Додманрандол, Бадмавантиг-дагзал, Хорваандол, Хандгавийланце, Номгуй галзуу гэх мэт олон янзаар зохиолдоо ёснийтэй наралжээ. Орчин үеийн монголын зарим зохиолч бас нууд нэр хэрэглэдэг байв. Жишээ нь Ц. Дамбадорж Улаан-Оторч ба Абмад нэрээр, Д. Чимэд Дэмчиг нэрээр, М. Цэдэндорж Мишигийн Зээхүү нэрээр бичиж байжээ.

Публистика художественная—уран нийтлэлийн зохиол. Жинхэнэ уран зохиол ба шинжлэх ухааны (чийгэм-улс төрийн) үргэлжилсэн зохиолын зааг дээр байдаг утга зохиолын нэгэн зүйл. Уран нийтлэлийн эн тэргүүний зорилго нь нийгмийн учир холбогдолтой орчин үеийн амьдралын чухал асуудлыг дэвшүүлэх тавихад оршино. Уран нийтлэлд чиглэсэн нэг санаа, маргааны амьсгал нэвт шингэсэн байдгийн дээр хэл найруулга нь сэтгэлийн их догдоллыг илэрхийлсэн шинжтэй байна. Уран нийтлэлийг найруулал, шог найруулал, сурвалжлага, хочлол, нээлттэй захидал тэргүүтэн олон зүйлийн хэлбэрээр бичиж болио.

Развязка—тайлал. Зохиолын зөрчил буюу ээдрээ нэг тийшээ болж шийдвэрлэгдэх мөч. Тайлал нь үйл явдалтайгаа шууд холбоотой өгүүлэгдэхүүний бүрэлдэхүүн хэсэг байдгаараа төгсвөрөөс (эпилог) ялгаатай. Тайлал голцуу зохиолын эцэст, туйлынхаа дараа байдаг боловч хааяа бас зохиолын эхэнд байх нь ч бий.

Размер стихотворный—шүлгийн хэмжээ. Шүлгийн мөрийг бүтээх аймын хэлбэр. Шүлэг зохиомжийн тогтолцоонос хамааран шүлгийн хэмжээний үндэс нь янз янз байна. Жишээ нь уртат-гальн шүлэгт урт богино үеүд, үеийн шүлэгт үеийн тоо, өргөлтийн шүлэгт үеийн тоо, өргөлтийн байрлалаар (5 ёлмийт ямб, 4 ёлмийт хорей г. м.) шүлгийн хэмжээ тус тус тодорхойлогдоно.

Рассказ — өгүүллэг. Баатрын амьдралын аль нэг хэсгийг үзүүлдэг хүүрнэл зохиолын бэрэг хэлбэр. Энэ зүйлийн зохиолын онцлог нь ахархан хугацааны явдал, цөөн тооны хүнийг дурсэлдэгт оршино. Өгүүллэгийг найруулалтай жишин тодорхойлох ёс бий. Тухайлбал найруулал ямагт баримтыг үндэслэл болгодог байхад өгүүллэг уран саналгын үндсэн дээр бичигддэг гэх буюу өгүүллэг найрууллаас зөрчил тэмцэл бүхий өгүүлэгдэхүүнээрээ ялгардаг бол найруулал нь үндсэндээ тоочин тодорхойлох аястай зохиол болно гэсэн саналууд байдаг. Бэрэг хүүрнэл зохиолын ёөр нэг зүйл байдаг нь туурь болно.

Реализм—реализм. Урлаг, утга зохиолын уран сайхны арга. Уран бүтээлч хүн энэ аргыг мөрдөж жинхэнэ амьдралын мөн чанарт нийцсэн, бодит байдлын баримтыг хэв шинж тэгс болгон үзүүлэх замаар бүтээсэн дүрээр амьдралыг дүрслэнэ. Реализм нь уран зохиолын ач холбогдол бол хүн өөрийгөө болон хүрээлсэн өртөнцийн танин мэдэх арга хэрэгсэл болдогт оршино гэж батлаад амьдралыг түнзгийн ухаарах, бодит байдлыг түүнд зуршмал байдаг зөрчил мөргөлдөөнтэй нь өргөн хамарч гаргахыг

Эрмэлзэн, уран бүтээлч хүн амьдралын бүх талыг ямар ч хязгааралтгүйгээр үзүүлэх эрхтэйг хүлээн зөвшөөрдөг юм.

Реализм нь Марийн ширийн зүйлс нь үнэн байхын сацуу хэвшижит зан чанарыг, хэв шинжит нөхцөлд нь үнэн зөв дурслэхийг шаарддаг гэсэн Ф. Энгельсийн тодорхойлолт. Хэдийгээр XIX зууны утга зохиолын түүхэн тодорхой аргын туршлага дээр тулгуурласан боловч орчин үеийн реализмыг ерөнхийд нь тодорхойлоход чухал чиг баримжаа болно гэж судлаачид үздэг юм. Энд гол нь реализмын анхаарлын төвд зүгээр нэг баримт, үйл явдал, хүмүүс, эд юмс байх биш, харин амьдралд шинж төгс байгаа тэр зүй тогтлууд байхад оршино. Реализм нь эдгээр зүй тогтлыг дурслэхдээ бодис хэрс дэвсгэрээс хөндийрдөггүй амьдралын мөн чанар болсон шинжүүдийг аль болох бүрэн сонгон авч үзүүлдэг, тэгснээрээ ч уншигчдыг амьдралын мэдлэгээр баяжуулан танин мэдуулэх үүрэг гүйцэтгэдэг.

Амьдралын үзэгдлийг сонгож дурслэх, үнэлэх, тэдгээрийг чухал зуршмал, хэв шинжит зүйл болгон үзүүлэх чадвар энэ бүхэн зохиолчийн амьдралыг үзэх үзэлтэй холбоотой бөгөөд энэ нь улмаар түүний өртөнцийг үзэх үзлээс, хамаардаг байна. Амьдралыг бодитой дурслэх эрмэлзэл нь зохиолчийг хааяа өөрийн улс төрийн мухардмал үзлээсээ давж, нийгмийн хөгжлийн хандлагыг үнэн зөв үзүүлэхэд хүргэх нь ч бий.

Урлагийн хөгжлийн түүхэн нөхцөлүүдээс болоод реализм нь газар бүр тодорхой онцлогтой байна. Мөн үндэсний түүхэн нөхцөл байдлын улмаас янз бүрийн оронд реализмын хөгжил харилсан адилгүй байдаг юм.

**Редакция**—боловсруулга. Зохиогч, редактор тэргүүтний засан өөрчлөх явцад буй болсон зохиолын нэгэн зүйл эх. Энэ боловсруулалт зохиолын агуулга, бүрэн бүтэн байдал, найруулгыг өөрчлөх зорилготой. Энэ нь их чухал өөрчлөлт тул үүний явцад шинэ зохиол бий болж, анхны эх нь шинэ боловсруулгынхаа хамтаар хоёр тусгай зохиол мэтээр зохиолчийн бүтээлийн эмхтгэлд орж хэвлэгддэг.

**Ренессанс** — үз. Возрождение

**Ремарка**—тэмдэглэмж гэж жүжгийн зохиолд үйл явдал өрнөх газар, орчин нөхцөл, баатруудын гадаад төрх, сэтгэл санааны байдал, нүүрний хувирал, дохио зангаа, ярианы өнгө тэргүүтний зохиолч өөрийн угээр зааж тайлбарласныг хэлнэ. Ийм тэмдэглэмж их төлөв хаалтанд байна.

**Реприза, реприз**—шог гаралц. Цирк, эстрадад алиалагчид буюу бусад жүжигчдийн тоглодог яриан юмуу хөдөлгөөнт богино хэмжээний шог үзүүлбэр.

**Ретардация**—уз. Задержание.

**Реффрен**—дахилт. Шулэг, дууны бадаг бүрийн дараа давтагдах уг, бүлэг уг, мөр юмуу хэд хэдэн мөр. Монгол ардын уртын

дуунд нийтээр түрж дуулах бадгийт түрлэг гэх нь бий.

**Рецензия**—шүүмж. Шүүмжлэлийн нэг зүйл, зохиол бутээлийн талаар сонин, сэтгүүлд бичсэн үнэлэлт. Шүүмжид зохиолын товч агуулгыг мэдээлж, холбогдох ном зүйн баримтыг дурдан, зохиолд дэвшүүлсэн нийтмийн асуудал, түүний уран сайхны чанар, тухайн зохиолчийн бүтээлд болон орчин үеийн утга зохиолд уг бутээлийн эзлэх байр суурийг тодорхойлно.

**Ритм**—айзам. Өөр хоорондоо тодорхой, тэнцүүхэн зайдайгаар аливаа төстэй үзэгдлүүд давтагдахыг айзам гэнэ. Шүлэгт бол энэ нь нэг төрлийн авиануудын онцлог байдал давтагдсанаар илрэнэ. Шүлэг зохиомжийн янз бүрийн тогтолцоонд шүлгийн айзмын үндэс өөр өөр байна. Урт богино үе тодорхой жигд харьцаатай ээлжлэн орвол хэмт буюу уртатгалын шүлэг болно. Мөр бүрийн үеийн тоо тэнцүү бол үеийн шүлэг болно. Өргөлттэй, өргөлтгүй үеүд тодорхой зайд ээлжлэн орох юм бол үе-өргөлтийн шүлэг болно. Мөр бүрийн доторхи өргөлтийн тоог тэнцүүлсэн бол өргөлтийн шүлэг болно.

**Ритмика**—айзам зүй. 1. Шүлгийн айзмын байгууллын асуудлыг судалдаг туурвил зүйн нэг салбар;

2. Тухайн нэг яруу найрагчийн шүлгийн өвөрмөц байгуулал. (Пушкиний 4 өлмийт ямбын айзам зүй) гэх мэт).

**Риторический вопрос**—яруу асуулт. Үншигч, сонсогчийн анхаарлыг татан, сэтгэл хөдөлгөх зорилгоор хариу үл шаардах асуулт тавьдаг найруулгын нэг ур маят.

Дуулим талын цэцгэрхүү хөөрхөн хүүхэн болж уу, би?

Дугуй толины өмнө дахин дахин эргэлдээд

Дурлалын дуу аялж гадаа гармаар байх чинь

Дуулим талын цэцгэрхүү сайхан хүүхэн болж уу, би?

Д. Нямаа, «Дуулим талын цэцгэрхүү сайхан хүүхэн хүүхэн болж уу би»

Саарал шинелээ тайлаагүй

Буурал найз минь хаа байна?

Дархан хотын барилга дээр үү

Тортон хилийн зааг дээр үү?

Ч. Чимид, «Дайчин нөхрийн тухай дууль»

**Рифма** — холбоц. Шүлгийн шатуудын толгой буюу сүүлийг дуудлага ижилсэн холбох ёс. Монгол шүлэгт толгой холбох ёс голлож дэлгэрсэн байхад европ зүгийн шүлэгт сүүл холбоц түгээмэл байна. Холбоц нь зэрэгцэх холбоц (АА юмуу АААА), салаавчлах холбоц (АВАВ) хаших холбоц (АВВА) гэх мэт янз янз хэлбэртэй. Жишээ нь.

Урьхан хонгор салхинд

Улиас мод танхана

Уяхан зант тэр минь

Удах тусмаа сацагдана

Д. Равжай «Урьхан хонгор»

гэсэн бадагт шүлгийн толгойг зэрэгцүүлэн холбосон байхад,

\*Хүүхэн нэг өдөр

Захиа над гардуулав

Хүссэн хариу мөн гээд

Задлалгүй сэм өвөртгэв

Д. Гомбожав «Шууданчийн тухай мөчлөг»

гэсэн бадаг салаавчлах холбооор бутсан байна.

Роды и виды литературные—уран зохиолын төрел, зүйл. Хувийг дурслэх гурван хэлбэртэй зохицон уран зохиол туульсын жүжгийн, уянгын гэсэн гурван төрөлд (аймагт) хуваагдана. Төрөл гэдэг бол хамгийн ерөнхий түүхэн үүднээс тогтвортой ухагдахуун юм. Их эртний үеэс уран зохиолыг гурван төрөл болгон ангилж иржээ.

Төрөл тус бүр нь ямагт зүйлээр илэрнэ. Жишээлэхэд туульсын төрөл нь их тууль, роман, түүж, найраглал, өгүүллэг, найруулал, ётг үлгэр; уянга нь шулэг, дуу, гуниглалт шулэг; жүжиг нь эмгэнэлт жүжиг, инээдэмт жүжиг, ерийн жүжиг гэх мэтээр цааш задарна. Туульсын төрлийг зүйл болгож хуваах зарчим нь амьдралыг дурсэлсэн шинж чанар, дурслэлийн нарийн төвөгтэй байдлын төвшнөөр тодорхойлогдоно. Уянгын зүйлийг тогтооход сэтгэлийг яаж илэрхийлсэн нь чухал (Гунихралтай бол гуниглалт, баяр ёслолын шинжтэй бол сүлд дуулал т. м.). Жүжигт бол дурслэгдэхүүндээ хандах хандлагын шинжээр нь зүйлийг тодорхойлно (Эрхэм дээд үйл хэргийг үзүүлсэн бол эмгэнэлт жүжиг, дооглон тохуурхсан бол инээдэмт жүжиг).

Роман—роман бол хүүрнэл зохиолын нэгэн томоохон зүйл. Их туульсыг бодвол хэмжээгээр арай бага боловч бусад туульсын зүйлс дотроо хамгийн том нь болно. Романд хүний амьдралыг, заримдаа нэг хэсэг буюу нэлээд олон хүний хувь заяаг урт удаан хугацааны туршид, хааяа хэд хэдэн үеийн нь туршид үзүүлнэ. Сонгодог хэлбэрийн романы онцлог нь нийгмийн харилцааны нарийн төвөгтэй байдлыг тусгасан олон салаа мөчир бүхий өгүүлэгдэхүүнтэй байж, хүнийг анги нийгмийн хэлхээ холбоонд нь дурсэлж, зан чанары нь төлөвшлийг орчин ахуй нь нөхцөлдүүлж, байгааг үзүүлдэгт оршино.

Роман в стихах—шулэглэсэн роман. Уянга-туульсын зохиолын хамгийн дэлгэр багтаамжтай хэлбэр. Романтизмаас реализмд шилжих үед үүсчээ. Шулэглэсэн роман нь өргөн өрнүүн өгүүлэгдэхүүнтэйн дээр уянгын баатрын дүрийг бүтээсэн уянгын хадууралтай байдаг. Байроны «Дон жуан», А. Пушкины «Евгений Онегин» зэрэг алдартай шулэглэсэн романууд гарчээ. Монголын орчин үеийн уран зохиолоос Р. Чойнномын «Хүн» романыг жишээ болгон дурдаж болох юм.

Романтизм—романтизм. XIX зууны эхээр бий болсон уран сайхны арга. Европын олон орны урлаг, утга зохиол, АНУ-ын утга зохиолын нэг чиглэл (урсгал) болон өргөн дэлгэрчээ.

Европт романтизм үүссэн нийтлэг түүхэн хөрс дэвсгэр нь Францын их хувьсгалтай холбогдсон эргэлтийн үе байв. Романтич нар өөрийн үеэс хувьсгалын дэвшүүлсэн бие хүний эрх чөлөөний үзэл санааг тусган авсан бөгөөд үүний хамтаар бас мөнгөний сонирхол эз дийлсэн нийгэмд хүн ямар ч хамгаалалтгүй, арчаагүй байдалтай болохыг ухамсарлажээ. Иймээс романтич нарны ертөнцийг ойлгох ойлголтын хувьд эргэн тойрныхоо ертөнцийг хараад бачимдан сандарсан байдал, бие хүний эмгэ-нэлт хувь заяа сэлт зуршмал байдаг.

Романтизм нь хэдий ийм нийтлэг хандлагатай ч нийгэм улс төрийн үзэл нь нэгдмэл байсангүй. Харин ч тэдний нийгмийг үзэх үзэл, тухайн үеийнхээ тэмцэл, нийгэмд баримтлах байр суурь нь хувьсгалт (буюу үймээн дэгдээгч) үзлээс аваад хуучинсаг, харгис үзлийг хүртэл эрс тэс ялгаатай байв. Нэг талаас бие хүнийг онцгой сонирхох сонирхол, эргэн тойрны үнэн байдалд тэр бие хүний хандах хандлагын шинж, негеэ талаас бодит ертөнцэд хүслэнгийн ертөнцийг (хөрөнгөтний бус, хөрөнгөтний эсрэг ертөнцийг) сөргүүлж тавих явдал романтизмын утга зохиолд уран сайхны нь аргын өвөрмөц онцлогийг тодорхойлно. Романтик уран бүтээлч хүн бодит үнэн байдлыг яг байгаагаар нь дүрслэх зорилт тавьдаггүй. Харин тэрээр бодит байдалд хандах хандлагаа илэрхийлэх, тэр ч атугай өөрийн туйлын хүслэнгийн биелэл болсон ертөнцийн дүр зургийг санаанаасаа зохиохыг чухалчилдаг. Иймээс романтизмын уран зохиол их төлөв зохиогчийн бодит байдалд хандах хандлагыг илэрхийлэгч баатрыг дэвшүүлэн тавьжээ. Тэр баатар нь баахан гайцаардмал, сэтгэл зориг чанга, бодот байдлыг их хурц эсэргүүцдэг, бусдын захирагддаг хууль ёсыг угүйсгэдэг хүн байдаг. Түүнийхээ улмаас ч их омог бардам, хүмүүсээс дээгүүр байдалтай дүрслэгддэг. Энэ баатар бол үргэлж сэтгэл түгшин, тэсч ядаж явдаг номхоршгүй хүн юм.

Романтизм дэлхийн утга зохиолын түүхэнд бүхэл бүтэн үеийг эзэлжээ. Бие хүн, түүний сэтгэлийн ертөнцийг гойд сонирхдог байсан нь уянгын ба уянга-туульсын төрөл зүйлс цэцэглэн хөгжихэд дөхөм үзүүлжээ. Романтизмын үед Гюго, Байрон, Гейне, Мицкевич нарны том яруу найрагчид төрсөн юм. Романтик зохиолчид хүний «би»-д гүнзгий нэвтрэснээрээ XIX зууны сэтгэлзүйн реализмыг ихээхэн хэмжээгээр бэлтгэж өгсөн юм. Романтизмын том нээлт бол түүхэн зүй болно. Энэ үед түүхэн роман (Скот, Гюго, Дюма), түүхэн жүжиг бий болжээ. Романтик зохиолчид цаг үеийн өнгө төрх, үндэсний болон тазар зүйн онцлогийг яруу сайхан таргахыг чармайдаг байв. Тэд ардын аман

зохиол, дундад зууны зохиол бүтээлийг дэлгэрүүлэх хэрэгт их зүйл хийжээ. Ард түмнийхээ өвөрмөц урлагийг сурталчилахын сацуу тэд бас бусад ард түмний уран сайхны охь дээжист хүмүүсийн анхаарлыг хандуулдаг байв. Романтизмын үед уран сайхны орчуулга цэцэглэн хөгжсөн юм. Романтизмын төлөөлөгчид классицизмын тогтоосон хатуу журам горимыг эс хэрэгссэн зохиолч хүн уран сайхны янз бүрийн хэлбэрийг ашиглах эрхтэй гэж тунхагладаг байв.

Романтизм нь реализмын үед ч байсаар байв. Гэвч ХХ зууны үед уран сайхны бие даасан чиглэл байхaa болж, гагцхүү тодорхой зохиолчдын бүтээл дэх романтизмын зарим шинжийн тухай л ярих болсон байна.

**Сарказм**—ингүүн шоглол. Илт шоглосон утгатай гашуун, ёвортон доог. Инээлгэх уран сайхны хэрэглүүр болохынхоо хувьд егөөдөлтэй ойроор үл барам, түүний нэгэн зүйл болно. Егөөдөл нь ёгтлол, битүү дохиогоор илрэдэг бол ингүүн шоглол нь сэтгэлийн хүчтэй хөдөлгөөн, угүйсгэл, зэвүүрхлийг шингээсэн байна. Свифт, Вольтер, Салтыков-Щедрин, Ильф Петров зэрэг зохиолчдын шог бүтээлд ингүүн шоглол их бий.

**Сатира**—шоглол. Ертөнцийн төгөлдөр бус байдал, хүний гэмсогийг хайр энэрэлгүй илчлэн шүүмжилсэн инээдмийн нэгэн зүйл. Хадгис муу үзэгдлийг улайлтан илчилсэн зохиолыг ч ингэж нэрлэх ёс бий. Шоглолыг ойлгохын тул хошигнолтой (юмор) жишиг үзэж болно.

Хошин дурийг бүтээгч өгүүлэн буй үзэгдэлдээ элэгтэй дотносог хандах бөгөөд түүний зөвхөн аль нэг тодорхой дутагдлыг үзүүлнэ. Гэтэл шоглол бол дурслэгдэхүүндээ ямар ч элэгтүй, түүнийг эрс ширүүн шүүмжилнэ. Хошигнол нь үзэгдэл дэх тодорхой жижиг, голлох бус зүйлийг угүйсгэдэг байхад шоглол нь нийтлэг, үндсэн зүйлийн нь угүйсгэнэ. Эндээс хошигнол, шоглол хоёрын гол ялгаа гарч ирнэ. Хошигнол үзэгдлийн зөвхөн хэсэг бусаг дутагдлыг харуулдаг тул тэр үзэгдлийнхээ бодит төрхийг их төлөв хэвээр нь гаргана. Гэтэл шоглол үзэгдлийн үндсэн онцлогуудыг угүйсгэн, эрс ихэсгэлийн аргаар тэдгээрийн ашиггүй, явцгүй цохон үзүүлдэг тул дурслэн буй үзэгдлийнхээ ердийн бодит хэлбэрийг өөрчилж томьёолсон дурслэл, хэтруулэг, уран сэтгэмж өргөн ашиглана. Дэлхийн утга зохиолд Рабле, Серванtes, Свифт, Вольтер, Гофман, Н. Готоль, Н. Салтыков-Щедрин зэрэг шоглолын гарамгай төлөөлөгчид төржээ.

**Свободный стих** (верлибр)—Чөлөөт шулэг. Холбоц, байнгын хэмжээ байхгүй, мөрийн доторхи үе, бадгийн доторхи мөрийн тоо харилцан адилгүй, чухамдаа шулэг, үргэлжилсэн үгийн зохиолын зааг дээр зохиогдсон нэгэн зүйл шулэг. Их төлөв ХХ зууны үед дэлтэрчээ. Гейнэ, Уитмен зэрэг дэлхийн олон алдарын яруу найрагч чөлөөт шулэг бичдэг байв. Одоо ч зарим шулэгч энэ

аргаар зохиолоо түүрвиж байна. Монголын яруу найрагт.

Дорно л гэнэ  
Өрнө л гэнэ  
Өрнө биш, Дорно л гэнэ  
Дорно биш Өрнө л гэнэ  
Хатан дэлхийг  
Хаа гуяар нь салгаж байгаа юм шиг  
Хаагуур нь  
Салгаад  
Ялгаад байгаа юм бол  
Хотол түмнийг  
Хонь хурга ялгаж байгаа юм шиг  
Юугаар нь зааглаад  
Заазлаад байгаа юм бол?

(Ч. Чимиid «Өрнө, Дорно хоёр»)

гэх юмуу:

Тэр цагт хүүхдийн нүдээр харсан  
Хүүхдийн тэнгэр л  
Бидний дээр байсан юм  
Тэр цагт хүүхдийн минь  
Цагаан цамц  
Цахтай болон  
Холд дэрвэж  
Хөлгийн дарвуул болж  
Хоёр мөрийг минь өргөж явсан

(Ш. Сүрэнжав «Хэзээ нэгэн цагт бид хүүхэд байсан юм») гэх мэтийн мөрийн доторхи үгийн тоо нь тэнцүүгүй, хайрцаглаж бадаглаагүй шүлгүүд үе үе гарч байгаа нь мөн чөлөөт шүлгийн жишээ юм.

**Сентиментализм**—сентиментализм. XVIII зууны хоёрдугаар хагаст урлаг, уран зохиолд гарч ирсэн урсгал. Соён гэгэрүүллийн эхний рационалист (оюуныг шүтэх ёсны) шатыг эсэргүүцсэн нэг ёсны эсэргүүцэл байдалтайгаар XVIII зууны Өрнөд европын утга зохиолд Соён гэгэрүүллийн хүрээнд ҳөгжжээ. Соён гэгэрүүлэгчдийн эрхэмлэдэг оюун ухааныг шүтэх ёс XVIII зууны дунд үе гэхэд өрөөсгэл болохоо нэгэнт харуулжээ.

Оюуны үүсгэл, рационалист хандлага нь яваандаа цулгуй хүйтэн бодол, тэр ч атугай шунахай тооцоо болж хувирчээ. Ингээд сентименталистууд хүний мөн чанарын гол шинж нь хөрөнгөтний практикаар нэрээ унагасан оюун биш, харин сэтгэл юм гэж тунхаглажээ. Сентиментализм нь соён гэгэрүүллээс салалтуй, улгэр жишээч хүний тухай туйлын хүслэнд үнэнч хэвээр үлдсэн боловч гагцхүү энэ хүслэнг хэрэгжүүлэх нөхцөл нь ертөнцийг «ухаалгаар» өөрчлөн байгуулах явдал биш, хүний «төрөлхийн» сэтгэлийг чөлөөлөх, төгөлдөржүүлэх явдал гэж үзэж байв.

Сентименталистууд хүний сэтгэлийг үзүүлдэг, сэтгэл үнэнхүү, гүнзгий хөдлөх чадвараар нь хүнийг үнэлдэг байв. Үүнд нэг чухал зүйл нь тэд эгэл жирийн, өндөр дээд язгуургүй хүнийг гол баатар болгон дэвшиүүлжээ. Тэд жирийн хүнийг язгууртантай эн зэрэгцүүлэх юмуу эсвэл бүр язгууртны мухар үзэлд автаж ялзраагүй, байгальд ойр байдаг жирийн хүн л үнэн сайхан сэтгэлтэй, жинхэнэ хүн байдаг гэж нотолцгоодог байв. Тэд бас байгалийг сэтгэлийн хөдөлгөөний өнгө аястайгаар их дурсэлдэг байжээ.

Сентиментализм нь зарим шийжээрээ романтизмыг бэлтгэсэн ба үүний хамтаар соён гэгээрүүлэгч реализмтай хааяа ойртож очдог юм.

**Силлабическое стихосложение**—үеийн шүлэг зохиомж. Мөр бүр дэх үеийн тоог тэнцүүлсэн шүлэг зохиох ёс.

**Силлабо-тоническое стихосложение**—үе-өргөлтийн шүлэг зохиомж гэдэг нь өргөлттэй, өргөлтгүй үеийг зөв хослуулахад үндэслэсэн шүлэг зохиох тогтолцоо. Энэ ёсыг Орост В. Тередиаковский, М. Ломоносов нар боловруулжээ. Орчин үеийн зөвлөлтийн яруу найрагчид өргөлтийн шүлэг зохиох ёсны хажуугаар энэ журмыг өргөн ашиглаж байна (А. Твардовский, Я. Смеляков г. м.).

**Символ**—бэлгэ тэмдэг. Аль нэг үзэгдлийн мөн чанарыг илэрхийлсэн үг, хэллэг юм уу биет зүйл, адгуус амьтан, юмын шинж, уйл хөдөлгөөн, хийсвэр дүрс (хээ угалз г. м.). тэргүүтнийг хэлнэ. Жишээ нь Тагтаа энх тайвны бэлгэ тэмдэг, хадаг хүндэтгэлийн бэлгэ тэмдэг г. м.

Үгээр илэрхийлсэн бэлгэ тэмдэг маш баялаг, нийтийн мэддэг хэвшсэн бэлгэ тэмдгээс гадна зохиолчдын бүтээсэн, тухайн зохиолын холбогдох хэсгийг уншиж байж санааг нь ойлгох бэлгэ тэмдгийн үг, хэллэг ч элбэг байдаг. Жишээ нь: «Бууны ам цаашаа, дууны ая наашаа» (Ц. Гайтав «Буу дуу хоёр») гэсэн шүлгийн мөрт бууны ам нь дайны аюулыг, дууны ая нь энх жаргалтай амьдралыг илэрхийлсэн бэлгэ тэмдэг болж байна.

**Символизм** — символизм бол юмс, үзэгдлийг тухайлсан дохио тэмдгээр дурслэн үзүүлж болно гэж үздэг, XIX зууны суул XX зууны эхэн үед Франц дахинд дэлгэрч байсан утга зохиолын нэгэн чиглэл (урсгал). Бүр XIX зууны 70—80-аад оны үед Франциад энэ чиглэл төлөвшсөн байна.

Символистуудын хувьд бэлгэ тэмдэг бол нийтийн ойлгох дохио тэмдэг биш. Энэ бэлгэ тэмдэг нь үзэгдлийн бодит мөн чанарыг биш, харин өртөнцийн тухай яруу найрагчийн хувийн бодгаль төсөөллийг илэрхийлдгээрээ реалист дүрээс ялгаатай. Символизмын онолоор бол яруу найраг бодит байдлыг нарийн дохио зангаа, саарал өнгөөр үзүүлэх ёстой, гоо үзэсгэлэн, үнэнийг оюун.

ухаанаар бус, эн билгээр бйлгодог гэж символистууд үздэг. Нэрд гарсан символист зохиолчид гэвэл Францын С. Малларме, А. Рембо, П. Верлен, Бельгийн Ж. Роденбах, Э. Берхарн, М. Меттерлинк, Германы Ст. Георге, Г. Гауптман, Австрийн Р. М. Рильке, Г. фон Гофмансталь, Английн О. Уайльд, Норвегийн Г. Ибсен (амьдралын нь сүүлийн үеийн бүтээлүүд), Оросын А. Белый, В. Брюсов, К. Бальмонт, А. Блок нарыг нэрлэж болно.

**Синекдоха** — орлуулал Нэгэн зүйлийн дурслэг хэллэг, төлөөллийн нэг хэлбэр, тооны харьцааг солих үндсэн дээр нэг үгийн утгыг нөгөөд шилжүүлснийг хэлнэ. Бүхлийг хэсгээр, олон тоог танц тооюур, хэсгийг бүхлээр тэхчлэн янз янзаар орлуулан нэрлэж болдог. Жишээ нь:

Хуралдсан олны дунд учирмагц

Дөрвөн нүд эсрэг ширтэлцэж

Хоёр сэтгэлийн дотор нэг зэргээр

Зул гэрэлтэж байгааг хэн мэднэ

(Д. Нацагдорж, «Нууц янаг»)

Монгол хүү, цэлмэг тэнгэртээ

Хүлэг онгоц жолоодож,

Монгол хүү, цэцэгт талдаа

Галт тэрэгт хурдлуулж ...

С. Дашдооров. «Монгол» найраглал)

**Синонимы** — ойролцоо уг гэж өөр өөр хэлбэртэй боловч төсөөтэй буюу ижилхэн утга бухий угс, бүтээвэр, хэллэгийг хэлнэ. Ойролцоо уг нь угсийн санд хамгийн их түгээмэл байдаг бөгөөд нэр үт, тэмдэг нэр, үйл уг, дайвар уг тэхчлэн угсийн тодорхой аймгийн хүрээнд хөгждөг. Жишээ нь саад, саад тогтор гэсэн утгаар гацаа, гачлан, зэтгэр, хясаа, чөдөр, тушаа, хявцаа, чагт, боомт, гай, тээр, дараа, дарамт, бэрхшээл, цөв, яршиг, төвөг, уршиг гэсэн олон үгийг хэрэглэж болно.

Түүнчлэн хэвшмэл хэллэгийг ойролцоо үгийн утгаар хэрэглэж болдог. Жишээ нь залхуурахыг ааг зөвгөн хийх, лазангийн зоогор хатгах, хойш суух, худрагаар суух гэх мэтээр хэлдэг. Баатрынхаа ярианы соёл, тухайн мөч дэх сэтгэл санааны байдлыг харуулах, өөрийн илэрхийлэх гэсэн санааг гартахад ойролцоо утгатай олон үгээс хамгийн тохирохыг нь зөв, оновчтой сонгож авах нь зохиогчийн уран чадварын хэрэг болно.

**Сказ**—аман өгүүллэг. Аман зохиолын нэг зүйл. Өнөө үе буюу саяхан өнгөрсөн үеийн явдлыг өгүүлэх бөгөөд уран сэтгэмжийн ба улгэрийн шинжтэй зүйлс агуулдаггүйгээрээ домгоос ялгаатай. Уг хэрэг явдалд оролцсон хүний ярьсан аман өгүүллэг (дурсамжийн аман өгүүллэг) байхаас гадна, тэр хэрэг явдалд оролцсон хүнээсээ холдсон, яваандаа домог, хууч яриа болон хувирах хандлагатай аман өгүүллэг бас байдал. Сүүлийн үед сказ гэхийн оронд үстний народный рассказ (ардын аман өгүүллэг) гэсэн нэр

томъёо их хэрэглэх болсон байна.

**Сказка**—улгэр. Ард түмний уран сэтгэмжээр зохиосон, ихэнх дээ ургэлжилсэн үгийн хэлбэртэй нэгэн зүйл аман өгүүллэг. Улгэрийг голцуу адгуус амьтны улгэр, шидэг улгэр, аж байдлын улгэр гэж ангилдаг. Улгэрийн сэдэв, дур, өгүүлэгдэхүүнийг ашиглан бичсэн уран зохиолын дурсгалуудаас гадна дэлхий дахины утга зохиолын эрдэнэсийн санд орсон алдарт улгэрийн цоморлигүүд байдаг. Тухайлбал арабын «Мянга нэгэн шөнийн улгэр», Энэтхэгийн «Панчатантра», Германы ах дүү Грим, Оросын А. М. Афанасьев нарыц цуглувалгыг нэрлэж болно. М. Е. Салтыков-Щедрин, А. С. Пушкин, Х. К. Андерсен, В. Хауф, Ш. Перро, Ж. Харрис, А. Н. Толстой, К. И. Чуковский, С. Я. Маршак нарын бүтээлээс улгэрийг боловсруулах, улгэрээс сэдэвлэн зохиол тууrvихын сайхан жишээг үзэж болно.

Монголын эртний уран зохиолд Субашид, Рашааны дуслын тайлбарууд, «Шидэт хүүрийн улгэр», «Бигармижид хааны тууж» зэрэг улгэрийн цоморлигүүд байдаг. Манай орчин үеийн уран зохиолд ардын улгэрээс сэдэвтэй бүтээлүүд - нэлээн гарчээ. (Ч. Ойдов «Далан худалч» жүжит, С. Эрдэнэ «Алтан өргөө» кино зохиол г. м.)

**Содержание и форма**—агуулга, хэлбэр. Уран зохиолд юу өгүүлэв (агуулга), яаж өгүүлэв (хэлбэр) гэдгийг илэрхийлэх өөр хоорондоо салшгүй холбоотой ухагдахуун. Зохиолыг задлан шинжлэх явцад ялган үзэж байгаа зохиолын гадаад, дотоод тал буюу илэрхийлэгч ба илэрхийлэгдэгч хоёрыг хэлбэр, агуулга гэнэ. Агуулга бол зөвхөн хэлбэржиж байж илрэх тул хэлбэргүйгээр агуулгыг сэтгэшгүй юм. Үүнчлэн хэлбэр бол илэрхийлэх агуулгагүйгээр байх аргагүй.

Ийнхүү хэлбэр агуулга хоёр нь амьд нэгдэлтэй тул тухайн зохиолыг задлан шинжлэхэд нэг нөхцөлд хэлбэр болсон юм нөгөө нөхцөлд агуулга болох, тэр нөхцөлд агуулуга болсон юм өөр нэг нөхцөлд хэлбэр болох гэхчлэн бурдвэр хэсгүүд нь бие биедээ шилжих диалектик шүтэлцээтэй байдаг. Жишээ нь зохиолын хэлний гадаад сонсголонт байгуулал (хэмнэл, айзам, хөг. аялгуу, холбоц) нь дотоод уран санаа, тэр хэллэгийн утгын хувьд хэлбэр болно. Гэтэл уг хэллэгийн утга нь зохиолын өгүүлэгдэхүүний (уйл явдлын) хэлбэр, өгүүлэгдэхүүн нь баатрын зан чанар, нөхцөл байдлыг илэрхийлэх хэлбэр, энэ зан чанар, нөхцөл байдал нь зохиолын нийт утга, үзэл санаа илрэх хэлбэр болох жишээтэй юм. Энд дээрх олон шаттай задлалын хөсрөх шат бүр нь нэгдэхийнхээ агуулга болж байна.

**Спондей**—сацал өлмий. Эртний грек рөмын щулэгт хоёр урт ует өлмий.

**Сравнение**—зүйрлэл. Нэг юм үзэгдлийг нөгөөтэй зэрэгцуулсан жиших замаар түүний аль нэг буюу хэсэг шинжийн тод тогтолцоогүй.

болгон узүүлэх яруу хэллэгийн хэлбэр. Зүйрлэлийг шиг, мэт, адил зэрэг угзэр голцуу холбоно. Жишээ нь:

Наадан явах цатт  
Намрын унага мэт зэлдэг боловч  
Нанчилдах дайсанд учрахад  
Начин шонхор мэт довтолж  
Насан ямагт өутгэсэн  
Найз хөлөг Боорч минь! (Гурван зуун тайчуудыг дарсан  
домог)

Дэйлүү хөөр нудэнд чинь би  
Дэнгийн эрвээхэй шиг шатчих гээд байна.  
Дэвүүр хөөр сормосонд чинь би  
Дэнжийн ногою шиг ганхаад байна

(Б. Явуухулан, «Харааас ялдам хонгор бусгүй ээ»)

**Стилистика** — найруулга зүй. Хэлний найруулгын олон хэлбэрийт судалдаг, хэл шинжлэлийн нэгэн салбар. Энэ салбар нь угийг зөв хэрэглэх зүй тогтлыг тогтооход утга зохиол шинжлэлд туслана. Хэлэнд яриа, бичиг, албан хэрэг, шинжлэх ухаан, нийтлэл, хар ярианы гэх мэт найруулгын олон ялгамжаа бий. Уран зохиолд найруулгын энэ бүх төрлийг янз янзаар хослуулан хэргэглэдэг учир уран зохиолын хэл нь туйлын нарийн төвөгтэй үзэгдэл юм. Иймд үүнийг судлах найруулга зүйн тусгай салбар байдаг.

**Стиль писателя**—зохиогчийн найруулга. Стилос (стилус) гэж эртний грек ромд анх лав нимгэхэн турхсэн самбар дээр бичдэг нэг талдаа үзүүртэй модыг хэлдэг байжээ. Цаащаа бичсэн хүний бичгийн хэвийг, дараа нь бичих маягийн онцлог буюу найруулгыг, сүүлдээ зохиолчийн үзэл санаа, уран сайхны онцлогийг бүхэлд нь хэлдэг болжээ.

Найруулгыг аргатай нягт холбоотой авч үздэг. Найруулга нь нэг зохиолчийг нөгөөгөөс ялгах давтагдашгүй хувийн онцлог байхад, арга бол туйлын нийтлэг, тухайн зохиолчийг бусад төстэй зохиолчидтой нь ойртуулж байгаа зүйл гэж үздэг. Арга бол ерөнхий, найруулга бол тодорхой юм. Найруулга бол аргын бодгаль илрэл ч гэж үзэх нь бий. Тухайн зохиолчийн хувьд зуршмал уран бүтээлийн онцлогууд үзэл санаа, сэдэв, зан чанар, ёгуулэгдэхүүн, хэлний төсөөтэй төрөл, нэгдмэл байдал нь найруулга тэсэн ухагдахууны үндэс болно. Үүнийг хуны өмнө тэр зохиолчийн намтар, амьдралын туршлага, соёл боловсрол, авьяас, уран бүтээл нь өрнөсөн нийгмийн тэр орчин байдал нэхцэлдүүлнэ. Зохиолчийн намтын онцлог, туүхэн нэхцэл, гоо зүйн байр суурь нь тэр зохиолчийн уран бүтээлийн өвермэц онцлог ба хэлэнд нь хамгийн тодорхойлжсан.

Найруулгаараа ойр дөт зохиолч нар уран зохиолын бүлэг, дэг, ургасалыг буй болгодог.

**Стих—1. Шүлэг (шүлэгтэл):** Үргэлжилсэн угзэс ялгаатай уран

сайхны хэлний онцгой хэв маяг. Шулгийг тодорхойлэгч гол шинж нь айзам болно. Айзмыг өргөлттэй, өргөлтгүй (урт, богино) үеийн зөв зохицтой сэлгэлт, зогсочийлт, толгой, сүүл холбоц зэргээр тодотгоно. Стих гэсэн нэр томъёог шулэг гэж их төлөв орчуулдаг нь угтаа шулэглэл гэсэн утгаар болохоос бус шулэг, шулэтлэсэн зохиол (стихотворение) гэсэн утгаар хэлж байгаа хэрэг биш. Харин энэ нэр томъёо орос хэлэндээ «стихи» гэж олон тоо-гоор байгаа нэхцэлд шүлэг буюу шүлэглэсэн зохиол гэж ухаж болно. Орос хэлний стихотворение гэсэн уг бол ёстой манай шулэг буху шүлэглэсэн зохиол мөн. 2. Шад-шулгийн нэг мэрийг хэлнэ.

**Стиховедение**—шүлэг судлал. Шүлгийн зохиолын хэл, түүний байгуулал, агуулгат шинж, айзам, хөг аялга, толгой сүүл холбоц, авиа сонголт, бадгийг болон эдгээр нь уран сайхны хувьд бүхэл бүтэн зүйл бүтээхэд ямар үүрэгтэйг судалдаг утга зохиол шинжлэлийн нэг хэсэг.

**Стихосложение** — шүлэг зохиомж, шулэглэх ёс. Шүлгийн хэлний зохион байгуулалтыг судалдаг утга зохиолын өнолын нэг хэсэг. Гол хамардаг асуудал нь хэмнэлзүй, айзамзүй, авиаын зохион байгуулалт (авиа давталт, толгой сүүл холбоц г.м.), бадагзүй, шүлгийн хэлний зүйлүүд (хүүрнэл, жүжгийн ба уянгын шулэглэл), зүйлчлэлүүд г.м болно.

Шүлэг зохиомж гэсэн нэр томъёогоор аль нэг яруу найрагчийн шүлгийн хэлний онцлог (Есениний шүлэг зохиомж), хэлний байгууллаас хамаатай түүний үндэсний онцлог (франц шүлэг зохиомж, орос шүлэг зохиомж), түүхэн хэлбэрүүдийг тэмдэглэх нь олонтаа. Нэг хэлний хүрээнд шүлгийн хэлний янз янзын төрөл байж болдог. Жишээ нь орос ардын шүлэг зохиомж, үеийн шүлэг зохиомж, үе-өргөлтийн шүлэг зохиомж, өргөлтийн шүлэг зохиомж г. м. Эртний грек ромын шулэглэх ёс, дорно дахины шулэглэх ёс гэж байхаас гадна бас задгай шүлэг, цагаан шүлэг, чөлөөт шүлэг гэх мэтийн жижиг хэлбэр байдаг.

Шүлэгт олон зүйл давтагдаг (өргөлттэй, өргөлтгүй үеийн байрлал, толгой, сүүл холбоц, авиа давталт г. м.) тул математик судалгааны аргыг шүлэгт хэрэглэх оролдлого нэлээд дэлгэрчээ.

**Стихотворение**—шүлэг. Шүлэглэж бичсэн харьцангуй утга, хэлбэр нь төгссөн бага шиг хэмжээтэй яруу найргийн зохиол. Уг санаа, чиглэлзэрээ шүлэг нь нийтлэл, түн ухаан, түүх, уянгын болон шоглол, элэглэлийн шинжтэй байж болно. Хэлбэрээрээ бод шүлэг нь хоёр, гурав, дэрвэн мөрт хийгээд олон мөр бүхий бадгтай зэрэг янз янз байна. Шүлэглэсэн жүжиг, найраглал, ёг улгэр бол бадаглаагүй хэлбэртэй ч байж болдог.

**Стопа**—өлмий. Эртний грек ромын ба үе-өргөлтийн шүлэг шүлгийн хэмжээг тодорхойлдог харьцангуй нэгж. Эртний грек ромын шүлэглэх ёсонд урт богино үеүдийн хослолыг, үе-өргө-

тийн шулэгт бол өргөлттэй, өргөлттүй үеудийн хослолыг өлмий гэнэ. Шүлгийн мөрөнд хоёр үет хорей, ямб өлмий, гурван үет дактиль, амфибрахий, анапест өлмий гэх мэтээр ялгана.

**Строфа**—бадаг. Шүлгийн хэдэн мөр нийлж нэгэн бүхэл нэгдэл болсныг бадаг гэнэ. Хоёр, дөрөв, тав, зургаа зэрэг янз бурийн тоотой мөрөөс бадаг бурддэг.

**Сценарий**—кино зохиол. Кино буюу телевизийн кино хийхэд зориулж бичсэн зохиол. Кино зохиол нь бие даасан байдалтай бөгөөд түүнийг тусгай зохиолын хувьд нь хэвлэж болдог.

**Сюжет**—өгүүллэгдэхүүн. Баатруудын зан чанар, дүреэлж байгаа амьдралын үзэгдэлдээ хандах зохиолчийн хандлагыг илрүүлж байгаа зохиолын үйл явдлын цогц. Уянгын зохиолд дэлгэрэнгүй үйл явдал байдалгүй.

**Тавтология**—санаа давталт гэж нэг үгийг юмуу, утга санаа; авианы бүрэлдэхүүн ойролцоо угс давтахыг хэлнэ. Санаа давталтыг голцуу сэргэл хөдөлгөх нөлөөллийг хүчтэй болгох зорилгоор яруу найрагт хэрэглэнэ. Жишээ нь:

Суут нь биш  
Цуут нь биш  
Гарамгай нь биш  
Давамгай нь биш  
Эгээ л бид  
Эгэл хүмүүс

(Ч. Чимид «Эгэл жирийн бид»)

**Текстология**—бичвэр судлал. Зохиолын эх бичгүүдийг (бичвэрүүдийг) шүүрдэн шалгах, цаашид утга зохиол шинжлэлийн үүднээс судлах зорилгоор тэдгээр эх бичгийг шинжлэх, хэвлэх ажлыг эрхэлдэг хэлбичгийн ухааны нэг салбар. Бичвэр судлалын үндсэн зорилт нь зохиолын бичвэрүүд болон тэдгээрийн сурвалжуудын түүхийг судлах, зохиосон он цаг, зохиогчийг олж тогтоох, нарийн нягт үйлдсэн лавлах булан, тайлбартайгаар хэвлэх явдал болно.

**Тема**—сэдэв гэдэг нь туульсын ба жүжгийн зохиол дахь амьдралын үндэс болж, гүн ухаан, нийгэм, ёс зүйн зэрэг асуудлыг тавихад ашиглагдсан аливаа хэрэг явдлыг хэлнэ. Сэдэв нь зохиол дахь гоо зүйн бодит байдал ба амьдралын жинхэнэ үнэн байдал хоёрын хооронд зуучийн үүрэгтэй. Иймээс утга зохиол шинжлэлд түүнийг хоёр талаас нь авч үздэг. Амьдралын үнэн байдлын үүднээс сэдэв гэдэг зохиолын биет «зураглалт» агуулга нь түүнд дүрслэгдсэн зүйл нь бино. Энэ тохиолдолд зохиолыг шинжлэхэд зохиол дахь зохиолчийн үзлийн илэрлийн анхдагч шат болохын нь хувьд бодит байдлын чухам ямар баримтыг зохиогч сонгон авч вэ гэдэгт зонхилон анхаардаг. Гоо зүйн бодит байдлын үүднээс бол зохиолын дотоод сэдэв, зохиолчийн уран бүтээлийн хувийн сэдэвийн талаар ярьж болно. Энэ тохиолдолд сэдэв

гэж зохиолд илэрхийлсэн зүйлийг хэлэх тул сэдэв нь чухамдаа дэвшүүлсэн «асуудал»-тай адил болно.

**Теория литературы**—утга зохиолын онол. Уран зохиолын мечанар, нийгмийн уургийг судалж, түүнийг задлан шинжлэх аризүйг тодорхойлдог утга зохиол шнижлэлийн нэг салбар. Утга зохиолын онолын судлах асуудал нь бодот байдлыг зохиолч дүрээр тусгах онцлогийн тухай сургаал, зохиолын бүтцийн тухай сургаал, утга зохиолын явцын тухай сургаал тэсэн Зүндсэн хэсэгт багтана. Эхний хэсэгт дур дурслэл, ур хийц, гоо зүйн туйлын хүслэн, ертөнцийг үзэх үзэл, арга барил, зохиол бүтээлийг бүхэлд нь үнэлэх зарчмын тухай ойлголтуудыг; хоёрдугаар хэсэгт үзэл санаа, сэдэв, зан чанар, өгүүлэгдэхүүн, зохиомжийн тухай ойлголтууд, найруулта зүй, шулэглэх ёсны асуудлуудыг; гуравдахь хэсэгт найруулга (болон найруулга, аргын шүтэлцээ), уран зохиолын төрөл, зүйл, зүйлчлэлүүд, утга зохиолын урсгал, чиглэл болон утга зохиолын нийт явцын тухай ойлголтуудыг тус тус авч үздэг.

**Течение**—урсгал. Утга зохиолын урсгал буюу чиглэл (направление) гэдэг нь үзэл санаа, гоо зүйн нийтлэг үзэлтэй хэсэг зохиолчдын уран бүтээлийн түгээмэл шинжийг илтгэх ойлголт юм. Хааяа чиглэлийг арай өргөн ойлголт (жишээ нь романтизм), урсгалыг чиглэлийн доторхи салбар (иргэний романтизм) гэж тайлбарлах нь бий. Уз: Направление и течение литературные.

**Тип**—хэв шинж. Хэв шинж буюу хэв шинжит зан чанар (типичны характер) гэдэг бол реалист уран зохиол дахь хувийн онцлог, өөрийн гэсэн олон янзын шинж чанар бүхий хүний уран сайхны дүр бөгөөд түүний тэр бүх шинжээс хамгийн голлох шинжүүд нь тухайн үеийн хүмүүс, нийгмийн анги, ард түмний хувьд нийтлэг зүйл байдаг. Уран зохиолд дурслэгдсэн хэв шинжит дуруудийн танин мэдуулэх, хүмүүжүүлэх ач холбогдол их. Уншигчид тэдгээртэй танилцаанаараа нийгмийн амьдралын зүй тогтол, хүмүүсийн зан чанар, үзэл, эрмэлзэл, үйл ажлын онцлот сэлтийг ухаардаг.

**Тоническое стихосложение** — өргөлтийн шулэг зохиомж. Өргөлтийн үеүйтэй эзлэлжлэх өргөлгүй үеүдийн байрлалыг жигдлэх замаар айзмыг тааруулан шулэглэх ёс. Өргөлтийн шулгийг дотор нь өргөлтийн, үе-өргөлтийн шулэг зохиомж хэмээн хоёр ангилна. Цэвэр өргөлтийн шулэгт гагцхүү мөрийн доторхи өргөлтийн тоог харгалздаг бол негөө үе-өргөлтийн шулэгт мөрийн доторхи өргөлтийн тоо, байрлал, үеийн тоог тэнцүүлдэг байна.

**Торможение**—уз: Задержание.

**Трагедия**—эмгэнэлт, жужиг. Голдуу баатар нь, амь эрсдэж тэгсдэг хүрц тод авлагчийн зорчил бүхий жужиг. Эрхэм дээд зорилтын төлөө тэмцэгч эмгэнэлт жужгийн баатар нь хүн болон цоноосоо хол давсан саад тогторой унирна. Эмгэнэлт жужгийн

агуулгыг онцгой учир холбогдолтой зөрчил тодорхойлно. Эл зөрчил нь туйлын хурц хэлбэрээр нийгэм-түүхийн хөгжлийн тэргүүлэгч, дэвшилт хандлага, хүн төрөлхтний сэтгэлийн байдлыг тусгана. Иймээс дэлхий дахины түүхэн ач холбогдолтой асуудлыг шийдвэрлэх учиртай баатрын дурслэл нь өсгөн томруулсан, суржавхлан бүрдсэн шинжтэй байна. Иймээс ч эмгэнэлт жүжиг нь чухамхан гүн ухааны шинжтэй, хүний ахуй, түүхийн хөдөлгөөний гол тогцоо асуудлыг дэвшүүлж тавьсан байдаг (Эсхилийн «Цовдлуулсан Прометей», Шеспирийн «Гамлет», Гётеийн «Фауст», Пушкины «Борис Годунов», Брехтийн «Галилейн амьдрал» г.м.). Хүний хувийн амьдралын явцуу эрх ашиг, нутаг зуурын зөрчил-эмгэнэлт жүжигт тэр бүр тохирдогтүй юм.

Традиция и новаторство в литературе—уран зохиолын уламжлал, шинэчлэл. Уран зохиолын үйл явц дахь залгамжлал, шинэтгэл, өвлөн авсан ба шинээр бүтээсэн зүйлийн харьцааг тодорхойлогч ухагдахуун. Уламжлал гэдэг нь зохиолчийн урьд үеэсээ нэн чухал, үнэт зүйл хэмээн өвлөн авч эзэмшсэн, уран бүтээлийн чиг баримжаа болсон соёл-уран сайхны туршлага. Уламжлал нь ундэсний төдийгүй, интернациональч шинжтэй ч байж болдог. Зохиолч хүн орчин үеийнхээ уран сайхны зорилтыг шийдвэрлэхийн тул урьд үеийнхнийхээ өвийг шилж сонгож, бүтээлчээр эзэмших болдог учир бас уламжлал нь шинэчлэлтэй хосолдог байна. Шинэчлэл. гэдэг нь уран зохиолд шинэ арга зам нээх, тэгснээрээ уран зохиолын уламжлалыг өөрчлөн байгуулах, өөрөөр хэлбэл нэг хэсэг уламжлалыг огоорч, нөгөө хэсэг уламжлалыг авах, эцсийн эцэст шинэ уламжлал үлдээхийг хэлнэ. Иймээс уламжлал, шинэчлэлийн асуудал бол үгүйсгэл үгүйсгэлийн хуульд хамаарах диалектикийн асуудал мөн.

Троп—дурслэг хэллэг. Үгийг шилжүүлсэн утгаар хэрэглэсэн хэллэг. Ямар нэг талаараа ойролцоо хоёр ойлголтыг зэрэгцүүлэн тавих нь дурслэг хэллэгийн ундэс болно. Үүнд энэ зэрэгцүүлсэн хоёр ойлголт нь дурслэг хэллэгийг бүрдүүлэгч хоёр хэсэг болох бөгөөд тэр хоёрын нэг нь шууд утгаараа, нөгөө нь шилжүүлсэн утгаар хэрэглэгдсэн байдаг. Дурслэг хэллэгт чимэг үг, адилтгал зүйрлэл, төлөөлөл, орлуулал, егөөдөл, ёгтлол, амьдчилал, тойруулал, ихэсгэл, багасгал тэргүүтнийг хамааруулна.

Умолчание — дуу хураах, дуугүй орхих. Санагаа зориуд дутуу нэрхийлээд, цухуйлгасгээд орхих ур маяг. Үүнд дутууг нөхөн ойлгох нь уншигч, сонсогчийн хэрэг болно. Жишээ нь: «Хэрэв би морьтой болоод завтай явсан бол доо...» Д. Нацагдорж Хөдөө талын үээсгэлэн».

— Тэгээд нэг сонин юм болоод...

— Юу?

— Нэг муу япон офицер намайг толгой түрүүгүй загнаад...

Д. Гармаа «Тагнуул»

## Устный народный рассказ — уз. Сказ.

**Фабула**—гол явдал. Гол явдлыг өгүүлэгдэхүүнтэй (сюжет) хутгах юм уу, ав адилд үзэх явдал бий. Нэг хэсэг эрдэмтэн зохиолын бүх үйл явдлыг өгүүлэгдэхүүн, түүн дотор өрнөж байгаа үндсэн зөрчлийг гол явдал гэж хэлнэ хэмээн үзэж байна.

**Фантастика**—уран зөgnөl, уран сэтгэмж. Санаанаасаа зохиосон элдэв дүр, сонин төсөөллийн ергэнц. Хэдий уран зөgnөl нь бодит байдалтай адилгүй ч гэсэн жинхэнэ амьдралаас төрсөн сэтгэгдэл, ойл голтод дулдуйдсан байдаг. Уран зөgnөl нь өнө балар цагт янз бурийн шашин, домог-үлгэр, онгон, шутээний дурд биеллээ олдог байв. Үлгэр, тууль зэрэг ардын аман зохиолын төрөл зүйлст мөн тусчээ. Тухайлбал мангас, шуламс, нисдэг морь зэргийг дурдаж болно. Шинжлэх ухаан, техник хөгжихийн хамтаар уран зөgnөl нь ирээдүйг хараад тусалж, шинжлэх ухааны сэтгэлгээг. эрэл хайгуулд дуудан, шинжлэх ухааны ололтыг сурталчилах болжээ. Сэргэн мандалтын үеийн уран зохиолд уран зөgnөlт зохиол их дэлгэрч байв. (Рабле, Шекспир, Т. Мор г. м.)

Уран зөgnөl шог зохиолд ч мөн их үүрэгтэй. Хэт ихэсгэх юмуу багастах аргаар шог зохиолчид өдөр тутмын амьдралаас бидний анзаардаггүй гэм дутагдлыг тодруулан гаргадаг (Свифтын «Гулливерын аялал» М. Салтыков-Щедриний «Нэгэн хотын түүх» г. м.).

Утга зохиолын бүхий л арга читлэлийн зохиолчдын бүтээл уран зөgnөlөөр баялаг юм. XX зууны уран зохиолд А. Франс, Г. Уэлс, Ф. Кафка, К. Чапек, А. Грин, М. Булгаков тэргүүтэй олон зохиолч уран зөgnөлийн олон сайхан дүр бүтээжээ.

**Фельетон**—шог найруулал. Төлөв сонин, сэтгүүлд гардаг уран нийтлэлийн нэгэн зүйл. XIX зууны эхэн үеэр бий болжээ. Уран сайхан-нийтлэлийн төрөл зүйл болохын хувьд шог найруулал нь өнөөгийн тулгамдмал асуудлыг хөдөлгөөнгүй баримтад тултуурлан уран дурслэлээр чимж үзүүлдэг. Шог найруулалд шоглох чиглэл давамгайлна.

**Фигура стилистическая**—найруулгын ур маяг. Энэ нь зохиолчийн хэлийг яруу сайхан болгож байгаа, ердийн ярианыхаас арай өөр хэллэгийг хэлнэ. Найруулгын ур маягт давталт, тонгоруулал, уран асуулт, солбицол, дүрслэг хэллэг, холбоос олшруулах, угтээх ёс сэлт хамаарна.

**Фигурные стихи**—хэвт шүлэг. Энэ нь мөрүүдийн байрлал юм уу мөрүүдэд ялган тэмдэглэсэн үсгүүд нь ямар нэг юмны дурс үүсгэхээр бодож бичсэн шүлгийг хэлнэ.

**Филология**—хэл бичгийн ухаан. Хэл шинжлэл, утга зохиол судлал хоёулыг баатасан ухагдахуун.

**Фольклор**—ардын аман зохол, ардын билэг. Ард түмний аж байдлын уламжлал болсон олон түмний үгийн уран бүтээлийн зүйл, хэлбэрүүдийн нийлбэр цогц.

Үгийн уран бүтээлийн нэн эртний хэлбэр хүний хэмжийн бүрэлдэх явцад, барагцаагаар хуучийн чулууны дээд үед бий болжээ. Анги үүсэхийн өмнөх нийгэмд уран бүтээл амаар дамжин хөгждөг байсан бөгөөд энд уг нь хөгжим, бүжигтэй хосолдог байв. Энэ шатанд яруу найраг хөдөлмөртэй нягт холбогдон хүний үүсгэвэр мэдлэг, шашин, домог-улгэр, түүхийн төсөөллийг тусгадаг байв. Цаашдаа нийгмийн анги давхартын ялгарлыг тусгасан аман зохиолын олон зүйл, хэлбэр үүсв. Аман яруу найргийн хөгжилд хөдөлмөрчин ард түмний уран бүтээл нэн чухал үүрэг гүйцэтгэжээ. Бичиг бий болмогц утга зохиол үүсв. Аман зохиол бичгийн утга зохиолтой зэрэгцээ хөгжиж, ард түмний гоо зүйн хэрэгцээг удаан хугацаанд хангасаар иржээ.

Аман зохиол бичгийн зохиол хоёр анхнаасаа нягт барилдлага шүтэлцээтэй байсан бөгөөд орчин үеийн утга зохиолд ч аман зохиолын нелөө холбогдол баагүй байна.

**Формализм** — формализм, хэлбэрдэл 1. Утга зохиол, урлаг дахь хэлбэрдэх хандлага гэдэг бол хэлбэрийг эрхэмлэх (заримдаа агууллыг хохиродог) чиглэл юм. Хэлбэрийг шүтэгчид зохиолын үзэл санаа, дэвшүүлсэн асуудал бол тохиолдлын шинжтэй, зохиолын уран сайхны чансаанд нелөөгүй, уран зохиолоос ангид зүйл гэж үздэг. Тэдний бодлоор бол харин уран сайхан хэлбэр нь уран бүтээлийн цорын ганц зорилт мөн бөгөөд хэлбэр хичнээн чамин байх тусмаа зохиолчийн авьяас төчнөөн дээгүүр үнэлэгддэг ажээ. Нийгэмд үзэл санааны салбарыг хамарсан ядуурал гарч нийгмийн уналт бууралт болсон үед хэлбэрдэх чиг хандлага гарч ирдэг юм.

2. Утга зохиол шинжлэл дэх формализм (хэлбэрийн сургууль) гэж бас бий. Энэ бол урлат дахь хэлбэрдэх онолын үндэслэл юм. Хэлбэрийн сургууль XX зууны эхээр үүсч, 1917 оны хувьсгалын дараа онцгой учир холбогдолтой болжээ. Энэ сургуулийн хан хувьсгалт ардчилсан шүүмжлэлийн уламжлалыг эсэргүүцдэг байв. Тэдний бодлоор бол утга зохиол шинжээч хүн зохиолын үзэл санааны агуулга, түүнийг нийгэм нөхцөлдүүлсэн байдлыг судлах биш, харин зөвхөн хэлбэрийн өвөрмөц онцлогийг л судлах ёстой ажээ.

Хэлбэрийг агуулгаас салган судлах нь үр дүнгүй юм. Ийм судалгаа уран сайхны элдэв «хэрэглүүрийг» тоочин тодорхойлох, ангилахаас хэтэрдэггүй байв.

Хэлбэрдэх онолын зөрчлийг энэ ёсны олон үзэл сурталчид яваандаа ойлгож татгалзсан юм. (Жирмунский, Н. Томашевский, Б. Эйхенбаум г. м.).

**Футуризм**—футуризм. 1. 1909 онд Италид бий болсон утга зохиолын урсгал (чиглэл), Толгойлогч нь Маринетти. Энэ урсгал яруу найрагт хэлбэр хөөцөлдсөн шинэчлэл хийхийг номлож (уг яриаг өгүүлбэр зүйн журмаар зохион байгуулахаас татгалзах, зохиолын эхэнд нот, математикийн томъёо тэмдэг тэргүүтэн хэл-

ний бус хэлбэрийн зүйлс нэзвтрүүлэх г. м.) байсан бөгөөд тэгэх дээ эл уриалгын нь цаана хүмүүнлэг бус агуулга нуугдаж байсан нь уг урсталин зарим төлөөлөгчийг хожим фашист дэглэмийн талд оруулжээ.

2. 1910 онд Орос оронд үүссэн утга зохиол, уран зургийн урсгал (1913 онд футуризм нэртэй болжээ). Энэ нь зарим талаар италийн урсгалтай төстэй (өнгөрсөн үеийн соёлыг угүйсгэх, хэлний шинэ шинэ хэлбэр эрэлхийлэх г. м.) боловч утгаа түүнээс их хол хөндий байв.

**Характер литературный**—уран зохиол дахь зан чанар. Уран зохиол дахь хувийн тодорхой зан чанар бүхий хүний дүр. Уран сайхны зан чанар бол давтагдатч ерөнхий ба давтагдашгүй бодгаль зүйлс; объектив (уран зохиолд тухайн зан чанарыг бүтээхэд эх дүр болсон хүний ёмьдралын нийгэм-сэтгэлзүйн бодит байдал) ба субъектив зүйлсийн (эх дурийн утга учрыг зохиолч нээж хуруулсан нь) амьд нэгдэл мөн. Ийнхүү урлагт дурслэгдсэн ху зан чанар гэдэг нь уран сайхны аргаар бүтээсэн «хувь хүн» юм.

Олон талтай, хөгжил хөдөлгөөнтэй зан чанарыг үзүүлэх нь уран зохиолын өвөрмөц шинж болно. Зан чанар гэсэн ойлголт эртний Грект бүрэлдэн төлөвшжээ.

Гэвч эртний хүмүүс зан чанарыг орчин үеийнхнээс өөрөөр ойлгож байв. Үзэл санааны агуулгыг нээн гаргахад үйл явдал (өгүүлэгдэхүүн) голлодог байсан тул баатрууд дав дээр зан чанараараа биш, харин дурслэгдэн буй үйл явдалд гүйцэтгэх үүргээрээ ялгардаг байв. Шинэ уед зан чанар, өгүүлэгдэхүүн хоёрын харьцаа өөр болов. Баатрын зан чанар нь тодорхой нөхцөлүүдэд түүний юу хийх, яхыг тодорхойлох болжээ.

**Характеристика речевая**—яриагаар тодорхойлох ёс гэдэг нь зохиолын баатрын өөрийн нь уг яриагаар түүний зан чанарын бусдаас ялгараах онцлог шинж, мөн соёлын төвшин, нийгмийн аль нэг тодорхой давхраа бүлэгт хамарагддагийг нь илрүүлэх аргыг хэлнэ.

**Хиазм**—солбицол. Ижил төстэй хэсгүүдийг солбицуулан буюу АВ-В<sup>1</sup>А<sup>1</sup> гэсэн дарааллаар байрлуулсан зэрэгцүүлэл. Жишээ нь:

Хийвэл бүү ай

Айвал бүү хий (цэцэн уг).

Дайн

Хүнгүй тэр

Гэргүй хүн

Дайн

Хөлгүй бие

Биегүй хөл (Д. Гомбожав «Дайн»,

Хорей (трехей)-хорей (трехей), бүжил өлмий. Уртатгалын

шүлэгт нэг урт, нэг бодино үеэр, үе-өргөлтийн шүлэгт бол нэг өргөлттэй, нэг өргөлтгүй үеэр бүтсэн өлмий.

### Хромос протос—үзье Мора.

Цезура—нугалбар, Монголоо үүнийг бас цэглэл ч гэнэ. Шүлгийн мөрийг хоёр (юм уу хааяа гурав) хураасан шадын дундах зогсожийлт. Шүлгийн хөгийг ялгаруулж, урт шадыг илүү тод айзамтай болгоно.

Цикл—мечлөг. Сэдэв, материал, баатрууд, уг санаа зэрэг ямар нэг нийтлэг зүйлээр өөр хоорондоо ҳолбогдсон хэсэг зохиолыг мечлөг зохиол гэнэ (Д. Нацагдоржийн эрүүл энхийн сэдэвт шүлгүүд). Ийм мечлөг бас аман зохиолд байдаг (Далан худалчийн яриа, Жангарын тууль).

Эвфемизм—эерүүлэл. Бүдүүлэг, зохисгүй, эрс тэс юм уу халуун нялүүн үг, хэллэгийг орлуулсан эелдэг зөвлөн үг, хэллэг (худал хэлэх гэхийг дэгс ярих, ухэх гэхийг амьсгах хураах, г. м.)

Эвфония—эгшиглэл зүй. Шүлэг зохиолд сэтгэл хөдлөлийн тодорхой өнгө оруулдаг хэлний авианы чанарын талыг судалдаг туурвилзүйн нэг хэсэг, яруу эгшигийн тухай сургаал. Шүлгийн айзам, холбоц, эхэн, сүүл ижилсгэх, эгшиг гийгуулэгч давтах тэргүүтэн найруулгын олон арга эгшиглэл зүйд ҳолбогдоно. Эгшиглэл зүй нь авианы үзэгдэл болохын хувьд яруу найраг, үргэлжилсэн үгийн зохиолд аль алинд нь адилхан хамаатай.

Эзопов язык—ёгт хэл. Ёгт үгс, тойруулал, нууц нэр, учир битүүлэгт хэллэг, егөөдлийг өргөн ашигласан уран сайхны хэл. Үгчлэн орчуулбал Эзопын хэл гэсэн энэ нэр томъёо МЭӨ VI зууны үеийн грекийн яруу найрагч Эзопын домогт дүрээс үндэстэй юм. Домогт хгүүлснээр бол боол гаралтай Эзоп орчин үеийнхээ тухай үнэнийг хэлэхийн тул адгуус амьтан, жигууртэн шувууны ёгт дүрийг бүтээхээс өөр аргагүй байжээ. Цаашдаа ийм ёгт хэл шоглол зохиолд өргөн хэрэглэгдэх болжээ. Утга зохиолыг хянах хатуу чандлагын нөхцөлд олон орны зохиолч нийтлэл, уран бүтээлдээ ёгт хэлийг ихээхэн ашигладаг байв. Ёгт хэл бол шогломын хэлний нэг өвөрмөц хэлбэр мөн.

Экранизация—дэлгэцийн болгох. Уран зохиолын аль нэг бүтээлийг ашиглан кино юмуу телевизийн кино хийх. Кино урлаг бүр үүсэхээсээ Дефогийн «Робинзон Крузо», Свифтийн «Гулливерын аялал» зэрэг зохиолыг дэлгэцийн болгож байжээ. Өнөөгийн дэлхийн киноны ихэнх нь сонгодог юм уу орчин үеийн өгүүлэг, тууж, роман, жүүжгээр хийсэн бүтээлүүд болж байна. Одоо үеийн кино гэдэг нийтлэг урлаг юм. Кино уран зохиолд үгээр бүтээсэн дүрийг биетэй, хөдөлгөөнтэй, нүдэнд үзэгдэх дур болгон хөрвүүлдэг дурслэн илэрхийлэх өөрийн өвөрмөц бөгөөд баялаг арга хэрэглүүртэй болжээ.

Экспозиция—өмнөтгөл. Зохиолын үйл явдал эхлэхийн өмнөх баатруудын байдал, тэдний амьдарч агсан орчин нөхцөлийг дүг-

НЭСЭН ХЭСЭГ. Энэ хэсэг нь угтэй юмуу дэлгэрэнгүй дүрслэлтэй ч байж болдог. Өмнөтгөл нь зохиолд гарах хүмүүсийн ааш зан үйл ажиллагааны уг сурвалжийг түнзгий ухаарахад дөхөм үзүүлнэ.

**Экспрессионизм**—экспрессионизм. XX зууны 10-аад оны утга зохиол, урлаг дахь авангардист урсгалын нэг. Экспрессионизм нь реализм болон XIX зууны сүүлч үеийн реалист бус урлагийн зарим хэлбэрийн (жишээ нь, натурализм, импрессионизм) эсрэг өөрийгөө сөргүүлэн тавьж, юны өмнө уран бүтээлчийн хувийн сэтгэл, оюуны ертөнцийг хурцаар гаргахыг эрмэлзэж байв. Экспрессионизм нь бодит байдлыг шууд дүрслэхээс зайлсхийж, гол зүйл бол зохиогчийн субъектив төсөөллийг илэрхийлэх явдал гэж тунхаглаж, дүрслэлийг илэрхийлээр сольжээ. Тийм учраас ийм утга зохиолын гол төрөл зүйл нь уянгын яруу найраг ба зохиогчийн оргилуун бодмоглол (монолог)-оор дүүрэн нийтлэлийн жуужиг хоёр байв. Энэ чиглэлийн гүн ухааны үндэс нь Бергсон, Гуссерль, Фрейд нарын дэвшүүлсэн онол юм.

Экспрессионизм Германд хамгийн их дэлгэрч, уран зураг театрт кино, утга зохиол тэргүүтэн урлагийн нэн чухал бүх салбарыг хамран хөгжжээ. Нэрд гарсан экспрессионистуудын тоонд Х. Бехер, Э. Толлер, Л. Франк нар орно.

**Элегия**—гүниглалт шүлэг. Уянгын зохиолын нэгэн хэлбэр. Эртний Грект МЭӨ VI зууны үед янз бүрийн сэдвээр бичсэн хоёр мөрт шулгийн хэлбэрээр үүсчээ. Европын шинэ утга зохиолд хэлбэр нь тодорхой биш болсон боловч агуулга нь тогтвортой, их төлөв гүнигтай бодол, гансрал, гүн ухааны эргэцүүллийг илэрхийлэх болжээ.

**Эллипсис**—гээлт. Өгүүлбэрийн байвал зохих аль нэг гишүүнийг гээх найруулгын ур маяг. Гээлтийг ашиглах нь хэлсэн зүйлээ чангаруулж, амьд ярианы аялгатай, уран яруу болгох ач холбогдолтой.

«Нойирноос морио»

Чөмөгнөөс хутгаа (өгөх)

«Ажил хийвэл дуустал

Давс хийвэл уудтал (хий)»

«Хүний хуучин нь

Дээлний шинэ нь (дээр)»

(Цэцэн угс)

Бөртэ-үжиний үгийг зөвшөөж үл буун шене турш явж зуур мөрт тайчуудыг дайрав. (Монголын нууц товчоо)

Хэдэн өдөр хүүхдүүдийн хувцсыг цэвэрлэж эзгийн нь уранхай дээл хувцасны хуулгыг угаан гурван багад нь нэг бүтэн одогор дээл оёж өглөө. (С. Удвал, «Ховор хүн»)

Дээр иш татсан цэцэн үгст өгүүлэхүүн нь алга боловч утга нь ойлгогдож байхад сүүлчийн хоёр өгүүлбэрт өгүүлэгдэхүүн нь

байхгүй хэр нь зохиолыг уншиж байгаа хүнд үйлийн эээн хэн болох нь урьд хойно өгүүлсэн зүйлсээс тодорхой байна.

**Эпигонство**—хоосон дуурайлт гэж утга зохиолын ямар нэг чиглэл, төрөл зүйл, найруулга, бодгаль маягийг бутээлч бишээр дуурайхыг хэлнэ.

**Эпиграф**—эшэлбэр бичээс. Эртний грек, ромд ямарваа биет зүйлд зориулан түүн дээр тухайлбал булшны хөшөөн дээр бичсэн бичээсийг хэлдэг байв. Шинэ үед бол уран зохиолын эхэнд бичсэн зохиолчийн уг санааг нээх, дүрслэгдсэн үйл явдалд зохиолчийн үнэлэлтийг өгөх зорилго бүхий цэцэн уг, эшлэлийг ийнхүү нэрлэх болжээ.

**Эпилог**—төгсвер. Зохиолд дурсэлсэн бүх явдлаас хойш баатруудын хувь заяа юу болсныг өгүүлсэн (Жужиг, романы) төгсголлийн хэсэг.

**Эпистолярная форма**—захидлын хэлбэр. Баатрууд нь захидлаар харилцаж байгаа хэлбэрээр бичсэн зохиол. Ийм төрлийн зохиол бүр эртний грек, ромд байв (Эпикур, Цицерон, Горация). Сүүлдээ энэ хэлбэр хөгжсөөр уран зохиолын нэлээд зүйл, түүний дотор роман, туужид ч дэлгэрчээ. Монголын хуучин төвд хэлт утга зохиолд захиа бичиг (брин-ег) гэсэн нэг зүйл байсан нь үүнтэй төстэй юм. Орчин үеийн манай утга зохиолд Д. Пурревдоржийн «Сэрг цагаан богд», «Хүүгийн эцэгт бичсэн захидал» найрагал зэрэг нэлээд ясоны захидлын хэлбэртэй бутээл гарчээ. Мөн томоохон зутгэлтний түүх, соёлын холбогдолтой хувийн захиа бичиг ийм хэлбэрийн утга зохиолд хамарагдана.

**Эпитет**—чимэг уг. Юмыг дүрслэн тодорхойлсон нэгэн зүйл тодотгол. Гэхдээ ерийн тодотгол тухайн юмыг бусад олон юнаас ялгадаг байхад чимэг уг нь уг юмын аль нэг шинжийг төвийлгөн гаргасан (намрын мөнгөн өглөө) юмуу эсвэл өөр юмны шинжийг түүнд шилжүүлж хэрэглэсэн (шивнэх навчис) байдаг. Ардын аман зохиолд байнгын чимэг уг (алтан нар, мөнгөн сар) их тохиолддог.

**Эпифора** (буюу концовка)—сүүл ижилстэл. Уг илэрхийллийг залгаагаар орсон өгүүлбэр, шүлгийн мөрийн ард давтахыг хэлнэ. Энэ нь эхэн ижилсгэл (анафора)-ийн эсрэг байдалтай найруулгын нэг ур маяг юм.

Царсны навчийг шарлаад байхад  
Нарсны мөчир ногоороод байдаг  
Цагаан хусыг хатаад байхад  
Цармын арц нойтон байдаг  
Хээрийн ногоог хуурай байхад  
Хэцийн зээргэнэ сөлтэй байдаг  
Дэлхийн ургамлыг нойсож байхад  
Дээрх гурав сэргэг байдаг

(Ц. Дамдинсүрэн «Царсны навчийг»)

Галт тэрэг дорно зүг яарна  
Газар дэлхий баруун тийшээ зөрнө  
Уул, ус, ой, мод зөрнө  
Уужим тал, хот, тосгод зөрнө  
Утасны шонгууд  
Тэнгэрийн наран  
Байгаль ертөнц буйгаараа  
Баруун тийшээ зөрнө

(Д. Нямаа «Өглөөний наран айсий»)

**Эпонея**—их тууль. Туульсын зохиолын хамгийн том зүйл. Эртний их тууль ба хүүрнэл зохиолын нэгэн зүйл болох их тууль гэж ангилж үзнэ. Эртний их тууль (баатарлагийн туульс) нь нийт ард түмний эрх ашгийг илэрхийлсэн баатарлаг явдлыг голцуу дурсэлсэн байдал. Эртний грекийн «Илиада», «Одиссея», Энэтхэгийн «Махабхараты», Карел-Финий «Калевала» зэрэг нь их туульс болно.

Орчин үед өргөн их үйл явдлыг дурсэлж, олон хүмүүс гардаг романыг их тууль гэж нэрлэж байна. Үүнд Л. Толстойн «Дайн ба энх», Ж. Голсуорсийн «Форсайтын тууль», М. Шолоховын «Дөлгөөн дон»-ыг хамааруулж болно.

**Эпос**—тууль. 1. Уран зохиолын гурван төрлийн нэг (нөгөө хоёр нь: уянга, жүжиг). Туульсын зохиол нь их төлөв хөндлөнгийн явдлыг хүүрнэн өгүүлсэн байдал.

Дурсэлсэн цаг хугацаа, хамарсан үйл явдлын нь хэмжээ хэрээс хамааран туульсын том, дундаж, бага (буюу бэсрэг) хэлбэр гэж ялгадаг. Том хэлбэрт нь их тууль, дундаж хэлбэрт нь тууж, бага хэлбэрт нь туурь, өгүүллэг багтана. Хүүрнэл зохиолын нэг онцгой хэлбэр бол найруулал юм. Найруулал нь хэмжээгээрээ яң бүр байх тул туульсын зохиолын бага, дундаж, тэр байтугай том хэлбэртэй ч төстэй байх нь бий.

2. Явцуу утгаар бол шулэг, үргэлжилсэн үгээр байдаг ардын аман зохиолын нэг өвөрмөц зүйл болох тууль буюу баатарлаг тууль. Ийм туульс их төлөв амаар уламжилж ирсэн боловч бас бичгээр үлдсэн гайхамшигт дурсгалууд дэлхийн улс түмэнд цөөнгүй бий. Монголын ихэнх туулийг мэргэжлийн туульчид товшуурдан хайлж ирсний дээр бас «Хан харангуй», «Гэсэр» мэтийн зарим тууль бичгээр тэмдэглэгдэж буюу бичгээр боловсруулагдан үлдсэн байна.

Ардын баатарлаг тууль (домог-улгэр, баатарлаг үлгэр, хожим нь тухайн хууч үг, домгийн уламжлал дээр) анхны хүй нэгдлийн байгуулал задрах үед үүсч эртний ба феодалын нийгэмд эзгийн эрхт ёсны харилцаа, төсөөлөл хагас заримдаг хадгалагдаж байсан нөхцөлд хөгжжээ. Туульс дахь туйлын хүслэнгийн үндэс нь анхны хүй нэгдлийн үеийн өзвөр ёсны хэм хэмжээг дурсан санагалзах явдал юм.

Туулийн анхны хуучин хэлбэр нь балар эртний домог-улгэрийн хэл, үзлийг ашигласан, түүнд гарах баатарлаг явдал нь үлгэр ба домог-улгэрийн хальсан бүрхэвчтэй байдаг. Жишээ нь турк, монголын баатарлаг туульс, нартын туульс зэргийг нэрлэж болно. Ийм туулийн гол сэдэв нь мангас махчинтай тулалдсан, заяаны хания баатрын ёсоор олж авсан, овгийн (эцгийн) ёшоот авсан явдлууд байдаг.

Нэн эртний туулийн ийм хуучин хэлбэрийн дараа, үндэстний төр бэхжих нөхцөлд түүхэн домогт үндэслэн туулийн сонгодог хэлбэр болох түүхэн баатарлаг тууль гарчээ. Энэ хэлбэрийн туульд домог-улгэрийн зүйл мартагдан гээгдэх хандлагатай байдаг. Баатрууд нь түүхэн үндэстэн, ястныг төлөөлдөг бөгөөд дайснууд нь их төлөв түүхт байлдан эзлэгчид, харийн, тэрс номт дарлан мөлжигчидтэй адил байдаг. Туулийн цаг нь эртний тууль дахь шиг ертөнц анх бүтэх домог-улгэрийн үе биш, харин үндэсний түүхийн эхэнд хамаарах урьдын сайхан үе байдаг. Гэхдээ туулийн түүхэн зүйг яг угчлэн ухаарч болохгүй. Тууль дахь эртний төр улсын байгууллууд нь (Оросын тууль дахь Владимир вангиин толгойлсон Киевийн улс, монгол «Жангар» дахь дөрвөн ойрд г. м.) өнгөрсөн үе рүүгээ хандсан үндэсний ба нийгмийн үл гүйцэлдэх мөрөөдөл юм. Сонгодог хэлбэрийн туульд түүхэн (буюу зохиомол түүхэн) хүн, үйл явдлыг магтан дуулах боловч түүхт үзэгдэл, юмыг дурслэхдээ өгүүлэгдэхүүний уламжлалт буудувч хэвд захирагдана. Заримдаа ёслол, домог-улгэрийн загварыг ашиглана.

Туульсын хамгийн сүүлийн түүхэн хэлбэр нь аман туульсын уламжлал яруу найрагчдын хувийн уран бүтээлтэй нэгдсэнд дунд үүсчээ. Жишээ нь Персийн Фирдоусийн «Шахнамэ», Гуржийн Шота Руставелийн «Барсан хэвнэгт баатар», төвд, монгол нэр нь үл мэдэгдэх зохиолчдын «Гэсэрийн тууж»-ийн бичгийн хувилбарууд г. м.

Ардын туульс дэлхийн бүх улс түмний утга зохиолын хөгжилд их нөлөөлжээ. Яруу найратгчдын хувьд туульс нь жинхэнэ үндэсний хөрс суурин дээр уран тансаг бүтээл туурвихын жишээ болсоор байна.

Эссе—эрэгцуулэмж гэдэг нь нэгэн зүйлийн найруулал. Энэ найруулалд баримтыг өгүүлэх нь биш, харин сэтгэгдэл, эргэцүүлэл, бодлыг дурслэх явдал гол үүрэг гүйцэтгэнэ. Эргэцүүлэмж XVI—XVII зууны зааг дээр үүсэж европын утга зохиолд, ялангуяа Английн утга зохиолд их дэлгэрчээ. Эргэцүүлэмжийн хэл найруулга ярианы хэлэнд ойр, уран, цэцэн байдаг. Гүн ухааны, уран зохиолын шүүмжлэлийн, түүх намтрин, нийтлэлийн мөн цэвэр, уран зохиолын шинжтэй эргэцүүлэмж байдаг.

Эргэцүүлэмжийн хатуу чанд цэгц тортолцостой өгүүлэх, дүг-

нэлтийг нотлохыг онц чармайлтгүй асуудлыг чөлөөтэй субъектийг байдаа тайлбарласан байдаг.

**Юмор**—хошигнол. Инээдмийн нэг онцгой хэлбэр, хошигнол нь нөхөрсөг наргиан мөн боловч бас дутагдлын эзнийг хэр тааруу «чимхээд» авдаг байна. Хэрэв шоглол нь (сатира) шоолж буй узэгдлээ үндсээр нь буруушааж, түүнд туйлын хүслэнг сөр гүүлэн тавьдаг бол хошигнол нь өөрийн шоолж байгаа зүйлээ туйлын хүслэнтэй үл харшилах талуудыг олж хардаг учир түүний шуумжилсэн зүйл нь нудэнд дулаахан, сэтгэлд зөвэргүү шинжээ хадгалааар байдаг.

**Явление**—узэгдэл. Жүжгийн зохиолын бүлгийн нэг хэсэг Узэгдэл нь тайлан дээр гарч байгаа баатруудын бүрэлдэхүүн өөрчлөгдтэл, өөрөөр хэлбэл хэн нэг нь явах буюу, шинэ хүн иртэх хугацаанд үргэлжилнэ.

**Язык художественной литературы**—уран зохиолын хэл гэдэг бол уран зохиолд уран дурийт амьдруулах үндсэн хэрэглүүр мөн. Уран зохиолын хэлний өвөрмөц тал нь хүний амьдралын янз бүрийн учрал тохиол, бодгаль хэлбэрийг дурслэгч зохиолчийн зорилтоор тодорхойлогдоно. Хэлний найруулгыг агуулга талаас нь шинжлэх ухааны, албан хэргийн, ярианы гэхчлэн хатуу ангилдаг бол зохиолч хүн энэ бух ангилмын найруулгыг аль алиныг нь эзэмшиж, амьдралын тухай тухайн салбарыг дурслэхдээ ашиглан тэдгээр салбарын төлөөлөгчдийн хэл ярианы онцлог, хүмүүс ар гэртээ, ажил дээрээ, наиз нөхөдтэйгээ харилцахдаа гэхчлэн өөр өөр орчинд яаж ярьж байгаа онцлогийг харуулах шаардлагатай байдаг. Иймээс уран зохиолын хэл нь нэг ёсны нийлэг шинжтэй юм. Уран зохиолд бие хүнийг өөрийн гэсэн зан чанартай, хэл яриа нь хүртэл бусдаас ялгарах өвөрмөц бодгаль байдалтайгаар дурсэлдэг тул уран зохиолын хэл нь бодгальжсан баатруудыг хэл ярианы онцлогоор нь ялгаруулагч нэг зүйл, уран сайхны хэрэглүүр болдог. Үүний хамтаар зохиолын баатрууд, тэдний амьдралын орчин нөхцөлийг зохиолч өөрийн угзэр дурсэлдэг. Зохиолчийн баатрууддаа хандах хандлага түүний угзэр илрэх бөгөөд тэр хандлага нь баходсан, угүйгэсэн, шоглосон янз янзын өнгө хөгтэй байдаг.

Туунчлэн зохиолын төрөл тус бүрийн хэл нь өөр өөр хэлбэртэй. Жүжигт бол зохиогчийн үг хэрэг дээрээ байдаггүй, зохиолчийн унэлэлт зөвхөн баатруудын явдал, харилсан яриагаар илэрдэг. Хүүрнэл зохиолд бол баатруудын яриа зохиолчийн угтэй хосолсон байдаг. Уянгын зохиолд бол их төлөв бодгаль хэл бэрээр хувийн, сэтгэлийн хөдөлгөөнөө уянгын баатар өөрөө илэрхийлнэ.

Уран зохиолын хэл нь найруулгын олон хэлбэрийг багтаадаа учраас ашиглах хэлний эх сурвалж нь баялаг байна (Хуучирсан

үг, шинэ үг, хар ярианы үг, нутгийн аялгууны үг, гадаад хэлний үг г. м.). Дүрслэгдэхүүнээ үнэлэх, бодгальжуулах зорилгоор уран зохиолын хэлэнд дүрслэг үг; найруулгын янз янзын ур маягийг хэрэглэдэг.

**Ямб**—дэвхцэл өлмий. Өргөлт нь (уртатгалын шүлэгт бол урт үе нь) дандаа тэгш үе дээр (2, 4, 6, 8-р үе г. м) таардаг хоёр үет хэмжээ. Тэгэхдээ байх ёстой газраа өргөлтгүй байх нь олонтаа.

**Д. ЕНДОН**

**ОРОС—МОНГОЛ УРАН ЗОХИОЛЫН  
НЭР ТОМЬЕОНЫ ТОВЧ ТАЙЛБАР  
ТОЛЬ**

Редактор Д. Шархүү  
Техник редактор А. Сожилмаа

Өрөлтөнд 1995 оны 5 сард орж, 1995 оны 7 сард 500 хувь хэвлэв.  
Цаасны хэмжээ 60x841.16 хх 5.75 Зa№15—95

ШУХЭВЛЭЛИЙН «Эрдэм» компани  
Нэгдсэн Үндэстний гудамж—19. Улаанбаатар—46.